



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-9
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	10-69

1.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах” тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/	10-36
2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газрын 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	36-46
3.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	46
4.“Зээлийн хүүг бууруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	46-59
5.”Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал нарын 89 гишүүн 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/	60-64
6.Монгол Улсын дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц, тайлагналтын талаар Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээллийг сонсох	64-69

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 06 дугаар сарын 30-ны өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 35 минутад Төрийн ордны “Жанжин Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Р.Сэддорж, Х.Баттулга;
Чөлөөтэй: А.Ундраа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу хэлэлцэх асуудлын 7 дугаарт байгаа Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээлэл сонсох асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлын дарааллаас хасах гэсэн горимын санал гаргав.

Ч.Лодойсамбуу: Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	5
Татгалзсан	10
Бүгд	15

33.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн хэлэлцэх асуудлын дарааллын 6 дугаарт байгаа Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх асуудлын дарааллаас хасах горимын санал гаргав.

Ч.Лодойсамбуу: Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	8
Татгалзсан	7
Бүгд	15

53.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах” тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд

Г.Дамдинням, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрэм, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Э.Батболд, Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ө.Өнөрнасан, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газрын дарга З.Туяа, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Батбаяр, Санхүүгийн хэлтсийн дарга Т.Сумъяа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Төмөрхүү, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Ариунсанаа, Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын Орон сууцжуулалтын хэлтсийн дарга Э.Батболд, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга бөгөөд Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ерэн-Өлзий, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Баясгалан, тус газрын Санхүү бүртгэлийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч Д.Гүндсамбуу, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг, “МИАТ” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Мөнхтамир, Иргэний нисэхийн ерөнхий газрын Нислэгийн стандартын газрын дарга Ц.Бат, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, мөн яамны харьяа Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн газрын дарга А.Баярбаатар, Шинжлэх ухаан, технологийн сангийн Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Л.Энхтунгалаг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Үндэсний статистикийн хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Төмөрхуяг, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Д.Оюунцэцэг, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Нэгдсэн стратеги, санхүүгийн удирдлагын газрын дарга Б.Батбаяр, “Эрдэнэс Тавантолгой” ХХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, Санхүүгийн зохицуулах хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга Б.Нансалмаа, мөн хорооны Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагва, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга Ч.Тавинжил, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төрийн сангийн газрын Төлбөр, тооцооны хэлтсийн дарга Н.Саруул, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн Т.Сайхантөгс, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер П.Чанцалдулам, Б.Долгорсүрэн, Д.Эрдэнэцэцэг, Д.Энхдалай, С.Нацагдорж, А.Цогбаяр, В.Эрдэнэцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төсвийн гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, М.Мандхай, Б.Жаргалан, Ж.Алдаржавхлан, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Г.Лувсанжамц нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газрын 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Э.Батболд, Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ө.Өнөрнасан, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газрын дарга З.Туяа, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Батбаяр, Санхүүгийн хэлтсийн дарга Т.Сумъяа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Төмөрхүү, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Ариунсанаа, Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын Орон сууцжуулалтын хэлтсийн дарга Э.Батболд, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга бөгөөд Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ерэн-Өлзий, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, мөн яамны

Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Баясгалан, тус газрын Санхүү бүртгэлийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч Д.Гүндсамбуу, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, “МИАТ” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Мөнхтамир, Иргэний нисэхийн ерөнхий газрын Нислэгийн стандартын газрын дарга Ц.Бат, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, мөн яамны харьяа Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн газрын дарга А.Баярбаатар, Шинжлэх ухаан, технологийн сангийн Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Л.Энхтунгалаг, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Д.Оюунцэцэг, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Нэгдсэн стратеги, санхүүгийн удирдлагын газрын дарга Б.Батбаяр, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, Санхүүгийн зохицуулах хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга Б.Нансалмаа, мөн хорооны Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагва, мөн хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Төмөрхуяг, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга Ч.Тавинжил, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төрийн сангийн газрын Төлбөр, тооцооны хэлтсийн дарга Н.Саруул, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн Т.Сайхантөгс, Үндэсний аудитын газрын Санхүүнийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер П.Чанцалдулам, Б.Долгорсүрэн, Д.Эрдэнэцэцэг, Д.Энхдалай, С.Нацагдорж, А.Цогбаяр, В.Эрдэнэцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт С.Төрмөнх, Ч.Сарантуяа нар байлцав.

Хуулийн төслүүдийн талаарх хууль санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг мэдэгдэв.

Хууль санаачлагч болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, П.Сайнзориг, Д.Пүрэвдаваа нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

И.Батхүү, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Жавхланбаатар, мөн яамны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ө.Өнөрнасан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.“Зээлийн хүүг бууруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, мөн хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн, Хууль эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалтын газрын референт Д.Мөнхтуяа, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Ч.Сарантуяа нар байлцав.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, П.Сайнзориг, С.Эрдэнэбат, Н.Батсүмбэрэл нарын тавьсан асуултад Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц нар хариулж, тайлбар хийв.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу “Зээлийн хүүг бууруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Л.Соронзонболд дээрх тогтоолын төсөлтэй холбогдуулан Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн саналуудад тайлбар хийж, Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван Монголбанкны гаргасан саналаа тайлбарлав.

Ч.Лодойсамбуу: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэгт заасныг үндэслэн “Зээлийн хүүг бууруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 14
Татгалзсан 4
Бүгд 18
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Тав.”Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал нарын 89 гишүүн 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалтын газрын референт Д.Мөнхтуяа нар байлцав.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг, Улсын Их Хурал дахь Хүн намын зөвлөл, Үндэсний эвслээс түр хорооны бүрэлдэхүүнд оруулах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж өгөхийг хүссэн санал ирүүлснийг тус тус танилцуулав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд тайлбар хийв.

Ч.Лодойсамбуу: “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	13
Татгалзсан	5
Бүгд	18

72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц, тайлагналтын талаар Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалтын газрын референт Д.Мөнхтуяа, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Ч.Сарантуяа нар байлцав.

Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү Монгол Улсын дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц, тайлагналтын талаар мэдээлэл хийв.

Мэдээллийг сонссонтой холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн Байнгын хорооны тогтоол гаргах горимын санал гаргав.

Ч.Лодойсамбуу: Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	13
Татгалзсан	5
Бүгд	18

72.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан Байнгын хорооны тогтоолын төслийг дараагийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх горимын санал гаргав.

Ч.Лодойсамбуу: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 12

Татгалзсан 6

Бүгд 18

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Монгол Улсын дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц, тайлагналтын талаар Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээллийг сонслоо.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 29 минут үргэлжилж, 25 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 88.0 хувийн ирцтэйгээр 19 цаг 04 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр,
Даваа гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхимд 15 цаг 35 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ч.Лодойсамбуу: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Эдийн засгийн байнгын хорооны ээлжит хурал эхэлж байна. Өнөөдөр хэлэлцэх асуудлыг, гишүүдийнхээ ирцийг танилцуулъя. Байнгын хорооны хурал 56 хувийн ирцтэйгээр эхэлж байна.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн ирсэн байна, Шинэбаярын Бямбасүрэн гишүүн ирсэн байна, Ганзоригийн Лувсанжамц гишүүн ирсэн байна, Бадрахын Найдалаа гишүүн, Саруулсайханы Цэнгүүн, Ренчиндоржийн Батболд, Батбаярын Жаргалан, Мэндбаярын Мандхай, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Мөнхчулууны Энхцэцэг, Пүрэвийн Батчимэг, Баатаржавын Мөнхсоёл, Одонгийн Цогтгэрэл, Чулуунбилэгийн Лодойсамбуу нар ирсэн байна аа.

Байнгын хорооны дарга гадаад томилолттой байгаа учраас чөлөөтэй байна. Мөн Халтмаагийн Баттулга гишүүн гадаад томилолттой байна. Ундраа гишүүн мөн чөлөөтэй байна аа. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 56 хувьдаа бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хоёрт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт тухай оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Гуравт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Алт 3 аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Дөрөвт, Зээлийн хүүг бууруулах талаар авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг.

Тавдугаарт, Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал нарын 89 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн асуудлыг хэлэлцэнэ.

Зургадугаарт, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Долоод, Монгол Улсын дунд богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц, тайлагналтын талаар Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээллийг сонсоно.

За ийм 7 асуудлыг өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс тов дараалал баталсан байна.

Үүнээс Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээлэлтэй холбогдуулан Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан цаглаврын дагуу Эдийн засгийн хөгжлийн яамнаас хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдийн хэрэгжилтийг хуульд заасан хугацаанд нь Улсын Их Хурлаар хэлэлцүүлсэн болохоор хэлэлцүүлсэн бөгөөд дараагийн хэрэгжилтээ нэгтгэх, тайлагнах, хуулиар заасан хугацаа хараахан болоогүй байгаа тул хэрэгжилтийн талаар танилцуулах боломжгүй байна гэсэн агуулга бүхий бичиг агуулга бүхий бичиг ирүүлснийг та бүхэнд тараасан байна аа.

Иймээс нэгэнт бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдийн хэрэгжилтийг тайлагнах, танилцуулах асуудлыг холбогдох хуулиар тусгайлан зааж өгсөн учир Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээлэл сонсох асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлын дарааллаас хасах горимын санал гаргаж байна аа. Одоо ингээд горимын саналаар санал хураана аа. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Санал хураалт.

Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээлэл сонсох асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлын дарааллаас хасахыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт.

33.3 хувийн саналаар саяын санал дэмжигдсэнгүй. Ингээд 7 дугаар асуудал хэвээрээ орохоор болж байна аа гэсэн үг ээ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүд байна уу? За Цэнгүүн гишүүний микрофоныг нээе. Цэнгүүн гишүүнээр тасалъя.

С.Цэнгүүн: Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр өнөөдөр бид бүхний хэлэлцэх асуудлын тоонд орсон Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэх эсэхийг дараах одоо зүйлсүүдийг бүрдүүлэхгүй байгаа учраас хэлэлцэх асуудлуудын тооноос хасаж өгөхийг хүсье.

Тэгэхээр 1 дүгээрт бол хууль тогтоомжийн хуулийн 4 дүгээр зүйлд заасан нийтлэг зарчим дээр тэр дотроо ил тод, нээлттэй байх, олон нийтийн оролцоог хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх шаардлагуудыг энэхүү хуулийн төсөл маань бол хангаагүй байгаа.

2 дахь шалтгаан маань бол Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйл хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шат энэний 8.1.5 дахь хэсэгт заасан эрх хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн хуулийн этгээдийн төлөөлөл олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах шаардлагыг хангаагүй

байгаа. Зөвхөн нэг удаа хэлэлцүүлэг хийсэн. Эрх ашиг нь хөндөгдөж байгаа болох этгээдүүдээс нэг ч санал бичгээр бол ирэгдээгүй байгаа.

3 дугаар шалтгаан бол хуулийн төслийг танилцуулгын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.5 дахь хэсэгт гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт гэж заасан харьцуулсан эрх зүйн судалгаа туршлага огт байхгүй. Бусад улс орны эрчим хүчний салбарын мега төслүүдийг ямар хууль эрх зүйн орчноор зохицуулж буйг зайлшгүй судлах шаардлагатай. Гэтэл энэ бол байхгүй байгаа.

4 дүгээрт бол сэргээгдэх эрчим хүчний салбарыг энэ төслөөс бол тэр чигт нь хассан байгаа. Тусгайлан хассан байгаа нь тодорхойгүй бөгөөд энэ талаар техник эдийн засаг, байгаль орчин болон бодлогын үндэслэл бүхий судалгаа бас байхгүй байна. Тэгэхээр Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх дээр санал хурааж өгч шийдвэрлэж өгнө үү гэж. Энэ асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллаас хасаж өгнө үү гэж гишүүдээсээ хүсье ээ.

Тэгэхээр ерөнхийдөө бол төсөл боловсруулсан хүмүүс маань бол олон нийтийн санал асуулга болон холбоотой талуудаас мэдээллүүдийг нь аваад, дээрээс нь бид бүхэнд наадмын баяр наадам тулчихсан, чуулган хаагдах гэж байгаа энэ цаг үед давхардуулж ийм том ач холбогдолтой стратегийн болон бодлого гаргах зүйлийг ийм хурд бэлтгэл ажил хангагдах боломжгүй байгаа үед оруулж ирэхгүйгээр илүү цаг хугацааны хувьд ярилцах боломжтойгоор намрын чуулган руу шилжүүлэх байдлаар тэр үед нь төслөө сайжруулж орж ирээсэй гэж хүсэж байна.

Ч.Лодойсамбуу: Цэнгүүн гишүүн тодорхой үндэслэл шаардлага бүхий горимын санал гаргаж байна. Тэгээд горимын саналаар одоо санал хураана. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалтын томьёолол уншъя.

Өнөөдрийн хэлэлцэх асуудлын 6-д байгаа Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх асуудлаас хасах Цэнгүүн гишүүний саналыг дэмжье гэдгээр санал хурааа аа. Санал хурааа.

53.3 хувийн саналаар Цэнгүүн гишүүний гаргасан горимын санал дэмжигдэж төсвийн энэ төсөл хэлэлцүүлгээс өнөөдрийн хэлэлцүүлгээс хасагдаж байна аа.

За ингээд хэлэлцэх асуудалдаа орьё.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлнэ ээ.

Төсвийн гүйцэтгэлийн талаар Засгийн газрын илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна аа. Жавхлан сайдын микрофоныг нээе.

Б.Жавхлан: За баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын чуулганы 6 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгийг танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан тус Байнгын хороонд харьяалагдах Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Монгол Улсын сайд, 20 минутын хот, Үндэсний хорооны дарга, зарим Зам, тээврийн сайд, Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга, Хот байгуулалт барилга, орон сууцжуулалтын сайд, Эрчим хүчний сайдын багцын нийт 259 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Улсын төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 2 их наяд 368.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, үүнээс урсгал зардал 751.3 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 1 их наяд 612 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд тус Байнгын хороонд харьяалагдах 10 төсвийн ерөнхийлөн захирагчийн 474 төсөл арга хэмжээнд 1 их наяд 520.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл нь 84 хувийн биелэлттэй байна аа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга аудитын дүгнэлтүүдтэй танилцаж төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ч.Лодойсамбуу: Сангийн сайд Болдын Жавхланд баярлалаа. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна аа. Ажлын хэсгийн 7 дугаар микрофоныг нээе.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Энэ талаараа тоймлон танилцуулъя.

Нэг.Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 29 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 20 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллагыг түүвэрт хамруулсан. Үйл ажиллагаа нь зогссон, хууль эрх зүйн зохицуулалт тодорхой бус зэргээс шалтгаалан 2 байгууллага аудитад хамрагдаагүй бол нэг байгууллага татан буугдсан байна аа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн

тайланд хязгаарлалттай харьяа 5 байгууллагад өөрчлөлтгүй, 10 байгууллагад хязгаарлалттай, нэг байгууллагад сөрөг дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 316 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчил, 22 төлбөрийн акт тогтоож, 254.6 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 89 албан шаардлага, 53.2 тэрбум төгрөгийн зөрчилд 80 зөвлөмж өгч, 2.3 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах, 6 албан шаардлага хүргүүлж, хууль хяналтын байгууллагад 5.7 тэрбум төгрөгийн нэг асуудлыг шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 79.6 тэрбум төгрөгийн 64 алдаа илэрснээс аудитын явцад 78.6 тэрбум төгрөгийн 52 алдааг залруулж, 1.3 тэрбум төгрөгийн 12 алдааг залруулах зөвлөмж өглөө.

2-т нь Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 36 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 30 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллагыг түүвэрт хамруулсан. Аудитор төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай 16 байгууллагад өөрчлөлтгүй, 11 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт, 2 байгууллагад сөрөг дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар 407.8 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 35 төлбөрийн акт тогтоож, 313.1 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох чиглэлээр 101 албан шаардлага, 94.6 тэрбум төгрөгийн зөрчилд 134 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах нэг албан шаардлага хүргүүлээ. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 416 тэрбум төгрөгийн 40 алдааг аудитын явцад залрууллаа.

3.Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргын 2024 оны санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар 70.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 17.5 сая төгрөгийн нэг төлбөрийн акт, 52.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 3 их наяд 663.1 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан. 3.6 тийм тэрбум 3 тэрбум 663.1 сая төгрөгийн юм байна.

4-т нь Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 36 тайлан нэгтгэсэнээс 16 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 19 байгууллагыг түүвэрт хамруулсан. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 13 байгууллагад өөрчлөлтгүй, 3 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар 6.6 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 2.6 тэрбум төгрөгийн 14 төлбөрийн акт, 0.8 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 28 албан шаардлага, хариуцлага тооцуулах 3 шаардлага хүргүүлж 3.2 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 71 зөвлөмж өглөө. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 1.7 тэрбум төгрөгийн 36 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй алдаанд давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

5.Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлд харьяа 77 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэсэнээс 51 байгууллагад дүгнэлт гаргаж, 26 байгууллагыг түүвэрт хамруулсан. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн

нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 4 байгууллагад өөрчлөлтгүй, 8 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар 141.3 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 95.5 сая төгрөгийн зөрчилд 39 төлбөрийн акт тогтоож, 125.6 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоолгох 103 албан шаардлага, 15.7 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 108 зөвлөмж өгсөн бөгөөд нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 117.4 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа.

6.Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Аудитаар илэрсэн 9.3 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох нэг албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн бөгөөд нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 994.2 сая төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа.

7.Үндэсний статистикийн хорооны даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 23 тайлан нэгтгэснээс 13 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 10 байгууллагыг түүвэрт хамруулсан. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн болон харьяа 13 байгууллагад өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар 114.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 0.1 сая төгрөгийн зөрчилд нэг төлбөрийн акт, 67 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 5 албан шаардлага, 47.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 14 зөвлөмж өгсөн бөгөөд нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 472.1 сая төгрөгийн 30 алдааг аудитын явцад залруулсан байна аа.

8.Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 10 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллагыг түүвэрт хамруулсан. Санхүүгийн нэгтгэсэн төсвийн Ерөнхийлөгч захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай харьяа нэг байгууллагад өөрчлөлтгүй, 4 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар 132.3 тэрбумын зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчил, 8 төлбөрийн акт, 3.8 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 30 албан шаардлага, 87.5 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 11 зөвлөмж, 40.8 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлсэн бөгөөд нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 36.2 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа.

9-д нь, Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэнд 33 тайлан нэгтгэснээс 29 байгууллагын санхүүгийн тайлан, дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамруулсан. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 25 байгууллагад өөрчлөлтгүй, 4 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар 145.4 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчилд 45 төлбөрийн акт, 74.5 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсох 88 албан шаардлага, 70.6 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 76 зөвлөмж өгсөн бөгөөд нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 123.5 тэрбум төгрөгийн 73 алдааг аудитын явцад залруулсан.

10.Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 3 тайлан нэгтгэсэн. 3 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Аудитаар

төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй, харьяа 2 байгууллагад өөрчлөлтгүй, нэг байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар 64.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.9 сая төгрөгийн зөрчил, нэг төлбөрийн акт 34 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага, 29.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргах 6 зөвлөмж өгсөн бөгөөд нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 377.9 сая төгрөгийн 4 алдааг аудитын явцад залрууллаа.

Дээр дурдсан аудитын дүн дүгнэлтээс үндэслэн дараах асуудлуудад анхаарал хандуулахыг бол аудитын байгууллагаас санал болгож байгаа.

1 дүгээрт нь, Төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний үлдэгдэл, санхүүжилтийг төсвийн жилд дамжуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах шийдвэр гаргаж байгаа асуудлыг судалж, барьцаа хөрөнгийг чөлөөлөх.

2-т нь Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын хөрөнгө оруулалтын дансны бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, барих, шилжүүлэх төрлийн концессын гэрээгээр хэрэгжүүлж дууссан, улсын комисс хүлээн авсан хатуу хучилттай авто зам, зогсоол, дэд бүтэц, станцын өргөтгөл зэрэг хөрөнгийг шилжүүлэн авах Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг тогтоож, балансаас баланст шилжүүлэх.

3-д нь төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглал, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны хараат бус ил тод байдлыг хангах талаар Улсын Их Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх зорилт шалгуур үзүүлэлтийг тодорхой болгож, хэрэгжилтийг хангаж ажиллах.

4-д нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн хувьцааг олон нийтэд нээлттэй арилжих. Компанийн бол компанийн олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлэн, үр ашиг, засаглалыг сайжруулах.

5-д нь Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны буудлын менежментийн төслийн 15 жилийн хугацаатай концессын гэрээний төлбөрийг Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн төсөлд улсын төсөвт төвлөрүүлэх орлогоор тусгаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн боловч орлогын төлөвлөгөө батлаагүй, гүйцэтгэлээр 6.2 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн тул орлогын төлөвлөгөөг батлуулах, аудитаар тогтоосон төлбөрийн акт хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, алдаа, зөрчил давтан гарахгүй байхад анхаарах зэрэг асуудлыг толилуулж байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ч.Лодойсамбуу: ажлын хэсэг танилцуулъя. Монгол Улсын Ерөнхий аудитор Магнайсүрэн, Монгол Улсын Сангийн сайд Жавхлан, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Учрал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Дамдинням, Зам, тээврийн сайд Дэлгэрсайхан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Бат-Амгалан, Эрчим хүчний сайд Чойжилсүрэн, Соёл спорт,

аялал жуулчлал, залуучуудын сайд Ундрэм, нэр дуудагдсан сайд нар хуралдаа орж ирээрэй.

Үндэсний статистикийн хорооны дарга Батдаваа, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Жамбаажамц, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батболд, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга бөгөөд Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ерэн-Өлзий, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Батболд, Зам, тээврийн яамны Иргэний нисэхийн бодлого, зохицуулалтын газрын дарга Туяа, Зам, тээврийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Батбаяр, Зам, тээврийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Сумъяа, ИНЕГ-ын Нислэгийн стандартын газрын дарга Бат, Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонбат, Эдийн засаг, хөгжлийн яамны хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Анар, Хот байгуулалт, барилга, хот орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга Баярбат, Үндэсний статистикийн хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Төмөрхуяг, Эдийн засаг, хөгжлийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Гэрэлбат, Зам, тээврийн яамны Санхүүгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Сумъяа, Эдийн засаг, хөгжлийн яамны харьяа ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дарга Баярбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны харьяа ШУТС-ийн Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Энхтунгалаг, Ашигт малтмал газрын тосны дарга газрын дарга Оюунцэцэг, Эрдэнэс Монгол ХХК-ийн нэгдсэн стратеги, санхүүгийн удирдлагын газрын дарга Батбаяр, Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын газрын дарга Болормаа, Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мөнхзул, Эрчим хүчний яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Хуягцогт, Эрчим хүчний яамны Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга Энхтүвшин, Эрчим хүчний яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Баясгалан, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү бүртгэлийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч Гүндсамбуу, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологи уур уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Өнөрнасан, Санхүүгийн зохицуулах хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга. Нансалмаа, Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цогтгэрэл, Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга Лхагва, ИНЕГ-ын Нисэхийн стандартын газрын дарга Бат, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Эрдэнэсайхан, Хөдөө аж ахуй Корпорац ТӨК-ийн захирал Цогтсаран, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Нарантуяа, Зээлийн батлан даалтын сангийн захирал Цогтсайхан, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах, Сангийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга Тавинжил, Сангийн яамны Төрийн сангийн газрын санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Мөнхсүх, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Ичинноров, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, Сангийн яамны Төрийн сангийн газрын төлбөр тооцооны хэлтсийн дарга Саруул, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн Сайхантөгс.

Үндэсний аудитын газраас: Санхүү-нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Энхболд, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер

Чанцалдулам, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Долгорсүрэн, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Эрдэнэцэцэг, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Энхдалай, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Нацагдорж, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Цогбаяр, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Эрдэнэцогт нар ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4.2-т зааснаар Байнгын хороод нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед гишүүд төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайлантай холбогдуулан зөвхөн Сангийн сайд болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух дэгтэй гэдгийг урьдчилан сануулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгье. Үгүй ээ сайд нараас бас асуусан. Мандхай гишүүний нэрийг нэмье. За Мандхай гишүүнээр тасаллаа. Соронзонболд гишүүн асуултаа асууя.

Л.Соронзонболд: Сайн байцгаана уу? Энэ 2024 оны төсвийн гүйцэтгэл дээр Эдийн засгийн хөгжлийн яамны төсвийн гүйцэтгэл дээр энэ шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогц нэгдсэн цогцолбор бүтээн байгуулалтын ажил гээд 2024 онд төсөвт тавигдаад хийгдээгүй юм байна аа. Энэ одоо ямар учиртай хийгдээгүй вэ гэдэг 1 дүгээр асуулт.

2-т болохоор бол энэ ажил маань одоо цаашдаа яаж төлөвлөгдөж байгаа вэ? Нэлээд хэмжээний мөнгө тавигдчихсан, тэгсэн мөртөө ингээд хийгдэхгүй ажил байгаад байна. 2 дугаарт болохоор бол энэ Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдын энэ тайлан дээр Үндэсний аудитын газраас одоо залруулагдаагүй 132.3 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн гэсэн юм байна аа. Энэ одоо ямар зөрчлийн тухай яригдаж байна? Энэ талаар тайлбар өгөөч ээ. Эдийн засгийн хөгжлийн яам, Барилга, хот байгуулалтын орон сууцжуулалтын сайд.

Ч.Лодойсамбуу: За ажлын хэсгийн 2 дугаар микрофон хариулт өгье.

Ж.Гэрэлбат: Сайн байна уу? Эдийн засаг, хөгжлийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Гэрэлбат байна аа. Гишүүний асуултад хариулъя аа. Шинжлэх ухааны салбарын барилгын тоног төхөөрөмж, шинжлэх ухааны барилгын 2 барилга манай Эдийн засаг, хөгжлийн яамны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд нэмэгдэж орж ирсэн байгаа. Сая энэ оны 2024 оны 7 сард шинжлэх ухааны судалгааны лабораторийн спорт танхимын барилга болбол хэвийн үйл ажиллагаа явагдаж байгаа. Гүйцэтгэлээ бүрэн санхүүжилтээ аваад тухайн онд туссан гүйцэтгэлээ аваад явж байгаа.

Ч.Лодойсамбуу: Тодруулах уу? За Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Энэ нөгөө Эдийн засаг, хөгжлийн яамны төсвийн гүйцэтгэлийг хараад л ярьж байгаа юм л даа. Энэ хөрөнгө оруулалт дээр байгаад байгаа байхгүй юу. Шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалт их засвар гээд нийтдээ 24 тэрбум төгрөгөөр гүйцэтгэл нь дутуу байгаа шүү дээ. Тэрийг яриад байгаа юм.

Ч.Лодойсамбуу: Ажлын хэсгийн 2 дугаар микрофон. Би микрофон нээчихсэн байгаа шүү.

Ж.Гэрэлбат: Нийтдээ хөрөнгө оруулалтын зардалд 92.4 тэрбум төгрөг батлагдсан. Үүнээс төсвийн гүйцэтгэлээр 57.2 тэрбум төгрөг гүйцэтгээд 35.2 тэрбум төгрөг хэмнэгдсэн байгаа нь энэ болохоороо зэрэг тухайн онд концессын төсөл Дархан, Сэлэнгийн авто замаас Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Зэлтэрийн боомт чиглэлийн хатуу хучилттай авто замын гүйцэтгэл тухайн онд гараагүй. Энэ 25 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарах ёстой байсан. Аудитын дүгнэлт мөн нөгөө яг тухайн ондоо энэ 25 тэрбум төгрөг гүйцэтгэл гараагүй байгаа нь концессын ажлын гүйцэтгэл гараагүй байгаа шүү.

Ч.Лодойсамбуу: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Д.Баттогтох: Эдийн засаг, хөгжлийн яам Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Баттогтох. Гишүүний асуултад хариулъя. Энэ шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын төсөл болбол нийтдээ 154 тэрбум төгрөгийн өртөгтэй төсөл байгаа. 2020 оноос эхлээд одоо ажил нь эхэлсэн. 2020 онд 3 тэрбум, 2021 онд 22, 2022 онд 20, 2023 онд 24.5, 2024 онд болбол гүйцэтгэл нь бол 23.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа. Төлөвлөсөн хэмжээнд бол гүйцэтгэлээ явуулж байгаа.

Тухайн барилга бол нийтдээ нэг 74 мянган м.кв талбайтай, шинжлэх ухаануудын нэгдсэн одоо цогцолбор учраас болбол энэ барилга ашиглалтад орох дээр хүрээлэнгүүд шилжиж байршихаар байгаа юмаа. За 2025 онд болбол энэ төсөл дээр одоо тодотголоос өмнө болбол 20.4 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан байгаа. Хэсэгчлээд бол цогцолбор ашиглалтад орно гэж төлөвлөж байгаа.

Ч.Лодойсамбуу: 4 номер гүйцээж хариулъя.

Д.Баттогтох: Тэгэхээр энэ төслийн тухайд болбол хэвийн үйл ажиллагаа нь явагдаж байгаа. Нийтдээ 7 блок барилга байгаа. Үндсэндээ бол 3 блокийг нь болбол энэ намраас ашиглалтад орно гэж төлөвлөж байгаа. Эдгээр 3 блок болбол дандаа эрдэм шинжилгээний байгууллагын лабораторийн зориулалттай барилгууд байгаа. За нийгмийн ухааны одоо хүрээлэнгүүд байрших 2 блок нь бас хэвийн үргэлжлээд явж байгаа.

Ч.Лодойсамбуу: Хот байгуулалтын яамнаас байна уу? Хариу. Эсвэл Үндэсний аудитаас. За ажлын хэсгийн 7 дугаар микрофоныг нээе. Микрофон нээгдсэн.

Ц.Наранчимэг: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Үндэсний Аудитын газар Наранчимэг. Барилга, хот байгуулалт орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн. За хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл нь залруулагдаагүй алдаа зөрчил буюу 132.3 тэрбум төгрөгийн алдаа нь одоо залруулагдаагүй буюу зөрчил учраас хязгаарлалттай санал дүгнэлтийг өгсөн. Тухайлбал энд норм стандарт, дүрэм одоо боловсруулахад зөрчсөн 0.4 тэрбум төгрөг. Хэрэгжилт нь хангалтгүй байгаа. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан, олон жил болсон, хэрэгжилтийн хугацаа дууссан, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагууд нийт 0.9 тэрбум

төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлээгүй. Харилцагч байгууллагуудын өглөгийн 17.3 тэрбум, авлагын 24.3 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тооцоо...

Ч.Лодойсамбуу: 7 дугаар микрофон гүйцээж хариулъя.

Ц.Наранчимэг: Иргэнээс худалдаж авсан 0.7 тэрбум төгрөгийн байрыг үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гаргаагүй гэсэн шалтгаанаар үндсэн хөрөнгөд бүртгэлгүй одоо авлагаар бүртгэсэн. Норм нормативын сангийн он дамжсан ажлыг бүрэн тусгаагүйгээс тайлант оны төлөвлөгөөг хэтрүүлэн өмнөх оны ажлын 0.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг олгосон гэх зөрчлүүдээр хязгаартай санал дүгнэлт өгсөн байгаа.

Ч.Лодойсамбуу: Зөрчлийг нь зассан юм уу гээд асуугаад байх шиг байна. 7 дугаар микрофон.

Ц.Наранчимэг: Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж 4 дүгээр сарын 25-нд дүгнэлт гаргаж байгаа. Бидэнд 9 дүгээр сарын 30-ны дотор аудитаар гарсан залруулагдаагүй алдаа зөрчлийг гаргах төлөвлөгөөг 30 хоногийн дотор ирүүлэх үүрэгтэй байгаа. Төлөвлөгөөгөө бол ирүүлсэн. Бид нар 8 дугаар сараас эхэлж завсрын аудитыг хийнэ. Энэ аудитаар энэ тайлан дээр гарсан алдаа зөрчлийн залруулсан эсэх асуудлыг шалгаж, эргэж тайлагнадаг байгаа.

Ч.Лодойсамбуу: Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууя. Мандхай гишүүний микрофоныг нээгээрэй.

М.Мандхай: За би яг үндсэндээ бол 2024 оны гүйцэтгэлийн тайланг бүтэн уншиж амжсангүй ээ. Ийм богино хугацаанд ч хүн яаж ч сайн уншиж, одоо тодруулах асуудлуудаа ч бэлдэх вэ гэж бодож байна. Тэгэхдээ яах вэ одоо аудитын гүйцэтгэлийн тайлангаас нэлээн хэдэн асуулт асууя гэж бодож байна. За энэ Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон энэ НӨАТ-ын 38.6 хувь нь уул уурхайн салбараас орж ирсэн юм байна аа. За энэ ер нь манай хамаарлыг ер нь яаж бууруулъя гэж бодож байгаа вэ? Бид нар чинь одоо уул нь энэ татварын баазыг төрөлжүүлэх, жижиг, дунд бизнесийн бодлогыг дэмжих гэж ярьдаг. Тэгэхлээр энэ хамаарлыг ер нь яаж бууруулах энэ дээр ер нь ямар ажлууд хийгдэж байгаа вэ гэдэг нэг эхний асуулт.

2 дугаарт Монголбанкнаас. Энэ мөнгөний нийлүүлэлт 2024 оны гүйцэтгэл дээр 23.1 хувиар өсөж инфляц 10.2 хувьд хүрсэн юм байна аа. За яг үндсэндээ бол ипотекийн зээл олгогдохгүй, ер нь яг иргэдэд ирж байгаа энэ одоо үнэ ханш нэмэгдсэнтэй холбоотойгоор хэрэглээ бас буурсан байгаа. Худалдан авах чадвар ч гэсэн буурсан. Энэ одоо яг энэ бодлогын уялдаа холбоо хангагдаж чадсан юм уу? Яагаад энэ нийлүүлэлт, ямар учир шалтгааны улмаас ингэж өсөж инфляц нэмэгдсэн бэ гэдэг асуултад хариулж өгөөрэй.

Төсвийн зөрчлийг түрүүн дурдлаа. 215.6 тэрбум төгрөг зориулалтын бусаар зарцуулсан. 85.4 тэрбумд хүрсэн байна аа. Энэ бол одоо бас л аймшигтай тоо. Энэ дээр ер нь яг ямар хяналт хариуцлага тооцох юм бэ? Энэ дээр бас Сангийн яам бас хариулт хэлж өгөөч ээ? Уг нь бол одоо энэ дотоодын аудитын тогтолцоог бэхжүүлж, энэ зөрчилд ийм үүсэж байгаа зөрчлийг одоо бид нар бас шууд хариуцлага тооцдог

байх ёстой. Тэгээд ийм механизм ер нь хэрэгжиж байгаа юм уу, үгүй юү гэдэг дээр нэг хариулт авмаар байна.

Дунд хугацааны төлөвлөлтгүй энэ богино хугацааны тэлэлттэй төсөв бол батлагдсан гэж бас мэргэжлийн одоо энэ санхүүч нар бол үзэж дурдсан байгаа. Энэ дээр одоо энэ сахилга бат хэрхэн хангагдах вэ? Энэ дээр бас асуулт авъя.

Сүүлд нь аудитын тайланд үр ашгийн дүн шинжилгээ хийгдээгүй олон төсөл одоо худалдан авалтууд байгааг бол дурдсан. Зарим нэг нь одоо бас одоо ТЭЗҮ-гүйгээр хэрэгжсэн, нэг одоо аймаг, сум нь давхардсан одоо хэмжээгээр төсөл хөтөлбөрүүд хэрэгжсэн гээд олон зөрчлүүдийг бол дурдсан байсан. Энэ зарим аймагт нэг төрлийн төсөл одоо жишээлбэл 2-3 дахин өндөр өртөгтэй бол одоо хийгдсэн байна. Тэгэхээр ийм өртгийн ялгаа, зардлын одоо энэ үр ашгийн дүн шинжилгээ яг ямар түвшинд явагддаг юм бэ гэдэг асуултад хариулж өгөөрэй.

Мөн хуульд тусгагдаагүй төсөл гүйцэтгэлд орсон. Засваргүйгээр хэрэгжсэн...

Ч.Лодойсамбуу: За нийт 7 асуулт асуулаа. Хэн хариулах вэ? Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Мандхай гишүүний асуултад хариулъя аа. Тэгэхээр Эдийн засгийн хөгжлийн яам бол мэдээж одоо энэ 4 жилийн хөтөлбөр, 5 жилийн Үндсэн чиглэл гээд хөгжлийн бодлогуудаа хийж байгаа. Тэгээд улсын жилийн төлөвлөгөөг боловсруулах үеэр гишүүд олон одоо саналуудыг тусгадаг оруулдаг. Тэгээд ингээд жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй олон ажлууд болбол төсөвт суучихдаг. Тэгээд ТЭЗҮ нь байхгүй, зураг төсөв байхгүй олон ажлууд сууснаас болоод төсвийн гүйцэтгэлээ эргээд харахаар одоо яг энэ жилийнх шиг 5 сарын 31-нд энэ 500 тэрбум төгрөг татагддагтай адилхан төсөл хөтөлбөрүүд тендерүүд зарлагдахгүй ингээд гацдаг. Тэгээд төсвийн хүрээ төсвийн зарцуулалт гүйцэтгэл бол болбол ийм үр ашиггүй зарцуулагдаж байгаа юм. Тэгээд манай улсын эдийн засаг өөрөө ийм хос хамааралтай. Тэгээд тэр дундаа уул уурхайн бүтээгдэхүүн тэр дундаа одоо нүүрснээс хамааралтай гээд хор гай болбол одоо ингээд ажиглагдаж байна шүү дээ. Нүүрсний үнэ нь 39 хувь буурчихаар ингээд төлөвлөгдөж байсан орлого тасарчихдаг. Тэгээд одоо бид нар энэ 7 дугаар сард гэхэд л өнөөдөр бараг одоо 3.3 их наядын ийм одоо орлого тасрах ийм нөхцөл байдал руу шилжсэн. Тийм учраас аргагүй нөхцөл байдлаас болж энэ хэмнэлт хийж байна.

Тэгэхээр цаашдаа болбол хөгжлийн бодлогыг барьж байгаа гэдэг утгаараа бол бид нар төсвийн санхүүжилтээр одоо ажлууд явуулаад байхаасаа илүүтэйгээр ер нь бол төр, хувийн хэвшлийн түншлэл дээрээ голлож анхаарна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг оруулж ирнэ. Үе шатуудыг багасгана. Ингээд хувийн хэвшил өөрөө одоо тэр зардлаа нөхөөд явах бололцоотой ажлуудыг урьдчилсан тэр бүрэн шинжилгээг нь хийлгээд, төр, хувийн хэвшлийн түншлэлээр энэ төслүүдээ урагшлуулна.

2-т болбол уул уурхайн салбар дээр нэмүү өртөг шингэсэн технологийн агууламж шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болохын төлөө зорино оо. Үүний тулд өмнө нь одоо Хэрэг эрхлэхийн сайдаар ажиллаж байхад болбол энэ 14 мега төслийн чинь бараг 6 төсөл нь Эрдэнэс Монгол дээр харьяалагдаж байсан. Үүнээс болбол энэ гангийн үйлдвэрийн цогцолбор, энэ улсын төсвөөс заавал санхүүжилт шаардахгүй. Багануур дээр нөгөө пирализын үйлдвэр байгуулах төсөл болбол

гаднын дээл тусламжаар баригдах бололцоо болбол бүрэн дүүрэн хэд хэдэн санал ирчихсэн, энийг явуулна. Дээрээс нь алт цэвэршүүлэх үйлдвэр лүү ч гэсэн бид нар одоо анхаарлаа хандуулж энэ аж үйлдвэрийн салбараа дэмжих чиглэл рүү болбол голлож анхаарна гэдгийг бас хэлэх ёстой гэдгийг бас хэлье.

Мөн худалдааны экспортыг нэмэгдүүлэх бол зайлшгүй байна. Тэгээд сая болбол тэр Евро Азийн хэлэлцээрт гарын үсэг зураад ирлээ. Энэ болбол Их Хурлаас Байнгын хорооноос Гантөмөр сайдын үед зөвшилцсөн. За ингээд төрийн ажлын залгамж чанар хадгалах үүднээсээ гэрээнд зурсан. 200 сая хүнтэй зах зээл дээр барааны эргэлт нь нэг 11 хувьтай байна гэдэг бол хангалтгүй тоо. Тийм учраас бид нар болбол ХАА-н салбарын экспортыг нэмэгдүүлэхэд анхаарах ёстой. Бид нар зөвхөн сөрөг талыг нь яриад байдаг, эерэг талаа бас ярих л ёстой шүү дээ. Тийм учраас энэ худалдааны экспортыг нэмэгдүүлэх чиглэл рүү болбол зайлшгүй анхаарна.

За өмнө нь Цахимын сайдаар ажиллаж байхад болбол энэ мэдээлэл технологи үйлдвэрлэлийг дэмжих хуулийг гаргасан. Виртуал бүс дээр татваргүй орчныг бүрдүүлэх чиглэлээр ажиллахад өнөөдөр эрчим хүчний салбар дээр ч гэсэн энэ дата төв байгуулах, технологийн салбарыг дэмжих чиглэлээр ийм худалдаа экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр болбол ийм таатай орчин бүрдсэн шүү дээ. Энэ хууль огт хэрэгжихгүй л байгаа. Тэгэхээр үүнийг ч гэсэн цаашдаа явуулах, нөгөө материаллаг бус баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэл рүү урагшаа харсан ийм бодлого зорилтуудыг дэвшүүлж ажиллах нь болбол бидний хувьд нэн тулгамдсан байгаа. Тэрнээс биш зүгээр нэг ийм уул уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтай эдийн засагтай тэгээд түүнийгээ хэрхэн хуваарилах вэ гэдэг дээр бид нар маргаад сууж байх нь өөрөө зохимжгүй юмаа.

Тийм учраас ер нь бол гадаадын зээл тусламжийг нэмэгдүүлэх чиглэл рүү анхааръя. Их Хурлын гишүүд ч гэсэн тэр 3 төслийг тэр төсөв дээр заавал бичихгүйгээр тусад нь гаргаад ингээд явъя аа гээд хууль санаачлаад явж байсан. Зарчим нь бол буруу биш. Тэгэхдээ төсвийн сахилга бат, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай гэдэг утгаараа ямар төсөл дээр, ямар шалгууруудыг хангасан төслүүдийг тэр төсвөөс гадуур байж болох юм бэ гэдгийг эргэж харахгүй бол зүгээр ингээд нэг ийм 3 төсөл биччихээд энэ нь одоо гадуур байна аа гэж болохгүй.

Тийм учраас гадаадын дээд зээл тусламжийг нэмэгдүүлэх төслүүдийг дэмжвэл, гадаадын зээл тусламжийг нэмэгдүүлбэл энэ инфляцад төлбөрийн тэнцэлд бас тийм шууд эффект өгөөд байх нь бага. Тийм учраас гадаадын зээл тусламжийг нэмэгдүүлэх чиглэл рүү анхаарна. Бондын санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэл рүү анхаарна. Гэхдээ үр ашгаа өгдөг зүйлүүд рүү санхүүжилтийг хийнэ. Хөгжлийн банкн дээр ч гэсэн тэр 350 сая долларын одоо бонд босож байгаа болбол үүнийг эргээд нөхдөг чиглэл рүү анхаарах, эргээд нөхдөг чиглэл рүү тэр одоо санхүүжилтийг олгох чиглэл рүү бид нар анхаарна аа л гэдгийг бас хэлье.

Ч.Лодойсамбуу: За өөр. Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Миний яг тодорхой асуусан асуултад нь одоо гол гол салбарынх нь хүмүүс нь хариулаад өгөөрэй. Тэр аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ-тай холбоотой тэгэхгүй бол ингээд ерөнхийлөн тойруулаад одоо дандаа хариултаа авдаг бол ерөөсөө яг бодитой яг асуултад цаг үрээд байгаа юм шиг хариулт өгөөд байгаа байх аягүй хэцүү байна.

Тэгээд ер нь нэг ийм зүйл хэлчихье. Гадаад өрийг нэмэгдүүлнэ гэдэг дээр би бол одоо бас яг эргэлзэж байна. Яагаад гэхлээр одоо бид нарт энэ тайлант хугацаанд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарснаас шалтгаалан ханшийн зөрүүгээр дамжуулан зээлийн үлдэгдэл 57 тэрбум төгрөгөөр буурсан. Ерөнхийдөө манайх өөрсдөө орлогоо хэт өндөр төсөөлөөд тэгээд түүнийгээ дагаад зарлагаа өндөр тавьчихдаг. Энэнээс чинь болоод хаана өр үүсдэг вэ гэхлээр ерөөсөө Засгийн газрын өр чинь нэмэгдээд байгаа байхгүй юу жил ирэх тусам. Тэгээд тэрэн дээр нь харах юм бол бараг 94, 2024 оны гүйцэтгэлээр 94 хувь чинь өөрөө дандаа гадаад өр байгаа шүү дээ. Тэгэхлээр бид нар гадаад өрийг өрнөөс Засгийн газар чинь ерөөсөө өрнөөс өр лүү өрнөөс өр лүү л ингэж санхүүжилт хийгдээд яваад байдаг. Тэгээд энэ зөв юм уу?

Ч.Лодойсамбуу: Сангийн сайд хариулах уу? Жавхлан сайдын микрофон.

Б.Жавхлан: 2013 онд Засгийн газрын өр ДНБ-ий 90 гаруй хувийг эзэлж байсан бүр 90-ээс дээшээ байсан шүү. 2024 оны жилийн гүйцэтгэлээр 42 хувь гарсан. Бараг 2 дахин буурсан. 12 жилийн өмнө Монгол Улсын гадаад өрийн зээлжих зэрэглэл 2 ангиллаар 2 шатлалаар буурсан. 12 жилийн дараа буюу өнгөрсөн жил бид одоо тэр үедээ алдсан зээлжих зэрэглэл дээрээ эргэж ирсэн. Тэгэхээр энэ болбол манай гадаад өрийн менежмент дээр олон улсын байгууллагуудын өгч байгаа үнэлгээ юм. Тэгэхээр одоо харьцангуй манай гадаад өрийн эрсдэл одоо буурч ирж байна аа гэсэн үг. За хэдхэн хоногийн өмнө мөн одоо Парист болсон энэ жилийн Ой Сидигийн хурлаар манай зэрэглэлийг мөн ахиулсан байгаа. Арваад жилийн дараа дахиад.

Тэгэхээр ер нь өрийн гол одоо эрсдэлийг үнэлдэг үнэлгээ юу вэ гэхээр зээлжих зэрэглэл тэгээд ДНБ-ий эзлэх одоо хувь хэмжээ ийм л зүйлүүд байгаа. Таны ярьж байгаа зүйл бол манай одоо Засгийн газрын зээлийн дотоод бүтцийн асуудал байгаад байгаа юм. Сүүлийн жилүүдэд бид дотооддоо бол дотоод төгрөгийн бонд гаргаагүй. Тийм учраас манай Засгийн газрын гадаад зээл юу өрийн үндсэндээ 95 хувь нь гадаад зээл. Өөрөөр хэлбэл одоо гадаад валютаар илэрхийлэгддэг ээ гэсэн үг. Тийм учраас бас ханшийн эрсдэлээр одоо жил бүр төгрөгөөр илэрхийлэгдэх Засгийн газрын зээлийн дүн гээд нэмэгдээд байгаа юмаа. Тийм учраас цаашдаа бид бас энэ бүтэцтэй бас өөрчлөлт хийх, дотооддоо төгрөгийн бонд гаргах ийм даалгаврыг Их Хурлаас бас чиглэл болгож авсан байгаа. Ингээд энэ жилээс одоо бага багаар зах дээр одоо хүү тогтоох зорилгоор бенчмарк суурь бенчмарк тогтоох зорилгоор одоо бага хэмжээний дотоодын бондуудыг гаргаад ингээд явж байгаа

Сүүлийн жилүүдэд бид дотоод бонд ингээд гаргаагүй. Гадаад...

Ч.Лодойсамбуу: Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Тийм гадаад бондыг шинэ төсөл одоо хөтөлбөр санхүүжүүлэхээр нэг ч бонд аваагүй. 2017 оноос хойш дандаа одоо Рефайнанс хийсэн тухайн одоо яг тулчихсан бондуудыг одоо хүүг нь багасгах, хугацааг нь хойшлуулах, төсөв дээрээ хойшдоо ингээд дарамтыг нь жигд хуваарилах ийм зорилготойгоор рефайнансуудыг бол маш амжилттай хийж ирсэн байгаа. Ингээд тухайн жилийнхээ төсвийн боломжоос шалтгаалж жилдээ нэг 250-300 сая доллароор болбол бууруулаад явж байгаа.

Ингээд манай бондын дүн бол одоо жишээ нь өмнөх Засгийн газар бид 2.8 тэрбум долларын бондын үлдэгдэл авч байсан, одоо 2.2 болчихсон ингээд явж байх жишээтэй. Харин одоо олон улсын олон тал эдийн засгийн хамтын ажиллагаатай одоо байгууллагуудаас Дэлхийн банк Олон улсын валютын юу Азийн хөгжлийн банк, BRD-гээс болбол дандаа Их Хурал дээрээ одоо танилцагдсан хөгжлийн хөтөлбөрт орсон ийм төслүүдийг санхүүжүүлэх урт хугацааны хөнгөлөлттэй зээлүүдийг аваад явж байгаа.

Ч.Лодойсамбуу: Тийм бусад хариулт. Нөгөө аж ахуйн нэгжийн орлогын албан татвартай холбоотой, Нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой асуултууд, мөнгөний бодлоготой холбоотой асуултууд гээд асуултуудаа сайн сонсчихоод гүйцэд хариулаад өгөөрэй. Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Сангийн яамнаас юу тэр татвартай холбоотой асуултад хариулаадхаач хэн байна.

Ч.Лодойсамбуу: Сангийн яамнаас татвартай холбоотой асуултад хариулаад өгөөч ээ гэж байна. Хүн байна уу. Монгол банкныхан байна уу? Монгол банкнаас байна уу? Асуулт асуугаад хариултаа авахгүй байна аа, өгөхгүй байна аа гэсэн гомдол байж байна. Жавхлан сайд энэ татваруудтай холбоотой ер нь ямар бодлого баримталдаг.

Б.Жавхлан: За уучлаарай би нэг өөр асуултад бэлдэж байгаад яг тэр хэсгийг нь анзаараагүй байна шүү. Уучлаарай. 1990 оноос хойш бид ингээд шинэ цагийн татварын тогтолцоонд орсноос хойш одоо 4 дэх удаагаа татварын яг суурь шинэчлэлийг хийхээр Засгийн газар төслөө бэлдсэн байгаа. Энэ удаагийн одоо татварын шинэчлэл маань бол нэлээдгүй бас өртөгтэй, өөрөөр хэлбэл хэдий хэр хэмжээний одоо хөнгөлөлт чөлөөлөлтүүд хувийн хэвшлийнхээ одоо дэмжлэг үзүүлнэ тэр хэмжээгээр одоо төсөвт өртөг нь ирнэ ээ гэсэн үг. Тэгэхээр тэр хэмжээ бол ойролцоогоор 4 их наяд байгаа. Өөрөөр хэлбэл ирэх жилийн төсвөөс 4 их наяд төгрөгийн одоо орлого буурна аа гэсэн үг. Тэгэхээр энэ олон одоо хууль тогтоомжоор төсвийн хуваарилалт хийчихсэн энэ зардлуудаа одоо санхүүжүүлж чадахгүй. Засгийн газрын үйл ажиллагаа тасалдаг бас ийм эрсдэлтэй байна аа.

Тийм учраас энийг ирэх 4 жилд одоо тэгээд жигд хуваарилах замаар ингэж цаг хугацааных нь...

Ч.Лодойсамбуу: Мандхай гишүүн нэмэлт тодруулъя. Тэгээд сонсож байгаад яг асуултыг нь сонсож байгаад бүрэн гүйцэд хариулаад өгөөрэй. Мандхай гишүүний микрофоныг өгье.

М.Мандхай: За хэдүүлээ одоо олон хүмүүс бас гишүүд асуулт асуух гээд хүлээж байгаа учраас яг асуултаа тодорхой бичиж аваад тэгээд яг хариулах хүмүүс нь яг тодорхой товч тодорхой хариулчихвал уг нь зүгээр. Би уг нь хэлсэн л дээ. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон НӨАТ-ын нийлээд 38.6 хувь бол ерөөсөө л энэ уул уурхайн салбараас юм байна аа. Тэгэхлээр ер нь энэ хамаарлын бууруулах дээр яг ямар бодлого баримталж ажиллах юм бэ? Бид одоо ялангуяа уул уурхайн экспорт буурч байгаа, орлого буурч байгаа ийм нөхцөл байдалд байхад бид нар уул уурхайн салбараас хараат бус төгөлдөржүүлэхийн тулд яг ямар бодлого баримталж ажиллах вэ гэдэг асуултыг асуусан.

2-т нь би мөнгөний нийлүүлэлт 23.1 хувиар 2024 онд нэмэгдсэн юм байна аа. Инфляц 10.2 хувьд одоо хүрлээ. Тэгэхлээр гэтэл энэ мөнгөний нийлүүлэлтийн чинь цаад яг гол шалтгаан нь юу байсан юм бэ гэдгийг би асуусан байгаа тиймээ. Ипотекийн зээл бол маш ба бага хэмжээгээр олгогдож байгаа, худалдан авах чадвар суларсан ийм нөхцөл байдалтай энэний цаана яг...

Ч.Лодойсамбуу: Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Үгүй ээ бид наад асуултыг чинь түрүүн сонссон л асуулт байна шүү дээ энэ чинь Эдийн засгийн хөгжлийн сайд түрүүн хариулчихсан шүү дээ. Энэ чинь Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудал. Монголбанкны асуулт дээр Монгол банкныхан хариулах хэрэгтэй. Мөнгөний нийлүүлэлт эд нар гээд бид нараас бүүр энэ чинь бүүр хамаагүй хол асуултууд байна шүү дээ.

Ч.Лодойсамбуу: Эдийн засгийн хөгжлийн сайд за нэмээд хариулъя.

Н.Учрал: Би түрүүн хэлсэн тийм Мандхай гишүүн ээ. Үнэхээр л энэ уул уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтай байгаа энэ эдийн засаг өөрчлөгдөх ёстой. Олон жил эдийн засгийг төрөлжүүлэх гэж ярилаа. Тэгэхээр бид нар болбол ирэх жил энэ аж үйлдвэрийн салбараа дэмжинэ ээ, үүнийг хэрэгжүүлэхийн тулд төр, хувийн хэвшлийн түншлэлийн энэ схем загварыг ашиглана аа гэдгээ болбол хэлсэн. Тийм учраас эхний эрэмбэд болбол тэр гангийн үйлдвэр, алт цэвэршүүлэх үйлдвэр гээд энэ үйлдвэрүүдээсээ болбол бид нар эрэмбэлж байгаа. Энэ 14 мега төслөө ч гэсэн эрэмбэлж байгаа. Үүнийхээ дагуу явуулна аа.

Дээрээс нь бид нарын эрхлэх асуудалд байгаа энэ оюуны өмч, мэдээллийн технологи, бусад салбаруудаар байгаа эрх зүйн орчноо урагшлуулъя аа. Өөр арга байхгүй ээ. Дээрээс нь худалдааны хэлэлцээрүүдийгээ одоо бүс нутгийн хамтын ажиллагаагаа өргөжүүлъя ээ, худалдааны экспортоо нэмэгдүүлъя ээ гэдэг чиглэлээр анхаарна аа. Барааны эргэлтийнхээ хувь хэмжээг нэмэгдүүлнэ ээ.

Ч.Лодойсамбуу: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Нэгэнт өрийн удирдлага ярьж эхэлсэн юм чинь энэ Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаас энэ орон нутгаас гаргасан үнэт цаастай холбоотой тодорхой асуултуудыг асуух гэсэн юмаа. Тэгэхээр Ерөнхий аудитор Магнайсүрэн байгаа юм уу? Магнайсүрэн даргын хувьд бол энэ бол анх удаа бас одоо энэ шинэ ажилд томилогдсоноос хойш энэ улсын төсвийн гүйцэтгэлийг оруулж ирж байгаа ийм хариуцлагатай цаг үе байгаад байгаа. Тэгэхээр харин Магнайсүрэн дарга бас өөрөө байвал сайн байна.

Тэгэхээр аудитын байгууллагаас хийсэн тайланд орон нутгийн дотоод үнэт цаас гээд өнгөрсөн жилийн хувьд болохлоор нийслэл Улаанбаатар хот дотоодод болон гадаадад хэд хэдэн удаа үнэт цаас гаргасан байгаа. Тэгээд тайлан онд бол 798.3 тэрбум төгрөгийн орон нутгийн дотоод үнэт цаас шинээр гаргасан. Эхний ээлжийн нээлттэй арилжаалсан 500 тэрбумын 300 тэрбум төгрөгийг 14 хувийн хүүтэй босгосон. За үүнийг Бөөрөлжилтийн цахилгаан станцад өгсөн. Мөн одоо 13 хувийн хүүтэй босгосон 100 тэрбумыг зам засвар арчилгаанд зарцуулсан. 12 хувийн хүүтэй 100 тэрбум төгрөгийн бондыг бас мөн зам засвар арчилгаанд зарцуулсан. Мөн дээрээс нь ахиад нэмэлтээр 300 орчим тэрбум төгрөгийн бонд босгосон. Нийлбэр дүнгээрээ хүүгийн төлбөрт 33.4 тэрбум төгрөг төлсөн гэж байна.

За тэгээд дотоодын зах зээлээс 1.5 жилийн богино хугацааны арилжааны нөхцөлтэй 13 хүртэлх хувийн хүүтэй үнэт цаас гаргаж, зам засвар, арчилгаа, батарей, хуримтлуурын станц барих төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь Өрийн удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4 дэх заалтуудтай нийцээгүй, өр үүсгэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зарчмыг алдагдуулсан гэж аудитын байгууллага дүгнэжээ.

Тэгээд өнгөрсөн зун хийгдсэн зам засварын асуудлууд бол нэлээн иргэдийн шүүмжлэлийг дагуулсан. Эдгээр ажилтай холбоотой яг бодит, одоо шаардлагууд дүгнэлтүүд бас юу байна аа гэдгийг аудитын байгууллагаас асууя. Гадаад үнэт цаасны хувьд 1.7 их наядын гадаад үнэт цаасыг 7.75 хувийн хүүтэй босгосон байгаа. За үүнийг бол одоо Сэлбэ дэд төв төслийг санхүүжүүлнэ гэж анх оруулж ирсэн. Тэгээд аудитын дүгнэлтэд Сэлбэ дэд төвийн төслийн ажил эхлээгүй шалтгаанаар тус үнэт цаасны 500 сая ам.доллараас 400 сая ам.долларыг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ханшаар хөрвүүлж, 1 аравны 329 тэрбум төгрөгийг арилжааны 7 банканд 6-24 сарын хугацаатай, жилийн 12.5-16.1 хувийн хүүтэй төгрөгийн, үлдэгдэл 100 саяыг 100 сая ам.долларыг Худалдаа хөгжлийн банканд 24 сарын хугацаатай жилийн 8 зууны 5 хувийн хүүтэй валютын хадгаламж тус тус байршуулсан байна гэнэ ээ. Тэгээд аягүй ноцтой дүгнэлт.

Хурал даргалагч аа, дахиад нэг минутаа нэмээд авчихъя тэгэх үү.

Ч.Лодойсамбуу: Нэг минутаа нэмээд.

Б.Жаргалан: За нэгэнт энэ бондын валютаар орж ирсэн бондын мөнгө зарцуулагдаагүйгээс энд нэг аягүй ноцтой дүгнэлт байна л даа. Жилийн эцэст арилжааны банкнуудад байршуулсан хадгаламжийн хүүгээс 11.6 тэрбум төгрөгийн хүүгийн авлага бүртгэсэн боловч тус үнэт цаасны хуримтлагдсан хүү 14.7 тэрбум төгрөг, ханшийн зөрүүгээр 2.6 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж, тус бондын эх үүсвэрийг ашиглаагүй нийт 5.7 тэрбум төгрөгийн алдагдалд орсон байна аа. Үүн дээр аудитын байгууллага тодорхой дүгнэлт хэлмээр байна. Мөн Монголбанк энэ хөрөнгийн удирдлагыг хэн хийж байгаа юм бэ? яагаад ийм 24 сар хүртэл хугацаатай бас одоо хадгаламжид байршуулаад байгаа юм бэ гэдэг асуулт байна. Тэгээд нийслэл одоо энэ дээрээ бас тайлбар хиймээр байх юм.

Ч.Лодойсамбуу: Байнгын хороодын хурал давхцаад Магнайсүрэн дарга өөр Байнгын хороонд орчихсон байгаа. Энэ оронд нь хариулах хүнийг үлдээгээд чөлөө авсан байгаа. Монголбанкнаас бол өнөөдөр яг энэ хэлэлцэж байгаа асуудал нь яг нөгөө шууд Монголбанкны хариуцах, харьяалах асуудал биш учраас өнөөдөр ирээгүй байгаа юм байна. Магнайсүрэн дарга аудитаас хэн хариулт өгөх вэ? 7 номер, 7 номерын микрофоныг өгье.

Ц.Наранчимэг: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Үндэсний Аудитын газар Наранчимэг. Бид Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн энэ бонд гадаад зээлтэй холбоотой асуудлыг бол сая гишүүний уншсанаар бид дүгнээд гаргачихсан. Тайландаа одоо энэ зээлийн ашиглалт, зээлээр санхүүжиж байгаа төсөл хөтөлбөрийн мөнгөн урсгалыг бодитой төлөвлөж, зөв ашиглаж байх талаар одоо зөвлөмжийг бол Сангийн сайд болон холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт дүгнэлтээ өгөөд аудитынхаа тайланд тусгачихсан байгаа.

Нийслэлд хэрэгжиж байгаа замтай холбоотой бусад асуудлаар бол манай нийслэл дэх Төрийн аудитын газар гүйцэтгэлийн аудит хийж байгаа. Энэ тайланг холбогдох Байнгын хороонд нь тайлан гараад дууссаны дараа хүргүүлнэ.

Ч.Лодойсамбуу: Жаргалан гишүүн тодруулъя.

Б.Жаргалан: Тэгэхээр дүгнэж хэлэхэд нийслэл 500 сая ам.долларын бонд гаргасан. Тэр бондынхоо мөнгийг бол 24 сая 24 сар хүртэлх хугацаатайгаар нийт 7, 8 арилжааны банканд байршуулсан байна. Гэлээ гэхдээ хүүгийн алдагдлын улмаас тус хөрөнгийг одоо зөв зохистой оновчтой ашиглаж чадаагүйгийн улмаас хүүгийн алдагдал нийт 5.7 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн гэж аудитын байгууллагаас бол дүгнэсэн байна гэж одоо нийтэд нь дүгнэж болохоор байна. Тэгээд цаашдаа бол одоо бид нар энэ улсын төсвийн гүйцэтгэл хэлэлцэхдээ энэ нэгдсэн төсвийн гүйцэтгэлээ хэлэлцээд тэгээд энэ орон нутгийн төсвүүд дээр байгаад байгаа энэ алдаа завхралуудыг тухай бүр бас Улсын Их Хурал авч хэлэлцэж байхгүй бол энэ нийслэл гэдэг байгууллага чинь ерөөсөө бараг улсаасаа илүү том том төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг. Нийслэл дээр явж байгаа 24 мега төсөл нь нөгөө улсынхаа 14 мега төслөөс илүү том дүнтэй, илүү одоо тийм алдаа завхралтай, ийм дутагдалтай ийм төсвүүд яваад байна аа гэдгийг бол зүгээр хэлэхийг хүсэж байна аа. Баярлалаа.

Ч.Лодойсамбуу: Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууя.

Ж.Алдаржавхлан: Хэдэн асуулт байна аа. 1 дүгээрт энэ аудитын тайлан дотор Жавхлан сайд төсвийн орлогын чиглэлээр баримталсан бодлогын хэрэгжилтийг нь нэгтгэн тайлагнаж, үр дүнг нь үнэлж дүгнээгүй гэсэн нэг үг байна. Аудитын дүгнэлт дотор. Энэ одоо юу гэсэн үг юм бол? Орлогынхоо чиглэлээр бодлогоо гаргаж чадаагүй гэж хэлээд байгаа юм уу? Аудитынхан нь хариулж өгнө биз.

2-т нь энэ нүүрсний үнэ маань ер нь одоо яахаар байна аа? Энэ өнгөрсөн жилээс хойш 40 хувиар уначихлаа гэж байна. Тэгээд цаашдаа ер нь прогноз энэ тэр байна уу үгүй юү? Энийг одоо бас мэргэжлийн хүмүүс хариулж өгөөч ээ гэж байгаа юм.

3-т нь мега 14 төсөл том арга хэмжээ хэрэгжинэ гэсэн одоо нөгөө төсөв мөсөв маань хүндэрчихсэн. Энэ ер нь хэрэгжих юм уу, хэрэгжихгүй юм уу. Хэд нь хэрэгжих юм. За энийг нэг хариулж өгөөрэй гэж хүсэж байна.

Аудитын газраас алдаа дутагдлыг илрүүлээд 9 сарын 30 гэх хүртэл үүрэг даалгавар өгсөн гэжээ. 9 сарын 30-нд алдаагаа засаад ирэхэд нь та хэд дахиж Эдийн засгийн байнгын хороонд танилцуулах ёстой гэж би бодож байгаа. Яагаад гэхлээр ингээд сүүлдээ тэрүүгээрээ найраад ч юм шиг алга болчихдог нөгөө алдаа дутагдлууд. Тэрийг яг алдааг нь яаж засуулсан юм гэдгээ бас 9 сард Эдийн засгийн байнгын хороонд танаас хүсэж байна. Тэгээд дарга энэ нартаа сайн хэлээрэй гэж байгаа юм.

4-т нь Эрчим хүчний яамныхан тэр нөгөө цахилгааны үнэ нэмбэл одоо ёстой болох гээд байна гэсэн. Одоо үнэ нэмсэн юу болж байна аа. Нөгөө эрчим хүчний асуудал чинь шийдэгдэж байна уу? Тэр ямар шатандаа явна вэ? Цахилгааны үнийн

өсөлтийг нэг жаахан нэмчихвэл одоо салбар сэргээчих гээд байна гээд байсан. Тэрэн дээр одоо тайлбар өгөөрэй. Би нэмж асууна аа.

За хамгийн сүүлийнх нь энэ Парисын олимпын зардал гээд 27 тэрбум төгрөг гэсэн ийм аудитын тайлан дотор явж байна. Энэ одоо ямар учиртай зардал байсан юм бэ? Би одоо өнгөрсөн жил бас энэ шүүмжлэлтэй хандаж байсан. Тэр баахан дарга, цэрэг олимпод явж байсан тэр хүмүүсийн зардал байсан уу? Та нар үзсэн үү? Яг ямар чиглэлээр үзэв ээ, ямар учиртай зардлууд гарсан бэ? Энийг одоо хэлж өгөөч. За 5 асуулт байна.

Ч.Лодойсамбуу: Эдийн засгийн хөгжлийн сайд Учрал.

Н.Учрал: Энэ төсвийн тодотголтой холбогдуулаад бид нар төсвийн хүрээний мэдэгдлийг өргөн барьсан. Тэгээд нүүрснийхээ үнийг болбол нэг 70 доллароор тооцож байна аа. Тэгэхээр яагаад вэ гэхээр 2025 онд гэхэд энэ Блүүмбергийн терминал дээр нүүрсний үнийн төсөөллийг тооцдог нэг 15 орчим байгууллага байдаг. Энэ 15 орчим байгууллагын 2025 оны нүүрсний жигнэсэн дундаж үнийн төсөөлөл бол 250 ам.доллар байсан. Ингээд өнөөдрийн байдлаар 175 доллар, 30 орчим хувиар буурсан үзүүлэлттэй. Тэгээд иймд энэхүү өөрчлөлттэй уялдуулан нүүрсний үнийн төсөөллийг өмнөх 150 доллароос 70 доллар болгож болбол ингээд бууруулсан гэсэн үг. Тэгэхээр бид нар яг энэ Блүүмбергийн терминал дээр байгаа энэ 15 байгууллагын яг тийм форкаст маягийн одоо чиг хандлагыг тодорхойлдог үнийн төсөөллөөс хараад үзэхээр энэ бол ер нь цаашдаа 13-30 хувь буурна аа.

Тийм учраас 2026 оны төсвийн хүрээний мэдэгдлийг бид нар хэлэлцэхгүй бол болохгүй ээ гэдэг зарчмын дагуу Засгийн газар өргөн мэдүүлсэн. Яагаад гэхээр 2025 оны төсөвт тодотгол хийхийн тулд 2025 оны төсвийн хүрээгээ өөрчилж байгаатай яг адилхан та бидний баталсан 5 сарын 31-нд батлагдсан 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл өөрчлөгдөж байж тэр бүтээгдэхүүний үнүүдийн одоо нийцүүлэх тэр тоонуудыг нийцүүлэх шаардлага үүсээд байгаа байхгүй юу. Тэгэхгүйгээр 9 дүгээр сарын 1-нээс өмнө ирэх оны төсвийг барина гэдэг болбол маш их бэрхшээлтэй. Хэт их өөдрөгөөр төсөөлчихсөн байгаа шүү дээ бид нар. Тэгэхээр ийм давагдашгүй ийм одоо хүчин зүйлүүд шууд утгаараа манай эдийн засагт нөлөөлж байна аа. Тийм учраас 13-30 хувь буурна аа гэж тооцох ёстой.

Тийм ч учраас энэ хэмнэлт хийж байгаа. Гэхдээ зөвхөн зүгээр ингээд нэг хэмнэлт хийгээд байх биш тэр худалдааны экспорт нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын орчноо сайжруулах, тэр төр, хувийн хэвшлийн түншлэлээр явуулах төслүүдээ эрэмбэлэх ажлууд хийгдэнэ. Засгийн газрын хамтарсан Засгийн газрын үед 14 мега төслийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бид нар тусгаж байхад болбол нөхцөл байдал их өөр байсан. Энэ болбол тэр нүүрсний үнээс ч гэсэн харагдаж байгаа юм. Тийм учраас бид нар болбол одоо 14 мега төслүүдийг зайлшгүй эрэмбэлэх шаардлага үүсээд, 14 шалгуур үзүүлэлтээр нэг 4 бүлэгт хуваарилаад, мега төслүүдийг эрэмбэлэх ажлыг хийж байна аа. Энэ юу вэ гэхээр макро эдийн засгийн үнэлгээнүүд хийх ёстой, хийж байна. Санхүүжилтийн эх үүсвэрийн нөлөөллийн үнэлгээ, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, төслийн бэлэн байдлын үнэлгээ гээд нэг 14 шалгуур үзүүлэлтээр үнэлээд эхлэхээр энэ 14 мега төсөл чинь бараг 43.4 их наядын санхүүжилт хэрэгтэй байхгүй юу.

Тийм учраас одоо энэ бүсээ чангалж байгаа үед болбол яах вэ гэвэл одоо бол нөгөө хил холболтын төмөр замын ажлууд нэгэнт эхэлсэн. Газрын тос боловсруулах

үйлдвэрийн санхүүжилтийг Их Хурлаар шийдвэрлэсэн. За Ураны төсөл болбол төсвөөс нэг их ачаалал үүсгэхгүйгээр ингээд явж байна. Эрдэнэбүрэнгийн Усан цахилгаан станцын төсөл гээд энэ 4 төсөл болбол ингээд хэрэгжиж эхэлсэн гэдэгт тооцогдож байгаа. Үүнээс гадна ач холбогдол өндөртэй 5 төсөл байгаа. Энд бол Тавантолгой станц, зэс боловсруулах үйлдвэр, нөгөө Эрдэнэтийн санхүүжилт хийгдэх, тэгээд гангийн цогцолбор, алт цэвэршүүлэх үйлдвэр, нүүрс химийн цогцолбор гээд энэ төслүүд бол ач холбогдол өндөртэй гэж үзэж байгаа.

Бусад төслүүдийн хүрээнд буюу сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэр, Хэрлэн тоонот, Орхон Онги, Эгийн гол, үндэсний хиймэл дагуул, Эрээн цав, Чойбалсан, Баруун-Урт, Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замыг бол энэ жил ирэх жил болбол хойшлуулах. Ийм л одоо бол зайлшгүй шаардлага болбол үүсэж байгаа учраас энэ эрэмбэлж байгаагаа болбол би бас бид нар бас Их Хурал дээр танилцуулаад явна аа. Тэгэхээр зарим ажлуудыг хойшлуулаад, зарим төслүүдээ явуулъя аа гэдэг ийм л одоо зарчимтай байгаа.

Ч.Лодойсамбуу: Аудитаас хариулах уу? 7 номер.

Ц.Наранчимэг: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг. Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлага шийдвэрийн хэрэгжилтийг 30-ны дотор төлөвлөгөөний дагуу хийсэн ажлынхаа тайланг ирүүлээд, тэдгээрийг бид нар үнэлээд, энэ аудитын байгууллагаас өгч байгаа асуудлуудыг бүрэн хэрэгжүүлэхгүйгээс төсвийн ерөнхийлөн захирагчдын тайлангууд дээр гарч байгаа зөрчлүүд нэмэгдээд байгаа учраас бүтэц зохион байгуулалтын шинэчлэл хийж, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хянадаг ийм газартай болж байгаа. Тэгэхээр энэ газар маань энэ тайлангийнхаа биелэлтийг холбогдох Байнгын хороодод төсвийн ерөнхийлөн захирагч нарт энэ чиглэлээр одоо энэ талаар чиглэл өгөх талаар Монгол Улсын Ерөнхий аудитор төслийн тогтоол Их Хурлаас бас тогтоолын төсөл бэлдсэн байгаа. Энийгээ батлуулахаар энэ чиглэлээр аудитын байгууллагаас тодорхой ажил хийж холбогдох Байнгын хороодууд нь хэлэлцэж, хариуцлага тооцуулж байх талаар бас тодорхой ажлуудыг төлөвлөөд ажиллаж байгаа. За Парис 2 мянга...

Ч.Лодойсамбуу: 7 номер нэмж хариулъя.

Ц.Наранчимэг: Парис 2024 олимпын наадамд тамирчдыг оролцуулахаар 27 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 25.2 тэрбум төгрөгийг бол зарцуулсан гэсэн гүйцэтгэл гарсан байгаа. Энэ бол зөрчил биш.

Ч.Лодойсамбуу: Энэ юуны зардал байсан бэ гэж тодорхой асууж байна лээ. Юу юуны зардлууд байна.

Ц.Наранчимэг: Энэ Монгол Улсын шигшээ багийн үйл ажиллагааны тамирчид зарцуулсан зардал байсан.

Ч.Лодойсамбуу: Дан тамирчдад зарцуулсан юм уу?

Ц.Наранчимэг: Тийм, тамирчдад.

Ч.Лодойсамбуу: Дан тамирчдад 27 тэрбум зарцуулсан гэж та хариулж байна шүү дээ тийм үү.

Ц.Наранчимэг: 25.2 тэрбум төгрөг зарцуулсан байгаа. Яг байгууллагынх нь хийсэн төсвийн төвлөрүүлэн захирагчийнх нь тайланг бас хүргүүлж болно. Тэр тайлан дээр дэлгэрэнгүй, тодорхой зөрчилтэй, хязгаартай санал дүгнэлт өгсөн ийм тайлан байгаа.

Ч.Лодойсамбуу: Эрчим хүчний сайд байна уу? Алга байна. Эчим хүчний яамнаас Хуягцогт. 4 номерын микрофон сул байна. 4 номерын микрофоныг. За 2 номер дээр суучихлаа. 2 номерын микрофоныг өгье.

О.Хуягцогт: Эрчим хүчний яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Хуягцогт. Гишүүний асуултад хариулъя аа. Үнэ тарифтай холбоотой 2024 оны төсвийн тодотголоор эрчим хүчний үнэ тариф одоо 2019 оноос хойш нэмэгдээгүйтэй холбоотой эрчим хүчний компаниуд дээр үүсэж байгаа өр авлага хуримтлагдаж, мөн одоо 2024 онд болбол цалингаа тавьж чадахгүй байх хэмжээний ийм хүндрэлд орсон байсан. Ингээд 2024 оны 8 сарын хийсэн тодотголоор болбол эрчим хүчний одоо ААН-үүдэд одоо олгох татаасыг 131 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны гүйцэтгэлээр нийтдээ 221.6 тэрбум төгрөгийн татаас олгосон төсвөөс. Энэ нь бол нийт одоо Эрчим хүчний сайдын багцын санхүүжилтийн 92 хувь байсан. Эрчим хүчний зохицуулах...

Ч.Лодойсамбуу: 2 номерын микрофон нэмж хариулъя, гүйцээгээд хариулъя.

О.Хуягцогт: Энэ нөхцөл байдлыг арилгахын тулд Эрчим эрчим хүчний зохицуулах хорооноос 2024 оны 11 дүгээр сард болбол одоо эрчим хүчний үнэ тарифыг бодит өртөгт нь нийцүүлж хүргэе гэдэг шийдвэр гаргасан. Ингээд 2 дахь зорилт нь болбол цаашид энэ үнэ тарифыг өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлсээс хамаараад индексжүүлэх ийм 2 зорилго тавьсан байсан. Харамсалтай нь болбол энэ шийдвэрүүд 2025 оны 1 дүгээр улиралд буцсан. Ингээд буцсан учраас одоо үнэ тариф нөгөө бодит өртөгтөө хүрч чадаагүй ийм нөхцөлд байгаа. Ингээд 2025 онд болбол одоо алдагдалгүй ажиллах ийм зорилт тавьж байсан боловч энэ үнэ тарифын одоо хойшилсноос хамаараад дахиад татаас хөнгөлөлтийн асуудал болбол энэ төсвийн тодотгол дээр бас хэлэлцэгдэж орж ирж байгаа.

Ч.Лодойсамбуу: Алдаржавхлан гишүүн тодруулъя.

Ж.Алдаржавхлан: Үндэсний аудитын хорооныхон нэг санал байна аа. Та хэд маань одоо саяын ярьсан юмнуудаар ингээд нягтлаад, дахиад мэдээлэл өгмөөр байна. 2-т нь энэ Эрчим хүчний зохицуулах хороо гэж нэг ийм утгагүй байгууллага байгаа. Зөвхөн үнэ нэмэхэд гарч ирдэг, тэгээд алга болчихдог, тусгай зөвшөөрөл олгодог, өөр юу ч хийдэггүй нэг ийм байгууллагууд байгаа. Эрчим хүчний зохицуулах хороо, Усны зохицуулах хороо ч билүү баахан тийм байгууллагууд байгаа. Хэзээ ч хариуцлага хүлээдэггүй. Зөвхөн үнэ нэмэхэд оролцдог бусад үед ингээд далд байдаг ололт байж байдаг хэдэн байгууллага байгаа. Эд нарыг та хэд маань бас нэг үзэж энэ Эдийн засгийн байнгын хороонд бас гаргаж өгөөч гэж хүсэж байна.

2 дугаарт нь Учрал сайд нөгөө Богд уул нүхлэх ажил маань больсон уу яасан бэ? Тэрийг нэг эцэслэж тодруулж өгөөч.

Ч.Лодойсамбуу: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Нийслэлийн хэрэгжүүлэх төслүүд дээр яг саяын одоо 4 бүлэгт хуваагаад 14 шалгуур үзүүлэлтээр төслүүдийг эрэмбэлж байна. Тэгэхээр Богд нүхлэх тэр туннелийн асуудал, тэр ган татлагат гүүр гээд төслүүд болбол хойшилно оо. Эдийн засгийн яам бол ийм л байр суурьтай байгаа. За энийг бол Засгийн газраа оруулаад шийдвэрлэнэ гэж зорьж байна. Ер нь болбол эргээд үр өгөөжөө өгөхгүй, ийм шаардлагагүй санхүүжилтүүдийг одоо зогсоолгохоос өөр арга байхгүй. Нийслэлийн хэмжээнд бол тэр Туулын хурдны зам, бусад одоо хэд хэдэн төслүүд бол явна. Тийм учраас болбол нийслэлийн тэр 24 төслүүдээс болбол эрэмбэлж байгаа. Тэгээд энийг бол Засгийн газарт оруулаад эцэслэнэ ээ гэдгийг хэлье.

Ч.Лодойсамбуу: Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Энэ төсвийн гүйцэтгэлтэй холбоотой ер нь төсөвтэй холбоотой зардлуудыг энэ том том тоон дотор гишүүд шууд дараад танилцчихдаг, дэлгэрэнгүй юмыг нь үзчихдэг ийм боломжоор бол цаашаа хангаж өгөөч ээ гэдгийг би бол зарчмын хувьд тавимаар байна. 1 дүгээрт хот байгуулалт, барилгын одоо бусдад өгөх татаас 20 тэрбум гэж байсан 0 байна. Өнгөрсөн онд гүйцэтгэл дээр. Энэ жил 63 гээд ороод ирчихсэн байсан төсвийн тодотгол дээр. Энэ яг ямар учиртай юм бэ, юу байж байгаад өгөөгүй юм бэ энийг.

2 дугаарт Санхүүгийн зохицуулах хороо 10 тэрбум төгрөгийн 4 тэрбум төгрөгийн төсөвтэй байж байгаад үндсэндээ төсвөө 50 хувиар нэмээд 21 тэрбум гэж орж ирсэн. Тэгэхээр энэ төсөв ингээд шууд 50 хувь нэмэгдэх ямар одоо юу байсан бэ?

3 дугаарт 20 минутын хот 60 тэрбумаар тоног төхөөрөмж авчихжээ. 20 минутын хот. Тоног төхөөрөмж уул нь авахыг ч бид нар чинь хориглоххоогүй билүү хэмнэлтийн хуулиар. Тэгээд энэ юу ороод ирэв. Одоо энэ тоног төхөөрөмж нь юу байдаг юм гэдгийг би тодруулж асуумаар байна.

Тэгсэн мөртөө шинжлэх ухааны хөрөнгө оруулалт 27 тэрбумыг тавьчхаад гуравхан тэрбум. Тэгэхээр энэ юунууд яагаад ийм юутай шинжлэх ухааны хөрөнгө оруулалтууд дээр яагаад ингээд гүйцэтгэл нь ийм бага байгаа вэ гэдэг зүйлийг хэлмээр байна.

Дараагийнх нь за эрчим хүчний салбар дээр ер нь манай зам тээвэр, эрчим хүч, уул уурхай гээд хамгийн их бас одоо хүнд хөрөнгө оруулалттай салбар. Харамсалтай нь энэ дээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг хуульд тавьсны дагуу нийт зардлын 0.5 буюу түүнээс дээш тавих ёстой салбарууд. Энийг үгүй ээ мөн олон хэлсэн дээ одоо өнгөрсөн оны төсөв ярьж байхад. Тэгсэн сая юу болсон бэ. Эрчим хүчний яаман дээр энэ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон технологийн одоо энэ горим технологитой холбоотойгоор осол гарч үндсэндээ 30 гаруй сая.доллар буюу одоо 100 гаруй тэрбум төгрөгөөр авч байсан турбин маань шатаад, одоо энэний үнэ тариф гэх юм бол еще илүү нэмэгдсэн ийм хэмжээний, үлэмж хэмжээний хохирол бид нар учирчхаад сууж байна.

Тийм учраас би цаашдаа юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр энэ манай томоохон салбарын энэ төсвүүд дээр энэ хуулиар хүлээсэн энэ зарим зардлууд яагаад тусахгүй байна вэ? Зам тээврийн салбар хамгийн их осол аваар гардаг

салбар. Тэгсэн мөртөө тэр мэргэжлийн яамд нь ерөөсөө хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн яам дээрээ тодорхой зардал тавьдаггүй юм шиг байна ингээд харахад. Эрдэс баялаг, уул уурхайн салбар хамгийн их осол аваар гарсан. Тийм учраас юмыг бүгдийг нь нөгөө мөнгө талаасаа харж болно. Нөгөө талаасаа хүн талаасаа, үр ашиг талаасаа, эрсдэл талаасаа ганцхан эрсдэл харахад л одоо дахиад эрчим хүчний салбар дээр ийм том хэмжээний эрсдэл учирчхаад одоо бид нар яах вэ, зээл авах уу, яах вэ, ийх вэ гээд л ингээд сууж байна л даа. Тийм учраас энэ тал дээр бол одоо манай дараагийн одоо энэ төсвийн тодотгол дээр хүртэл анхаараарай гэдгийг хэлье. Тэгээд түрүүнийхээ асуултуудад би хариулт авъя.

Ч.Лодойсамбуу: За хэн хариулах вэ? Ням-Осорын Учрал сайд.

Н.Учрал: Ер нь энэ татвар төлөгчдийн мөнгө төгрөгийг эргээд ямар ч үр өгөөжгүй зүйлд зарцуулдагийн л ор гай ингээд л төсвийн гүйцэтгэл дээр жил болгон гардаг л даа. Тэгэхээр энэ яагаад шинжлэх ухааны салбар энэ хөгжлийн яаманд ирсэн юм бэ? Яагаад ирсэн юм бэ гэхээр шинжлэх ухааныг эргэлтэд оруулах гэж, эдийн засгийн эргэлтэд оруулах гэж. Яагаад энэ хөгжлийн яаман дээр оюуны өмч ирсэн юм. Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах гэж байна шүү дээ. Тэрнээс энэ оюуны өмчийн байгууллага гэдэг чинь одоо зүгээр нэг ийм патент бүртгэдэг, зохиогчийн эрхийн гэрчилгээг үйлдвэрлэдэг л нэг ийм газар болчихоод байна шүү дээ. Яагаад өнөөдөр шинжлэх ухааны салбарт оруулсан хөрөнгө оруулалт төсөв мөнгөн дээр ийм харам болчихсон юм бэ гэхээр шинжлэх ухаан чинь өөрөө эдийн засгийн эргэлтэд орохгүйгээр тэгээд эдийн засагт бодитой импакт өгдөггүй болчихоод байна шүү дээ.

Тийм учраас маш олон жил өнөөдөр ингээд нэг судалгаа хийгээд, ингээд нэг санхүүжилт авсан болоод нэг 20, 30 хүний дотор эргэлдээд байна аа гэдэг ийм хардлага сэвдлэг нийгэмд байна. Тийм учраас цаашдаа болбол зүгээр хөгжлийн яам гэж байгаа шүү дээ. Энэ чинь хөгжлийн яам. Тэгэхээр яагаад эдийн засагтайгаа хамт байгаа юм бэ гэхээр тэр коммершиал хийх үйл явц буюу технологи дамжуулах, инновацын үйл ажиллагааг дэмжих чиглэл рүү хандсан төсөл хөтөлбөрүүд санхүүжүүлдэг болох ёстой байхгүй юу. Шинжлэх ухаан, технологийн сан дээр 12.6 тэрбум төгрөг батлагдаад гүйцэтгэл 12.4 авчихсан. Яах вэ гүйцэтгэл сайн байна. Гэхдээ эд нараас хэд нь яг эдийн засгийн эргэлтэд орсон юм. Түрүүн Мандхай гишүүний асуугаад байгаа зөв шүү дээ.

Энэ уул уурхайгаас хамааралтай эдийн засгийг яаж төрөлжүүлэх юм. Тэгэхээр энэ шинжлэх ухаан, технологийн сан чинь өөрөө яг бодитой эргэлтэд орох, эдийн засагт импакт өгөх тэр төслүүдийг санхүүжүүлдэг болж байж тэр ТЭЗҮ чинь, тэр зураг төсөв чинь, тэр судалгаанууд чинь өөрөө эдийн засгийн эргэлтэд ордог зөв зарчим руугаа шилжинэ ээ. Оюуны өмчийн байгууллага ч тэр. Тийм учраас оюуны өмч ч тэр, материаллаг бус баялгийг ч тэр, энэ шинжлэх ухааны салбарыг ч тэр эдийн засгийн эргэлтэд оруулахын тулд л бид нар цаашдаа анхаарна гэдгийг л одоо би бас хэлэх ёстой гэж бодоод байгаа юм. Тэрнээс гүйцэтгэл 99 хувьтай байна аа гэдэг ийм үнэлгээ бол дараа жил бид тавихгүй ээ.

Дараа жил төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхэд энэ төслөөс санхүүжилт авсан судалгаануудын хэд нь эдийн засгийн эргэлтэд орсон юм бэ гэдгийг би ярья л гэж бодож байна. Тэрнээс зүгээр нэг 99 хувьтай гээд мөнгө гаргасан, гараагүйг яриад байх нь утгагүй. Гэхдээ би бас өнгөрсөн, одоо үеийг яриад яах вэ. Ирэх жил болбол арай өөр гүйцэтгэл танилцуулахын тулд энэ шинжлэх ухаан, оюуны өмч, энэ уул

уурхайн салбарыг төрөлжүүлэхэд хувь нэмрээ оруулах энэ салбаруудыг шахаж, шаардаж ажиллана аа гэдгийг бас та бүхэнд хэлье.

Ч.Лодойсамбуу: Санхүүгийн зохицуулах хороо 8 номер дээр суучих уу. 8 номерын микрофоныг өгье.

Т.Жамбаажамц: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя Санхүүгийн зохицуулах хороо Жамбаажамц байна. Санхүүгийн зохицуулах хороо сүүлийн жилүүдэд ялангуяа энэ 2021 онд 6.8 тэрбум, 2022 онд 7.4, 2023 онд 12.2, 2024 онд бол 14.7 тэрбум төгрөгийн төсөв бол батлагдсан байж байгаа. За ингээд гүйцэтгэлээрээ санхүүжээд явдаг. Өссөн үндсэн шалтгаан бол Санхүүгийн зохицуулах хороо орон тоо бол 2020 онд Монгол Улс мөнгө угаах терроризмийг санхүүжилттэй тэмцэх энэ томоохон одоо сорилтууд тулгарсан. Энэ хүрээндээ бол ялангуяа Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын үндсэн одоо уламжлалт 4 салбар бий. Энэ 4 салбар дээр нэмэгдээд 2020, 2021 онуудад Монгол Улсын Их Хурлын одоо баталсан хуулиар Хорооны чиг үүрэг бол нэмэгдсэн байж...

Ч.Лодойсамбуу: За гүйцээж хариулъя.

Т.Жамбаажамц: Хорооны чиг үүрэг нэмэгдсэн. Үл хөдлөх эд хөрөнгө зохицуулалт, үнэт металлын салбар, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хууль гээд ингээд шинэ хуулиуд батлагдаад нийтдээ Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбар бол 7 бие даасан ийм салбар нэмэгдсэн. За үүнтэй холбоотой Санхүүгийн зохицуулах хороон дээр мөнгө угаах терроризмыг тэмцэх одоо тийм хөтөлбөр хэрэгждэг. Яг энэ зохицуулалтын салбарууд дээр. Орон тоо бол 2021 оноос хойш бол огт нэмэгдээгүй. Энэ бие даасан энэ хуулиудын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр бол тодорхой төсвүүд бол нэмэгдсэн. За үүний одоо харьцуулж харвал 62.1 хувь нь бол цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, 28.4 хувь нь бол мөнгө угаах терроризмт тэмцэх хөтөлбөрийн үйл ажиллагаа байдаг. Өөрөөр бол 90 гаруй хувь нь бол энэ 2 зардлаас бол бүрддэг. Байр ашиглалт олон улсын гишүүнчлэлийн хураамж зэрэг ийм зардлууд бол байдаг аа. Баярлалаа.

Ч.Лодойсамбуу: Эрчим хүчний яамнаас бас асуусан байгаа ДЦС-тай холбоотой. 2 номер дээр суучих. 2 номерын микрофоныг өгье.

О.Хуягцогт: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Үйлдвэр, аж ахуйн газрууд дээр тэр ХАБ-ын зардал дээр болбол одоо хангалттай хэмжээнд батлагдаж чадахгүй байна аа гэсэн ийм дүгнэлтийг одоо бас мэргэжлийн байгууллагууд бас энэ ажлын хэсгээс дүгнэлт гаргасан байна аа. Энэ бол одоо яалт ч үгүй бас л тэр алдагдалтай тарифаар явж байгаа зардлаа одоо маш дээд зэргээр хэмнэж ийм ажиллаж байгаа ийм нөхцөлд байсан, одоо ийм үр дагавар гарч байна. Ингээд төсвийн тодотгол дээр болбол яг энэ 3 дугаар цахилгаан станц дээр гарсан ослын одоо улмаас энэ ирэх өвлийг одоо дулаан хангамж, энэ станцын үйл ажиллагааг одоо хэвийн явуулахад шаардлагатай арга хэмжээг Засгийн газраас авч хэрэгжүүлэхээр тодорхой шийдлүүд гаргаж байна. Энэний дараа хэлэлцэх төсвийн тодотгол дээр болбол хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхээр...

Ч.Лодойсамбуу: 20 минутын хоттой холбоотой Хот байгуулалтын яамнаас хариулах уу? Хот байгуулалтын яам байна уу? Яах вэ нийслэлийн л гээд байдаг юм

байна лээ л дээ. Энэ 20 минутын хотыг болбол. За тодруулах уу Эрдэнэбат гишүүн. Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: 20 минутын хот 60 тэрбумаар тоног төхөөрөмж юу авсан юм бэ л гэж би маш тодорхой асуусан нэг. За 2 дугаарт тэр шинжлэх ухааны гээд түрүүн Учрал сайд хэлэх шиг боллоо. Шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалтын их засвар, хөрөнгө оруулалт, их засвар гэж байгаа юм. 27 тэрбум тавьчаад 3 тэрбум буюу гүйцэтгэл нь үндсэндээ нэг 10 хувьтай байгаад байна л даа. Тэгээд энийг яагаад ингэсэн юм бэ гэдэг талаар би бол тодруулж асуусан.

Тэр аж ахуйн нэгж, байгууллагууд дээр зардал тавих бол яах вэ манай өөрөө яам маань, яамд маань энэ том том төсөв зарцуулж байгаа мөртөө тэр салбарын аюулгүй байдал эрсдэлийн асуудал дээр анхаарал хандуулахгүйгээр энэ чинь тогтолцооны хяналтын болон өөр олон асуудал байгаа байхгүй юу. Тэгээд тэрэн дээр би анхаараач ээ л гэж хэлээд байгаа юм. Бүхэл бүтэн том салбарын уул уурхайн салбарын машин тоног төхөөрөмж, хүн хүний одоо амь нас, эрүүл мэндтэй холбоотой юман дээр зардал тавьдаггүй мөртөө тоног төхөөрөмж ч гэдэг юм уу, эс үгүй бол нэг иймэрхүү юман дээр ингээд зардал тавиад байдаг, энэний чинь нөгөө сөрөг эрсдэл нь ингэж гарч ирээд байна аа гэдэг тал дээр л би хэлж байгаа юм шүү. Түүнээс биш одоо...

Ч.Лодойсамбуу: Наранчимэг даргад яг энд хариулах боломж байна уу? байхгүй байна уу? Энэ 60 тэрбумаар ямар нэг төмөр төхөөрөмж энэ тэр авсныг нь гүйцэтгэлээс ингээд харсан тоо мэдээлэл өгөх боломжтой бол өгөөч? За 6 номерын микрофон. 6 номер хариулах юм уу? За 6 номерын микрофон.

Д.Энхболд: Үндэсний аудитын газар Энхболд. 20 минутын хот сайдын багц дээр тоног төхөөрөмж гэдэг ангилал дээр нийтийн тээврийн автобус авахаар 317 тэрбумын төсөв тавигдсан. Гэрээний үнийн дүн бол 300 тэрбумаар гэрээ байгуулагдаад 27.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, энэ төсөл арга хэмжээний хэрэгжилт бол 9.3 хувийн хэрэгжилттэй явж байгаа гэж дүгнэсэн байгаа.

Ч.Лодойсамбуу: 4 номерын микрофон.

Д.Баттогтох: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам, Шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Баттогтох. Тэгэхээр манай салбарын тухайд болбол хөрөнгө оруулалт, их засвартай холбоотой гүйцэтгэлүүд болбол 90-ээс дээш хувьтай байгаа. Тэгээд саяын тоо болбол андуурагдсан байх гэж бодож байна. Ер нь бол түрүүн би дурдсан 2024 онд цогцолборт оруулсан хөрөнгө оруулалт болбол 23.9 тэрбум төгрөг зарцуулагдсан. Энэ жилийн тухайд болбол хөрөнгө оруулалт дээр болбол тодотголоор нэлээн хасагдаж орж ирж байгаа. Эрдэм шинжилгээний зардлын тухайд бол түрүүн сайд дурдсан. Бас 90-ээс дээш хувьтай маш сайн гүйцэтгэлтэй байгаа.

Ч.Лодойсамбуу: Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо үг хэлэх Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Лувсанжамц гишүүнээр тасаллаа. Пүрэвийн Батчимэг гишүүн үг хэлье.

П.Батчимэг: Эдийн засгийн байнгын хороо бол эрхлэх ажлынхаа хүрээнд улсын төсөв хэлэлцэх, тэгээд тодотгол хэлэлцэх мөн одоо төсвийн гүйцэтгэлийн

талаар одоо тайлан сонсох хамгийн гол үндсэн чиг үүрэгтэй. Өнөөдөр бол ер нь гишүүд ч цөөхөн байна. Олон олон одоо ажлын хэсгүүд тэгээд л Байнгын хороо давхардчихсан байх. Энд одоо хүрэлцэн ирсэн энд төрийн төв байгууллагын төрийн захиргааны төв байгууллагын энэ албан хаагчид маш олноороо ирдэг. Тэгээд гүйцэтгэл өнөөдөр ярьж байгаа энэ чухал асуудал дээр ер нь зарим хариултууд маш оновчгүй. Одоо яг ингээд урд оны төсвийн гүйцэтгэл яг ямар байдалтай хэрэгжсэн бэ гэдгийг өнөөдөр маш чухал хэлэлцэх өдөр байхгүй юу. Ингэж гүйцэтгэлийг өнөөдөр бодитой дүгнэж, харж тэгээд тэрнээсээ дараагийн одоо төсөв энэ тодотгол руу орох ёстой л доо.

Монгол Улсын Засгийн газар шинээр байгуулагдсантай холбоотой Үндэсний Ерөнхий аудитор өнөөдөр томилогдсон байгаа. Энэ Ерөнхий аудитор бол одоо энэ өнөөдрийн энэ ажилд маш тодорхой байр суурьтай оролцох ёстой. Тэгтэл ингээд л хурлаас хурал гээд гараад явсан шалтгаантай алга байх жишээтэй. Одоо энэ 2023 онд хийсэн аудитор энэ дүгнэлтээр нийт 24 зөвлөмжийг хүргүүлсэн гэж байгаа юм. Бүрэн хэрэгжүүлсэн 9, хэрэгжүүлэх шатандаа 6, зөвлөмж хэрэгжүүлээгүй 9 нийт одоо энэ ажлын хэрэгжилт нь 54.3 хувьтай. Ийм байхад энэ төсвийн сахилга бат, төрийн санхүү ийм задгай сул төсөвлөлт төлөвлөлт ийм муу явж байхад өнөөдөр дараагийн тодотгол бид ингээд яриад сууж байх юм уу. Энэ байдлаа одоо хэзээ засаж залруулах юм.

Ер нь энэ одоо төсвийн энэ замбараагүй төсөвлөж байгаа байдал, энэ сахилга бат санхүүгийн сахилга бат хангалтгүй байгаа дээр энэ холбогдох байгууллагууд ямар дүгнэлт хийж цаашдаа ажиллах юм бэ. Одоо энд бид нар өнөөдөр Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан хараад сууж байна. Энэ том зузаан ном шиг. Гишүүдийн уншиж мэдэх, танилцах эрхэд хязгаарлалт хийсэн, тулгаж өгдөг. Тэгээд одоо энэ тайланг хэлэлцэж байхад бид нар зүгээр улсын төсвөөс улсын төсвөөр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хийсэн хөрөнгө оруулалтын л хэрэгжилт хийсэн тайлан л хэлэлцээд байна. Орон нутгийн төсөв тэнд хамаарагдах одоо өнөөдөр Нийслэлийн Засаг дарга байхгүй, холбогдох хүмүүс байна уу. Бид яагаад зөвхөн улсын төсөв яриад байгаа билээ.

Улсын төсвөөр хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл тайлан өнөөдөр энд Нийслэлийн Засаг дарга байх ёстой шүү дээ. Ингэж одоо ийм байдалтай явж, энд маш олон зөрчил байгаа байхгүй юу. Энийг одоо цаашид ер нь хэрхэн анхаарч энэ аудитын байгууллагын хийсэн дүгнэлтийг Сангийн яам, Эрчим хүчний яам, энэ Эдийн засгийн яам, голлох энэ гол чиг үүргийн яамнууд маш одоо юутай дүгнэлттэй ажиллахгүй болбол энэ цаашид ер нь энэ төсөв хэлэлцэх, тодотгол хэлэлцэх ажил бол ингэж явж урагшлахгүй ээ, бахь байдгаараа л ингээд суух юм байна. Баахан одоо хүмүүсийг ажлын цагаар нь авчраад суулгачихдаг, том том зузаан цааснуудаар цаасаар гишүүдийг ингээд тэврүүлээд суулгачихдаг. Яг хэлэлцээд ямар үр дүнд хүрэх юм, яг гүйцэтгэл ямар явж ирсэн энэ бүх юмнууд дандаа бүдэг ингээд хоцорчхож байгаа юм. Тэгээд ингээд хуралд ирэхгүй үл хүндэтгэнэ.

Ч.Лодойсамбуу: Ганзоригийн Лувсанжамц гишүүн үгээ хэлье.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе ээ. Ер нь намрын чуулганаас хойш хаврын чуулган ч гэсэн оролцуулаад яамнуудаас ерөөсөө 1 л юм асуугаад байгаа шүү дээ. Нэгдүгээр хавсралтаа л бид нар ярих ёстой, хэдэн төгрөг, хаана, юунд зарцуулсан, зарцуулж дууссан, дуусаагүй тэр бол 10 дугаар асуудал. Шалгуур үзүүлэлтийн 1 дүгээр хавсралтаа л хэдүүлээ ярилцаад л явах ёстой. Тэгээд өнөөдөр одоо тайлан

ингээд орж ирж байгаа 1 дүгээр хавсралттай холбоотой нэг ч юм байхгүй. Яамдууд ийм төгрөг зарцууллаа эсвэл зарж дуусаагүй байна аа л гэсэн. Эсвэл тавиад гараад ирсэн юмнууд нь ингээд ийм болсон, болоогүй алдагдалтай зарцуулсан байна аа гэсэн ийм юм яриад байгаа юм. Яах вэ аудит бол энэ тайлангаа хийх нь зөв л дөө. 2024 онд 1 дүгээр хавсралт гээд баталж байгаа шүү дээ хэдүүлээ. Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт гээд.

Уг нь энийгээ л бид нар ярих ёстой, нөгөөдөр нэгдсэн чуулган дээр энэ талаар асууя гэж бодож байна. Ялангуяа би өөрийнхөө салбарын яг чанарын чухал ийм асуултууд байгаа. Дэд бүтцийн салбарууд гэсэн ийм зүйлүүд дээрээ чанараараа үр дүн яаж ахисан юм бэ гэдэг зүйлийг л асуумаар байна. Хэдэн төгрөг зарсан болбол үнэхээр 10 дугаар асуудал.

Баталсан бичиг баримтынхаа дагуу тайлангаа гаргадаг байх ёстой шүү дээ тийм ээ та бүхэн маань бүгдээрээ мэдэж байгаа. Тийм 1 дүгээр хавсралтынх нь тайлан нь байхгүй шүү дээ. Ийм байхад одоо ямар ч асуулт асуух вэ. Тэгээд та хэд маань хэрвээ 1 дүгээр тайлангаа ямар нэгэн байдлаар яам дотроо өөрсдөө гаргасан байгаа болбол асуух миний асуух асуултад тэрнийгээ бэлдээд ирээрэй гэж одоо захиас л хэлье дээ. Тэгээд цаашдаа ер нь 2025 оны гүйцэтгэл орж ирэхэд 1 дүгээр хавсралт байхгүй байх юм бол ер нь ийм асуудлыг ярилцах хийгээд ч хэрэггүй гэж бодож байна. Энэ асуудлыг хойшлуулаад л явчихсан нь илүү зүгээр.

Ч.Лодойсамбуу: За гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн зарлагын дэд хорооны гишүүн Батболд уншиж танилцуулна аа. Ажлын хэсгийнхэн баярлалаа.

17:08

Ч.Лодойсамбуу: Дараагийн асуудалд орёе.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье ээ.

Ажлын хэсэг үргэлжлүүлээд энэ дээрээ бас суух юм байна шүү ажлын хэсэг. Одоо Жавхлан сайд маань нөгөө нэг өөр Байнгын хороо бас давхцаж байгаа. Одоо ирж байгаа. Жавхлан сайдыг ирэхээр танилцуулга уншуулна.

Төслүүдийн талаарх хууль санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засаг, хөгжлийн сайд Ням-Осорын Учрал танилцуулна аа. Сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхий дахинд үүсээд байгаа сорилт бэрхшээлийн Монгол Улсын эдийн засгийн нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, мөн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголын төслийг боловсруулж, 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Эдийн засгийн сорилт хүндрэлийг даван туулахад төсвийн сахилга бат, үр ашигтай зарцуулалт онцгой чухал үүрэгтэй. Тиймээс хэмнэлтийн тодотголд бүх шатны төрийн байгууллагуудын тэвчиж болох зардлыг хэмнэх зарчмыг баримталлаа. Цомхон бүтээмжтэй төртэй байхын тулд төрийн албаны орон тоог 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн 9 хувиар бууруулахаар тооцлоо.

Мөн төсвийн байгууллагын тээвэр, шатахуун, дотоод томилолт, хичээл, үйлдвэрлэлийн зардал, төрийн өндөр дээд болон өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, тавилга, эд хогшил худалдан авах урсгал засвар хийх болон багаж техникийн зардал, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад олгодог татаасын зардал, байгууллагаас олгох нэг удаагийн болон бусад төрлийн тэтгэмж, урамшуулал, хөтөлбөр, арга хэмжээний зардал зэргийг хэмнэхээр тооцож холбогдох өөрчлөлтийг тодотголын төсөлд тусгалаа.

Энэ хүрээнд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцын төсөв 2025 оны батлагдсан төсвөөс урсгал зардал 17 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 15 тэрбум төгрөгөөр, нийт 33 тэрбум төгрөгөөр бууруулахад төсөвлөсөн болно. Салбарын хэмжээнд 176 орон тоо буурч, 1910 орон тоотой байхаар тооцлоо.

Зам, тээврийн сайдын багцын төсөв 2025 оны батлагдсан төсвөөс урсгал зардал 1.5 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 76 тэрбум төгрөгөөр, нийт 77.5 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн болно. Тус салбарын төрийн албан хаагчийн тоог 9 хувиар буюу 26 орон тоогоор бууруулж, 256 орон тоотой байхаар тооцлоо.

Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдын багцын төсөв 2025 оны батлагдсан төсвөөс урсгал зардал 2.2 тэрбум төгрөгөөр, Хөрөнгийн зардал 21.1 тэрбум төгрөгөөр, нийт 23.3 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөлөө. Тус салбарын төрийн албан хаагчийн тоог 9 хувиар буюу 9 орон тоогоор бууруулж, 122 орон тоотой байхаар тооцлоо.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын багцын төсөв 2025 оны батлагдсан төсвөөс урсгал зардал 1.7 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 0.2 тэрбум төгрөгөөр, нийт 1.9 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөлөө. Тус салбарын нийт төрийн албан хаагчийн тоог 9 хувиар буюу 33 орон тоогоор бууруулж, 332 орон тоотой байхаар тооцлоо.

Эрчим хүчний сайдын багцаас төрийн албан хаагчдын орон тоог 9 хувь буюу 10 орон тоогоор бууруулж, 100 орон тоотой байхаар тооцлоо. Дээрх хэмнэлтийн бодлогын хүрээнд Эрчим хүчний сайдын багцаас 739.6 сая төгрөгөөр бууруулахаар төлөвлөлөө. Харин ДЦС 3 ТӨХК-ийн өндөр даралтын турбин цехийн барилга байгууламжид гарсан гэнэтийн аваар осол гал гарч томоохон эрсдэл үүссэнтэй холбогдуулан гамшиг ослын хохирол, хор уршгийг бууруулах, өвлийн их ачаалал, дулаанжуулалтын тоноглолын бэлэн байдлыг хангах зайлшгүй шаардлагын хүрээнд 35.5 тэрбум төгрөг, дулааны станцууд болон эрчим хүчний компаниудын найдвартай ажиллагааг хангах зорилгоор 9.1 тэрбум төгрөгийг, эрчим хүчний шөнийн тарифын хөнгөлөлтийн хугацааг уртасгасантай холбогдуулан 26 тэрбум төгрөгийг нэмж тусгалаа.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайд төрийн чиг үүргийг оновчтой зохион байгуулж, цомхон, чадварлаг бүтцээр ажиллах зорилт тавьж, зарим сайдын чиг үүргийг ойролцоо чиг үүрэг эрхэлдэг харилцан уялдаа бүхий үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа бусад сайдын эрхлэх асуудалд шилжүүлэх болсонтой холбогдуулан төсвийн тодотголын төсөлд зарим өөрчлөлтийг тусгалаа. Тухайлбал, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын чиг үүрэгт, 20 минутын хотын хөгжлийн асуудлыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын чиг үүрэгт тус тус шилжүүлж, холбогдох төсвийн өөрчлөлтийг тусгалаа.

Ийнхүү 2025 оны төсөвт тодотгол хийснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3 их наяд 260 тэрбум төгрөгөөр бууруулж, 30 их наяд 209.9 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 1 их наяд 856.5 тэрбум төгрөгөөр бууруулж, 31 их наяд 875.1 тэрбум төгрөгт хүргэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 365.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 1.5 хувийн алдагдалтай болж байна аа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Ч.Лодойсамбуу: Төслүүдэд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна аа. Ерөнхий аудиторын микрофоныг нээе. Ажлын хэсгийн 7 дугаар микрофон.

С.Магнайсүрэн: Гишүүдийн өдрийн мэндийг айлтгая. Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Засгийн газраас 2025 оны 6 сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгөх аудитыг хийж гүйцэтгэлээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах 9 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт 98.2 тэрбум төгрөгөөр, зарлагыг 97 тэрбум төгрөгөөр тус тус бууруулахаар төлөвлөсөн байна аа. Байнгын хороо энэхүү төслийг хэлэлцэж шийдвэрлэхдээ дараах асуудалд анхаарал хандуулахыг санал болгож байгаа. Үүнд:

Уул уурхайн салбарын орлого гадаад зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч тодорхой бус эрсдэлтэй байгаа учир Уул уурхайн бус орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчлах, татварын хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах, хураалт үйлчилгээг сайжруулах.

2-т нь төрийн албан хаагчдын тоог чиг үүргийн давхардал, ажлын байрны ачаалалд бүрэн шинжилгээ хийлгүйгээр нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан бүх төсвийн ерөнхийлөн захирагчдын орон тоог жигд 9 хувиар бууруулахаар тооцсон нь төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулж болзошгүй. Иймд төсвийн ерөнхийлөн захирагчдад хариуцсан салбартаа чиг үүргийн шинжилгээ, ажлын байрны ба бүтээмжийн үнэлгээг хийсний үндсэн дээр ажлын ачааллыг оновчтой хуваарилах зорилгоор харьяа байгууллагуудынхаа орон тоонд зохицуулалт хийх боломж олгох асуудлыг судалж үзэх.

3-т нь төсвийн тодотголтой хамт Улсын Их Хуралд өргөн барьсан тогтоолын төсөлд 2025, 2026 оны төсвийн жилд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалын орон тоо бий болгохгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулах зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх гэж заасан.

Энэ нь чиг үүргийн судалгаа хийсний үндсэн дээр ажлын ачааллыг нягтруулж, орон тоогоо зорилтот түвшин хүртэл нэгэнт бууруулсан байгууллагуудад сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх нь тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь сөргөөр нөлөөлж болзошгүй байгааг анхаарах.

4-т нь төсвийн ерөнхийлөн захирагчдын харьяа сул орон тооноос бусад цомхотголд орж буй албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн дагуу ажлаас чөлөөлөгдсөний 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийн зардал шаардагдахаар байгааг энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хамтад нь шийдвэрлэх гарц шийдлийг олох.

Дээрх саналуудаас гадна төсөвт тодотгол хийх нөхцөл байдал үүссэн тохиолдолд төрийн аудитын байгууллагаас аудитын үйл ажиллагааны үе шатны стандартын дагуу хянаж, дүгнэлт гаргахад цаг хугацааны хувьд одоо хязгаарлагдмал байх тохиолдлууд гарч байгааг анхааралдаа авч, дүгнэлт гаргаж, Их Хуралд хүргүүлэх зохистой хугацааг Төсвийн тухай хуульд тусгаж өгөх шаардлагатай байна аа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэснээ үүгээр танилцуулж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ч.Лодойсамбуу: Ажлын хэсэг хэвээрээ. Ажлын хэсгийнхээ гишүүдийг урьж байна. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Хууль санаачлагчдаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуух асуулттай гишүүд нэрээ өгье өө. Соронзонболд гишүүнээр тасаллаа. Соронзонболд гишүүн асуултаа асууя.

Л.Соронзонболд: Нэг л асуулт асууя аа. Энэ боомттой холбоотой төсөв дээр тодотгол хийгдэж байгаа асуудал байгаа юу гэдэг нэг ийм асуулт байна. Ялангуяа одоо энэ бид нар боомтын сэргэлт гээд олон жил ярьсан. Тэгээд одоо яг сэргэлттэй холбоотой яг газар дээр нь яваад үзэхээр боомтын маань ажил бас ганц хоёрхон хүнтэй, хүн хүч багатай, төсөв зардал багатай нэг ийм байдалтай байгаад байдаг. Гэтэл гол нь эдийн засгийнхаа экспортыг дэмжих зорилгоор боомтоо сэргээе гэж бид нар яриад байдаг. Энэ дээр одоо ямаршуу төсвийн тодотгол оруулахаар тусгасан бэ гэдгийг асууя аа.

Ч.Лодойсамбуу: Хэн хариулах вэ? 4 номерын микрофон.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя аа. Боомттой холбоотойгоор бол төсвийн тодотгол дээр бол 1 дүгээрт болбол Боомтын сайдын эрхлэх асуудал бол Сангийн сайдын эрхлэх асуудал руу бол шилжиж байгаа. Боомтын үндэсний зөвлөл гэж хуулиараа байгаа. Үндэсний зөвлөлийг бол Сангийн сайд ахалж байгаатай холбоотойгоор бол ингэж орж байгаа.

2 дугаар өөрчлөлт болбол Боомтын сайдын ажлын албыг болбол татан буулгаж байгаа. Тэгэхлээр энэ ажлын алба маань бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр байсан. Сайдтайгаа нийлээд 16 хүн байсныг бол татан буулгаад явчхаж байгаа.

3 дугаар асуудал болбол боомттой холбоотойгоор бол гадаад зээлийн эх үүсвэрээс бол бас нэлээд ажлууд явж байгаа. За ялангуяа боомт руу чиглэсэн авто замын төслүүд, мөн боомтын шинэчлэлийн асуудлууд байгаа. Гадаад зээлтэй холбоотой төслүүдийн хэмжээг бол бид бууруулаагүй байгаа. Тэгэхлээр том төслүүдийн хувьд бол явчихна.

4 дүгээр асуудлын хувьд бол боомттой холбоотойгоор болбол боомтын захиргаа гэж байгууллага байдаг. Илүү боомт дээр очиж хэрэгцээ шаардлагыг

судлах ийм чиг үүрэгтэй, мөн зохион байгуулалтын арга хэмжээ авах ёстой байгууллага байгаа. Энэ байгууллага бол 9 хувийн цомхотголд орон тоо нь буураад, үлдсэн зардал нь болбол Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд очсон байгаа. Ийм өөрчлөлтүүд байгаа. Баярлалаа.

Ч.Лодойсамбуу: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Энэ удаагийн төсвийн тодотгол болон хамт өргөн мэдүүлсэн холбогдох хуулийн төслийг бол одоо ер нь агуулгын хувьд бол дэмжиж байна аа. Бид хэд бас нөгөө яг үнэнээ ярьж чадахгүй, ерөнхий одоо нөхцөл байдалд тааруулж, гал унтраах, эргээд энэ улс төрийн амлалтдаа живэх ийм л нөхцөл байдалтай тулсан. Тэгээд өнөөдөр яг одоо уул уурхайгаас хамааралтай тэр дундаа ганцхан нүүрснээс хэт хамааралтай эдийн засаг дээр бол одоо бодит сигнал өгч байна. Энийгээ зөв төлөвлөж, зөв эрсдэлээ тооцохгүй бол ерөнхийдөө одоо бүх салбарт бол хүндрэлүүд үүсэх юм байна аа гэдэг ийм том сигнал өгч байгаа учраас энэ дээр одоо онцгой анхаарах зайлшгүй шаардлага бол байгаа нь харагдаж байна.

Тэгэхээр энэ цаашдаа би яах вэ зүгээр төсвийн тодотгол батлаад өнгөрөх бол нэг. Тэгэхээр ийм нөхцөл байдлуудад цаашдаа орохгүйн тулд бид яах вэ гэдгийг л одоо маш сайн ярилцаж бас явах зайлшгүй шаардлага байна. Энэ дээр уул уурхайн бодлого, уул уурхайн салбар дахь тэр төрөлжилтийн асуудлыг илүү нарийн сайн ярихыг л одоо Засгийн газар онцгой анхаарч, ирэх намрын чуулганыг ашиглаач ээ гэж хүсэж байгаа юм. Ирэх намар бид хэд уул уурхайн салбар дээрх бодлогоо тодорхой байхгүй бол дараа жил яг өдийд дахиад л ийм юм яриад сууж байна. Тэгэхээр энийг одоо бүр онцгой анхаараач ээ. Энэ дээр одоо бол Уул уурхайн яам ямар ямар ажлууд төлөвлөж байна гэдэг нэг зүйлүүдээ бас тодорхой хэлчхээч.

2 дугаарт нэг зүйл байна аа. Энэ төрийн хэмнэлт. Би тэгээд энэ Магнайсүрэн даргын санал дүгнэлт дээрээс гарч байгаа нэг зүйлтэй санал нийлж байна. Механикаар ингэж хасаж байгаа, дээрээс нь тэр тэтгэвэрт гарсан байдаг юм уу, хэмнэгдсэн орон тоонд дахиж нөхөлт хийхгүй гэдэг зүйлүүдийг бид зарчмын хувьд шийдэх арга барилаа зөв олмоор байна. Тэгэхээр өнөөдөр Засгийн газар дээр чиг үүргийн тооллого бас хийж байсан удаа байдаг. Тэгэхээр би төр дээр ерөөсөө энэ чиг үүргийн тооллого хийх асуудлыг Улсын Их Хурлаас ажлын хэсэг гарч нэг шийдээд зарчмаа тогтоохгүй бол болохгүй байна аа.

Тэгэхээр Засгийн газрынх нь хувьд нэг тоолъё. Шүүх эрх мэдлийн байгууллагын хувьд нэг тоолъё. Энэ дээр цэц прокуророо оруулаад. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага дээр нэг чиг үүргийн тооллого хийе. Дээрээс нь Улсын Их Хурлаас томилогддог, удирдлагууд нь томилогддог байгууллагууд дээр чиг үүргийн тооллого хийе. Өнөөдөр Санхүүгийн зохицуулах хороо орон нутагт салбаргүй учраас санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалж чадахгүй, батлагдсан хуулиудыг тэнд хэрэгжүүлж чадахгүй байж байхад Монголбанк 700 хүнтэй сууж байгаа шүү дээ. Тэгээд ямар ч төсвийн гадуур, хяналтгүй, дуртай үедээ орон тоогоо нэмдэг, дуртай үедээ төсвөө нэмдэг. Тэгэхээр энийг энэ зарчим чинь одоо бүгд жигд биш байж чадаад байгаа байхгүй юу. Тэгэхээр би бас одоо Байнгын хорооны санал, дүгнэлт дээр ороосой гэж хүсэж байна. Хурал даргалагч анхаарч өгөөсэй.

Улсын Их Хурал дээрээс энэ бүх төрийн байгууллагуудын түвшин түвшин дэх чиг үүргийн тооллогыг 4 чиглэлээр хийе ээ. Нутгийн өөрөө удирдах ёс, Засгийн газар

буюу гүйцэтгэх эрх мэдэл, тэгээд Улсын Их Хурлаас томилогддог байгууллагууд, ингээд дээрээс нь шүүх эрх мэдлийн байгууллага гээд. Тэрэн дээр ямар арга зүйгээр энэ ачаалал, чиг үүрэг байна, тэнд нь тохирсон ямар хүний нөөцийг ер нь цаашдаа байх ёстой, ямар арга зам...

Ч.Лодойсамбуу: Нэмэлт нэг минут.

П.Сайнзориг: Ямар арга замаар тэрийг нэмэгдүүлдэг байх вэ гэдгийг жигд авч үзэх, зарчимтай авч үзэх энэ одоо асуудлыг жигд явахгүй бол ташраар нь ингээд явчихдаг. Дандаа ингээд салбарууд доголдох, үүний цаана бас хүний эрх зөрчигдөх, магадгүй эдийн засаг, санхүүгийн эрсдэлүүд хэрэглэгч дээр илүү их очих л ийм эрсдэлүүд байна аа. Тэгэхээр энийг одоо бүр протоколд үлдээгээд би өөрөө бас энэ ажлыг ахалж явъя гэж бодож байна. Тэгээд ийм зарчмаар явахгүй бол бид хэд яах вэ нэг ийм шуурган дунд л жоохон яриад л явчхаж байна. Тэгээд ач холбогдол өгч, зарчим тогтоож, нэг арга зүйтэй болохгүй бол заримдаа нэмдэг, заримдаа ингээд ямар ч зарчимгүйгээр ташраар нь хасчихдаг, заримдаа эсвэл хэн лобби ихтэй салбарууд нь ингээд хүн хүчээ нэмээд явчихдаг, эсвэл сүүл рүүгээ аль нэг салбар нь хяналтгүйгээр 700 хүнтэй болчихдог ийм л зүйл байна. Тэгээд Монголбанкнаас эхлээд ямар ч хяналтгүй явж байна. Энэ асуудлыг хэн ч ярихгүй байна. Ийм байж болохгүй ээ л гэдэг зүйлийг би зарчмын хувьд хэлээд байгаа юм аа. Тэгээд энэ төслийг дэмжиж байгаа.

Ч.Лодойсамбуу: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Тийм Сайнзориг гишүүний ярьж байгаа зөв өө. Энэ 14400 төрийн албан хаагч гэдэг тоо хаанаас гараад ирсэн юм бэ гэж хүмүүс их асууж байгаа юм. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд төрийн хэмнэлт бүтээмжийн зөвлөл ажиллуулсан. Чиг үүргийн шинжилгээ хийсэн. Чиг үүргийн шинжилгээ хийхээр 6 мянган сул орон тооны асуудал яригдсан. Дахиад жинхлээгүй түр орлон гүйцэтгэгч нар гэж томилгоонууд байна. Ингээд үлдсэн 14400-гийн 6 мянган сул орон тоо гэхээр үлдсэн тоо нь яагаад ингэж том тоо гараад ирэв ээ гэхээр ерөөсөө 1 ажлыг 3 хүн хувааж хийдэг, чиг үүргийн давхардалтай байдал болбол одоо бүр хэрээс хэтэрсэн. Жишээ нь 2018 онд батлагдсан чиг үүрэг дээр дахин хуваарилах аргачлалын дагуу үнэлгээ хийсэн ийм том судалгаа байгаа. Энэ үнэлгээн дээр болбол бодлого боловсруулах, зохицуулалт хийх, зохион байгуулах, санхүүжилт хийх, хүний нөөцийн бодлого, хяналт шинжилгээ, үнэлгээ үйлчилгээ үзүүлэх гээд ангилалтай. Гэтэл энийг ингээд чиг үүргүүд давхцаад эхлэхээр юу болдог вэ гэхээр нөгөө салбар дундын уялдааг зохицуулах хороо гэдэг шиг сүүлдээ Үндэсний хороонуудыгаа зохицуулах үндэсний хороотой болох хэмжээ рүүгээ очиж байгаа. Чиг үүргийг хуваагаад эхлэх.

Боомтын сэргэлтийн үндэсний хороо гээд байлаа гэхэд Сангийн яамтай юугаараа холбогддог, гааль холбогддог нөгөө талаасаа Хууль зүйн яамтай юугаараа холбогддог вэ хилээрээ холбогддог. Ингээд ерөөсөө бүх давхардсан чиг үүргүүд нь одоо ингээд нөгөө оновчлохгүй болбол нэг ийм байдалд хүрчихсэн. Тийм учраас энэ 14400 гэдэг тоо болбол өөрөө өнөөдөр төрд тангаргаа өргөөд, ажлаа хийж байгаа хэн нэгэнтэй хамааралтай биш байхгүй юу. Хэн нэгэнтэй хамааралтай биш. Энэ бол зөвхөн сул орон тооны асуудал, чиг үүргийн одоо оновчлоогүй байгаатай холбоотой асуудал. Тэгээд бид нар олон жил Рэ-инженеринг гэж хэлээд ярилаа. Рэ-инженеринг гэдэг үг нь бараг одоо элэгдлээ. Одоо ер нь шинэчлэл, өөрчлөлт, реформ, сэргэлт мэргэлт гэдэг үг чинь ингээд элэгдээд дууслаа шүү дээ.

Гоё сайхан үггүй боллоо. Тэгэхээр энэ Рэ- инженеринг гэдэг чинь юу юм бэ гэхээр хяналт хийгээд, мониторинг хийгээд тэр үйл ажиллагааны хөтөлбөр дээр дизайн хийгээд, мониторинг хийгээд, деволюшн хийгээд, ард нь Рэ-инженеринг хийе гэсэн чинь энэ цикл чинь алдагдчихсан. Тийм учраас энэ Эдийн засаг, хөгжлийн яам яагаад энэ хяналтын механизмыг хэрэгжүүлэх гээд байсан юм бэ гэхээр ерөөсөө л энэ Ре-инженеринг гэдэг дээрээ л анхаарал тавина, чиг үүргийн давхардлыг арилгана.

Цаашлаад бид нар яг энэ Сайнзориг гишүүний хэлж байгаагаар ер нь бол хүний нөөцөө өөрөө холбогдох институц нь хариуцдаг жишиг рүү явахгүй бол болохгүй нь ээ. Засгийн газар өөрөө хүний нөөцөө мэддэг. Их Хурал өөрөө хүний нөөцөө мэддэг, шүүх өөрөө хүний нөөцөө мэддэг зарчим руу явахгүй болбол энэ чинь одоо бүр хоорондоо холилдоод, учир зүйгээ олохоо больчихоод байна шүү дээ. Тэгээд төрд тангаргаа өргөөд ажиллаж байгаа хүн байгаад байтал хажууд нь нэг Үндэсний хороо зөвлөл гэдэг нэртэй юм байгуулагдаад тэр хүнээс илүү цалин аваад явахаар хэн энэ төрд чинь зүтгэх юм бэ гэдэг асуудал л яригдаад байгаа юм.

Тийм учраас бид нар зөвхөн Үндэсний хороо зөвлөл гэхэд л 28 хүн Үндэсний хороо зөвлөл буулгахад л 311 тэрбум төгрөг хэмнэж болж байгаа байхгүй юу. Энэ чинь бас том тоо шүү тийм. Том тоо байхгүй юу. Тэгэхээр гэтэл энийг бас хавтгайруулж болохгүй. Жишээ нь нээлттэй засгийн зөвлөл, авлигатай тэмцэх хөтөлбөр, Жендерийн үндэсний хороо гээд олон улсад хүлээсэн үүрэгтэй зөвлөл, хороодууд байна шүү дээ. Гэхдээ энэ дээр заавал ажлын алба байх ямар шаардлагатай юм. Сангийн яам өөрөө хариуцаад л, тэр боомтынхоо асуудлыг хариуцаад л, тэр ажлын албагүйгээр хариуцаад явж болно гээд энэ зарчим руугаа явах ёстой учраас энэ хөгжлийн яам гэж байгаа бол цаашаа бид нар энэ Ре-инженерингээ хийнэ. Тийм учраас энийг болбол одоо Их Хуралтай ингээд хамтарч ажиллаяа л гэж хэлье.

Ч.Лодойсамбуу: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууя.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Нэг хэд хэдэн асуулт асуумаар байна аа. Юун түрүүнд бол энэ төслийг бол хасах тодотгол оруулж ирж байгаа нь сайн байна аа. Тэгээд Эдийн засгийн хөгжлийн яамнаас асуумаар байна. Ялангуяа тэр Төрийн нарийн бичгийн дарга олон жил ажилласан өнгөрсөн жилийн тодотголыг оруулж ирсэн хүн байгаа. Та яг жилийн өмнөх хэлж байсан зүйлээ нэг санах ёстой байх аа гэж бодож байна. Жилийн өмнө 2024 оны төсөв 27 их наяд байсныг 30 болгож тодотгосон. 30 болгож тодотгосныг 2025 онд 35 их наяд болгож, 2025 оны төсвийг баталсан. Оруулж ирсэн хүн нь та. Дараа нь Ерөнхийлөгч хориг тавьснаар 32 болгож баталсан. Тэгээд тухайн үед бид нар хэлж байсан.

Энэ аливаа зүйлийг ингээд тэлэх амархан, дараа нь маш олон тооны бизнесийн байгууллагуудаас татвар, иргэдээс татвар авах тэр орон зайг бий болгочихдог. Төр өөрөө маш том худалдан авагч болж хувирдаг. Баахан гэрээ хэлцэл хийчихсэн байдаг. Маш олон тооны иргэдийг одоо хөдөлмөрийн гэрээ байгуулж авсан байдаг. Одоо тэгээд хасах болохоор зэрэг нөгөөдөх нь нэг үзүүрээс нь татахаар нөгөө үзүүр нь гараад ирдэг ингээд баахан хуулиудтай уялдаад явчихдаг. Та хариуцлага үүрэх үү? Энэ эдийн засаг 8 хувийн өсөлттэй байна гээд та наад индэр дээрээсээ хэлж байснаа одоо болохоор хагас жилийн байдлаар эдийн засаг 2.4 хувьтай байна аа гээд энэ тараасан материал дээр чинь байна. За 1 дүгээрт.

2 дугаарт энэ Монголбанкнаас асуумаар байна аа. Энэ төсвийн орлого тасарсантай холбогдуулаад мөнгөний нийлүүлэлт одоо ихэссэн үү, нэмэгдсэн үү, зах зээлд нийлүүлсэн мөнгөний хэмжээ 15 хувь байна аа гээд тараасан материал дээр байна. Энэ дээр свот буюу одоо нөхцөл байдлын шинжилгээ хийсэн үү, тэрийгээ яагаад бид нарт танилцуулахгүй байгаа юм бэ?

Дараагийн дугаарт ер нь энэ төсвийн асуудлыг хуулинд уул нь бол Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд аягүй ойлгомжтой системчилж өгсөн байсан. Тэр системийг авч хаяж байгаад өнгөрсөн жил яг тодотгол хийсэн байхгүй юу даа. Та бүхэн санаж байгаа бол энэний эсрэг хамгийн их дуугарсан нь бол Тэмүүлэн гишүүн байгаа. Та нар энэ төсвийн Үндсэн хуулийг өөрчлөлт орууллаа, хязгааруудыг авч хаялаа, тэгээд одоо тэгээд үр дагаварт нь татвар төлөгчид хохирч байна, мөрөөрөө ажиллаж байсан төрийн албан хаагчид хохирч байна. Бүгд шүүхдэлцэх байх. Их, бага хэмжээгээр. За тэгээд тодруулъя.

Ч.Лодойсамбуу: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

И.Батхүү: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн оны төсвийн тодотголыг Сангийн яамнаас боловсруулаад, Засгийн газар оруулж ирсэн. Ямар нэгэн хувь хүн нэг яам биш тухайн үеийн хүчин төгөлдөр хууль, эрх зүйн орчинд төрийн албан хаагчид ажлаа хийж байгаа. Та бол энэ эдийн засгийн өсөлтийг тухайн үеийн 2024 онд тооцоолж байсан тоонуудыг шүүмжлэлтэй хандаж асуугаад байна лээ. Эдийн засгийн өсөлтийг тооцоолохдоо Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро бусад тоонуудыг нь харах юм бол нүүрсний үнийг 107-132 ам.доллараар 2025 онд тооцож ирүүлсэн. Нүүрсний бодит экспортын биет хэмжээний дүнг 50 сая тонноор ирүүлсэн байгаа. Гэтэл эдийн засгийн одоо бодит гүйцэтгэл өнгөрсөн онд 83.3 сая тонн экспортод гарсан байгаа. Оны эцсээр бол нүүрсний одоо хил үнийн дундаж үнэ бол бас биднүүсийн тооцож байсан үнэ бол тийм байсан. Та өөрөө сайн мэдэж байгаа. Олон улсын геополитикийн болон худалдааны дайны нөхцөл байдал цаг мөч бүхэн өөрчлөгдөж байгаа. Одоо дэлхийд одоо тодорхойгүй байдлын индекс гэж гаргадаг. Энэ индекс бол ковидын үеэс даруй 20 дахин 20 хувиар өндөр гарсан байна. Энэ яг одоо энэ цаг нөхцөл байдалд.

Тэгэхээр биднүүс одоо нэг хувь хүн юм уу, нэг байгууллага бие дааж одоо ирээдүйг бүрэн төлөвлөж тооцоолно гэдэг бол бас худлаа. Бүх олон улсын хөрөнгө оруулалтын банкнууд, судалгааны банкнуудын гаргаж байгаа дэлхийн эдийн засгийн өсөлт тухайн улс орнуудын бүс орнуудын эдийн засгийн өсөлтийн тооцоонууд өөр өөр байдаг аа. Туйлын нэг үнэн байдаг тэрнийхээ төлөө хариуцлага хүлээдэг гэвэл энэ их олон байгууллагуудын мэргэжлийн судлаачдын тооцоонууд яагаад өөр өөр гардаг юм бэ гэдгийг асуумаар байна аа.

Тэгээд нүүрсний үнийг бол одоо биднүүс 70 ам.доллар гэж энэ удаа тооцож байгаа. Энэ 70 ам.доллар гэдэг тооцоо бол бас цаг хугацааны хувьд бас байнга өөрчлөгдөж унаж ирж байгаа. Дөнгөж хоёрхон сарын өмнө 4 сарын үед бол биднүүс бас 2026 оны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах үедээ бас үнийн тухай таамаглалуудыг авч ярьсан. Тэр үед бол одоо Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг 85 ам.доллараар гэж дундаж үнийг тооцоолж байсан байгаа. Биднүүс бол энэ мэдэж байгаа эрсдэлүүдээ тооцоолоод 80 ам.доллар гэж тухайн үедээ тооцоолж байсан. Гэхдээ нөхцөл байдал улам

дордоод одоо 5, 6 сарын үед одоо биднүүсийн хүлээж байсан тодорхой төмөр замын холболт, хөрөнгийн бирж дээрх нүүрсний арилжааны идэвхжил гэсэн ажлууд маань сайн явахгүй байсан. Тэгээд дээр нь олон улсын зах зээл дээр нүүрсний үнийн уналт үргэлжлэн явагдаж байгаа учраас бас биднүүс үнийнхээ тооцоололыг бууруулж байгаа.

Биднүүсийн хамгийн сүүлийн тооцоолол 70 ам.доллар гэдэг маань бас ОУВС-гаас хамгийн сүүлд гаргасан тооцоололтой бас нийцтэй байгаа. Тэднүүсийн зүгээс бол 2025 онд 68 ам.доллар, 2026 онд 73 ам.доллар 70 руу, 2027 онд 72 ам.доллар гэсэн тооцооллуудыг гаргаж байна лээ. Тэгэхээр одоо олон төрлийн макро үзүүлэлтүүдийг аваад дундаас нь аль нэгийг нь таарсангүй гэдэг байдлаар хариуцлага тооцно гэдэг асуудал бас ч боломжгүй байх аа л гэж харж байна.

Ч.Лодойсамбуу: Энд Монголбанкнаас ирээгүй байгаа. Энэ Засгийн газар төсвөө өөрөө бүрэн хариуцах учраас Монголбанкнаас. 2 номерын микрофон.

Г.Энхтайван: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт сүүлийн 10 сарын турш тасралтгүй буурч, 2025 оны 4 дүгээр сарын байдлаар бол 8.9 хувьтай байна. Төлбөрийн тэнцлийн одоо алдагдалтай холбогдуулан гадаад цэвэр активын хэмжээ буурч байгаа нь мөнгөний нийлүүлэлт дээр бол одоо мөнгөний нийлүүлэлтийн хурдац саарахтай одоо саарах үндсэн нөхцөл болж байна аа. Өнгөрсөн жилүүдэд одоо мөнгөний нийлүүлэлт бол хамгийн оргил үедээ жишээлбэл 2024 оны 2 дугаар улиралд 31 хувь хүрч байсан. Тухайн үед мөнгөний нийлүүлэлтийн голлох одоо фактор нь бол төсвийн тэлэлт болон зээлийн эх үүсвэр байсан. Зээлийн өсөлт бол бас харьцангуй мөнгөний нийлүүлэлттэйгээ уялдаад бол суларч байна. Энэ оны 4 дүгээр сарын байдлаар бол зээлийн өсөлт 31 хувьтай байна. Бүтцийг нь харах юм бол хэрэглээний зээлийн хурдац бол харьц...

Ч.Лодойсамбуу: Пүрэвдаваа гишүүн тодруулъя.

Д.Пүрэвдаваа: За нөгөө 1.6 их наяд төгрөг хэрвээ нүүрсний үнэ хэлбэлзвэл нөгөө баялгийн сангаас ордог нөгөө 3 сан гээд нэг ийм үнэ тогтворжуулалтын нөгөө сан байгаа биз дээ тиймээ. Тэгээд энэ асуудлаас болоод бид нар бол төсвөө тэлэхэд ямар ч асуудал эрсдэлд орохгүй ээ гэдэг байдлыг та бүхэн илэрхийлж байсан шүү дээ. Одоо тэрийгээ мартчихаад байна л даа. Нэмээд хэлэхэд тийшээ тэр санд нэмэгдээд орлого орно оо. Одоо Санжаадорж дарга санаж байгаа байх. Одоо энэ 4 номер дээр сууж байна шүү дээ. Нүүрсний үнэ унахад энэ төсвийн тэлэлт ямар ч нөлөө үзүүлэхгүй ээ гээд яг энэ индэр дээр сууж байсан шүү дээ. 1.6 их наяд санд байгаа, нэмээд тэр санд мөнгө орж ирнэ, энэ хэлбэлзэлд бид нар өртөхгүй ээ гэж байсан. Одоо өртчихөөд байна аа. Тэгээд энэ ажлаа дутуу дулимаг хийсэн асуудал дээр ер нь хүн хариуцлага хүлээж байсан...

Ч.Лодойсамбуу: Хэн хариулах вэ? 4 номер.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя аа. Одоо болбол манай Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар болбол бид нар 4 тусгай шаардлагыг болбол мөрдөж байгаа. Нэгдүгээрт бол тэнцвэржүүлсэн үнээр одоо төсвийн орлогыг тооцно гэж байгаа юм. Энэ нь өөрөөр хэлэх юм бид нар болбол өнгөрсөн 20 жилийнх 20 дахь, 19 дэх, 18 дахь жилийн дундаж үнэ, тухайн жилийн дундаж үнэ, тэгээд ирэх 3 жилийн дундаж үнийг Олон улсын байгууллага буюу ОУВС-аас зарласан үнээр

бол тооцно гэж байгаа юм. Нүүрсний үнэ бол зэсийн үнийг болбол бид болбол яг энэ аргаар болбол тооцоод гаргаад ирчхэж байгаа. Хэрэвзээ тэнцвэржүүлсэн үнээс буюу бидний тооцсон одоо тэр тэнцвэржүүлсэн үнээс зах зээлийн үнэ давсан тохиолдолд бол энийг бол Тогтворжуулалтын санд бол хадгалах хуультай. Тэгээд үнээс болсон одоо хямралын үед бол энийг зарцуулах ийм дүрэм бол үйлчлээд явж байгаа. Одоо бол үлдэгдэл нь 1.8 их наяд төгрөг байгаа. Тогтворжуулалтын санд бол.

Ч.Лодойсамбуу: Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Алга байна. Гишүүд үг хэлж дууслаа. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батболд гишүүн уншиж танилцуулна аа.

17:40

Ч.Лодойсамбуу: За дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Алт 3 аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье ээ.

Ажлын хэсгийг танилцуулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Жавхланбаатар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологи уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Өнөрнасан. Ажлын хэсгийг оруулаарай.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.11 дэх хэсэгт заасны дагуу гишүүд тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асуух боломжтой.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу. Нэрээ өгье. Алга байна. За зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гарах санал дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батболд уншиж танилцуулна аа.

17:43

Ч.Лодойсамбуу: Дараагийн асуудалдаа оръё.

Зээлийн хүүг бууруулах талаар авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболдыг ажлын хэсгээс боловсруулсан тогтоолын төслөө танилцуулахыг урьж байна. Гишүүний микрофоныг нээе.

Л.Соронзонболд: Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.3.6 дахь заалт Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас Тогтоох нь:

Нэг. Зээлийн хүүг бууруулах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монголбанканд даалгасугай.

1.Эх үүсвэрийн өртгийг бууруулах зорилгоор банкны системийн тухайн хугацааны дундаж хүүгээс өндөр хүүтэй хугацаатай хадгаламжийн заавал байлгах нөөцийн хэмжээг өсгөх зохистой харьцааг тогтоох асуудлыг судлан шаардлагатай зохицуулалт хийх.

2.Банк болон банк бус байгууллагын гадаад зах зээлээс татсан валютын эх үүсвэрийг үндэсний мөнгөн тэмдэгтэд хөрвүүлэх зардлыг бууруулах.

3.Бизнесийн зээлийн эх үүсвэрт ноогдох заавал байлгах нөөцийг бууруулах.

4.Арилжааны банкнууд эрсдэл багатай зээлдэгчид олгох зээлийн хүүгийн түвшин тогтоож, тогтмол хугацаанд нийтэд мэдээлэх.

5.Зээлийн шимтгэл хураамж тооцсон бодит хүүг тухай бүр зээлдэгчид мэдэгдэж нийтэд мэдээлэх.

6.Монгол Улсад гадаадын банк үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд гадаадын банкны салбар байгуулах, үйл ажиллагаа эрхлэх нөхцөл шалгуурыг шинэчлэх боловсронгуй болгох.

Хоёр.Зээлийн хүүг бууруулж банкнаас бусад санхүүгийн салбарыг хөгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Санхүүгийн зохицуулах хороонд даалгасугай.

1.Банк болон банк бус санхүүгийн байгууллагууд хөрөнгийн зах зээлээр дамжуулан эх үүсвэр татахад дэд бүтцийн байгууллагатай холбогдох зардал, хугацааг бууруулах.

2.Банк бус байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг тогтоохтой холбоотой шаардлага шалгуур нь эх үүсвэрийн зардлыг нэмэгдүүлж байгаа асуудлыг судалж төв болон орон нутгийн нөхцөл байдалд нийцүүлэн ялгамжтай тогтоох.

3.Зээлийн хүүгийн дээд хязгаарыг бизнесийн хэрэглээний болон бусад зээлийн бүтээгдэхүүн тус бүрээр төрөлжүүлэн судалж, санал боловсруулан танилцуулахыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус даалгасугай.

4.Зээлийн үнэлгээг үл хөдлөх эд хөрөнгийн барьцаанд тулгуурлан тооцох өнөөгийн аргачлалыг судалж сайжруулах санал боловсруулан танилцуулахыг Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус даалгасугай.

5.Тогтоолын хэрэгжилтийн явцыг 2025 оны 11 дүгээр сард багтаан Улсын Их Хуралд танилцуулахыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд даалгасугай.

6.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна аа.

Ч.Лодойсамбуу: Соронзонболд гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Монголбанкны дэд ерөнхийлөгч Энхтайван, Санхүүгийн зохицуулах хорооны дарга энэ нэр зөв үү тиймээ. Жамбаажамц, Монголбанкны Банк санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Мөнх-Ундарга, Санхүүгийн зохицуулах хорооны ББСБ-ын газрын дарга Итгэлсүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны Хууль эрх зүйн хэлтсийн дарга Мөнх-Оргил, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Дөлгөөн ирсэн байна.

За одоо тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Мандхай гишүүнээр, Бадамсүрэн гишүүнээр, Эрдэнэбат гишүүнийг нэмье. Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Одоо Бадамсүрэн гишүүн асуултаа асууя.

М.Бадамсүрэн: Монголбанкнаас асууя. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд зааснаар Ирээдүй өв сангийн хөрөнгө 3.9 их наяд төгрөгийг бодлогын хүүгээс багагүй хувиар хүүг тооцож одоо гадаадын банк санхүүгийн байгууллагад өр ... гэсэн заалт байгаа. Тэгэхээр 1 дүгээрт энэ Ирээдүй өв сангийн хөрөнгө хэдэн төгрөгийг ямар ямар банкнуудад, хэдэн хувийн хүүтэйгээр хэдэн жилийн хугацаатай хадгалж, ямар одоо үр шим, хүүгийн өгөөж бидэнд оногдож байгаа вэ нэг.

2 дугаарт нь Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангуудаас энэ зээлийн одоо эх үүсвэр буюу дотоодод одоо зээлийн эх үүсвэрийн дутагдалтай байгаа учраас энийг одоо дотооддоо гаргаж хөрвүүлэхэд хууль эрх зүйн болоод бусад бодлогын шинэчлэл хийхэд Монголбанкнаас ямар байр суурь баримталж байгаа вэ? Тухайлбал Ирээдүй өв сангийн одоо хуримтлагдсан хүү, өссөн энэ хүүг хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэл рүү одоо яг Ирээдүй өв сангийн агуулгаар нь шийдвэрлэх ямар одоо судалгаа ийм тооцоолол санал байна аа та бүхэнд.

Тэгэхээр надад бол хуулийн заалт бол тайлбарлаад хэрэггүй. Энийг бол би бүрэн уншихсан байгаа. Ирээдүй өв сангийн тухай хуулиар 2030 он хүртэл энэ хөрөнгийг арвижуулна гээд заачихсан байгаа. Тэрийг мэдэж байгаа. Энэ хуульд өөрчлөлт оруулж энэ мөнгийг одоо дотооддоо эргэлтэд оруулах боломж байгаа юу?

Дараагийнх нь хуримтлалын сангийн хөрөнгөөр ипотекийн зээлийн эх үүсвэр болгож ашиглаж байгаа. Энэний талаар маш одоо товчхон мэдээлэл. Энийг цаашид яаж өөрчлөх санал байгаа вэ.

3 дугаарт нь энэ дотоодод одоо зээлийн эх үүсвэр дутагдалтай байгаатай холбогдуулаад ямар одоо, хаанаас, аль одоо эх үүсвэрээс улсын төсвөөс гадна Үндэсний баялгийн сангаас бусад эх үүсвэрээс яаж одоо дотоодын ялангуяа энэ хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр одоо бодлого авч

хэрэгжүүлэхээр тооцож байгаа вэ? Ингэхгүй бол үндсэндээ ингээд одоо зээлийн хүүг бууруулах энэ тогтоолын төслийг одоо хэлэлцэж байгаатай холбогдуулаад энэ одоо ажлын хэсэг бол ажилласан байна. Тодорхой одоо саналуудаа гаргаж, дүгнэлтээ дэвшүүлсэн байна. Өөрсдөөс одоо шалтгаалах зүйлүүдээ энэ тогтоол дээр тусгасан байна. Гэхдээ энийг амь оруулдаг зүйл нь энэ зээлийн эх үүсвэрийг ялангуяа хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг яаж нэмэгдүүлэх вэ? Тэгэхгүй бол энэ бизнес эрхэлье, аж ахуй эрхэлье гэсэн одоо жирийн иргэд жирийн одоо монгол өрх айл энэ одоо өндөр хүүтэй зээлийн дарамтад бүр орж дууслаа. Одоо тухайлбал банк бусын зээл маш өндөр байна. За энэ дээр ямар...

Ч.Лодойсамбуу: За хариулъя. 6 номерын микрофон.

Г.Энхтайван: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя аа. Сүүлийнх нь асуултаас эхлээд хариулаад явчихъя. ББСБ-аас банкнуудтай харилцаж байгаа харилцааг зохицуулсан Төв банкны ерөнхийлөгчийн тушаал гарсан. Энэхүү тушаалаар банкны одоо зээлийн багцад ББСБ-ын авч байсан зээлийг бол дахиж нэмж олгохгүй байхаар бол тушаал гаргаад, одоо арилжааны банкнуудаас, банкнуудад банк бусуудад эх үүсвэр олгож, тухайн одоо тийм дамжуулан зээлийг бол хийхгүй ээ. Энэ дээр бол зогсоосон гэж ойлгож болно. Тэр энэ хөнгөлөлттэй эх үүсвэртэй холбоотой асуудал бол энэ бол хэд хэдэн хөнгөлөлттэй эх үүсвэртэй буюу одоо хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл бол хэрэгжиж байгаа. Дийлэнх нь бол Засгийн газрын татаастай зээлүүд байгаа. Төсөв дээрээ суулгаад төсөв дээрээ татаастай буюу зээлийн хүүг нь дэмжлэгийг нь тавиад тэгээд арилжааны банк өөрийн эх үүсвэрээр олгож байгаа. Түүнээс биш Төв банкны зүгээс ямар нэгэн хэлбэрээр төсвийн шинж чанартай санхүүжилт хийж, арилжааны банкнуудаар дамжуулж ямар нэгэн салбар дэмжсэн үйл ажиллагаа бол явуулахгүй ээ. Энэ бол хуулиар хориотой.

Ирээдүй өв сангийн хөрөнгө бол Монгол банкн дээрх Ирээдүй өв сангийн валютын дансанд байршдаг. Энэ мөнгийг бол Төв банк өөрийн гадаад валютын албан нөөцийг удирдах хүрээндээ олон улсын санхүүгийн одоо зах зээл дээр байршуулж явдаг. Энэ дээр бол дийлэнхдээ АНУ-ын Холбооны Нөөцийн банкны одоо санхүүгийн хэрэгслүүд болон одоо Хятад, АНУ-ын Засгийн газрын бондуудыг бол худалдаж авч байршуулдаг аа.

Хуримтлалын болон хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийг төр төрийн ба одоо Монголбанкн дахь Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулдаг. Үүн дээр бол хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд бол бодлогын хүүгээс багагүй хэмжээний хүү тооцож явж байгаа. Хуримтлалын сангийн хөрөнгө гэдэгт бол өнгөрсөн 2024 оны 5 дугаар сард бол 497 тэрбум төгрөг шилжиж орж ирсэн байгаад байгаа. Энэ дээр бол иргэн бүрийн одоо өөрийнх нь дансанд байгаа хэмжээнд нь тухайн үеийн бодлогын хүүгээр бол хүү тооцогдоод явж байгаа. Энэ мөнгийг бол хуульд заасны дагуу ипотекийн зээлийн санхүүжилтүүд бол зарцуулсан байгаад байгаа юм.

Ер нь бол Үндэсний баялгийн сангийн хуулиар энэ мөнгийг хэрхэн зарцуулах тухай нарийн зохицуулалтыг бол хуулиар зааж өгсөн. Одоогийн байдлаар бол мөнгөн хөрөнгийг зөвхөн ипотекийн зээлийн санхүүжилтэд л зарцуулаад байна. Яг одоогийн байдлаар бол үндэсний одоо баялгийн сангийн хуримтлалын санд нэмж одоо үндэсний баялгийн санд төсөв төвлөрүүлж мөнгөн хөрөнгө төвлөрүүлж байгаа Эрдэнэс Монгол болон бусад одоо уул уурхайн ААН-үүдээс бол мөнгө одоогоор орж

ирээгүй юм байна. Энэ оны 9 дүгээр сард Үндэсний баялгийн сан дээр бол 2025 оны санхүүжилт орж ирнэ ээ гэсэн хүлээлттэй байгаа.

Ер нь бол төв банк зээлийн хүү бууруулахдаа бол илүү уян хатан байж одоо хууль хяналтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эх үүсвэрийн зардлыг бууруулах чиглэлээр зээлийн хүүг тодорхой түвшинд хүргэж бууруулах тийм боломжтой гэж үзэж байгаа. Гэхдээ энэ дээр бол мэдээж бодлогын арга хэмжээнүүд авна. Тэгэхдээ бас нэг зүйлийг нэмээд хэлэхэд зээлийн хүү гэдэг маань нэг талдаа төгрөгийн худалдан авах чадвар байдаг. Худалдан авах чадвар байдаг буюу монгол төгрөг хэр ямар үнэ цэнтэй байгааг нөгөө талаараа илтгэдэг. Тэгэхээр бас зохиомлоор механик аргаар хадгаламжийн хүү болон зээлийн хүү эх үүсвэрийн хүүг механик аргаар бууруулах юм бол энэ нь эргээд инфляц болон төгрөгийн худалдан авах чадварт бол маш сөргөөр нөлөөлдөг. Тэгэхээр энэ дээр бол бид бүхэн бол яг тийм тохируулгатай бодлогын арга хэмжээ авч ажиллана аа гэж бол төлөвлөж байна аа.

Ч.Лодойсамбуу: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Би нэг яг тодорхой 3 асуулт асууя. Яг энэ зээлийн бодит өртгийг арилжааны банкнуудын тооцож байгаа аргачлалууд дээр ер нь дүгнэлт хийж үзэж байгаа юмнууд байна уу? Ямар зардлууд энэ одоо зээлийн хүүд илүү их одоо өндрөөр нөлөөлж, банкны эрсдэлийг нэмэгдүүлээд, зээлийн одоо бодит өртөг буюу энэ бас хүүгийн одоо байдал ийм өндрөөр тогтоогдоод байна вэ? Энэ дээр Монголбанк ямар бодлогын арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт яг энэ арилжааны банкн дахь иргэдийн хадгаламжийн ер нь дундаж хугацаа хэд байна? Хэт бас богино хугацаатай энэ зээлүүдийг маш өндөр хүүгээр авчхаад энэ зээлийн хүү дээр ер нь хэрхэн яаж авч байгаа нь бас энэ зээлийн хүүг бууруулахад бас нөлөөлж байна уу, үгүй юу? Энэ дээр ямар дүгнэлт байна вэ?

За дээрээс нь энэ арилжааны банкнуудаас ББСБ ломбардуудад зээл олгож байна гэсэн. Сүүлдээ ингээд арилжааны банкнууд нь зээл олгохоо болиод энэ ББСБ ломбардуудаар дамжуулж өндөр хүүлэх байдалтайгаар эрсдэлгүйгээр авч байна гэсэн ийм мэдээллүүд яваад байгаа юм. Энэ хэр бодитой вэ? Ер нь зүгээр энэ арилжааны банкнууд дахь ББСБ ломбардад олгосон зээлийн хэмжээ хэд байна аа, давтамж хэр байна аа энийг нэг хариулаадхаач.

Тэгээд дээрээс нь одоо нэг зүйлийг хэлмээр байна. Энэ ипотекийн зээл дээр жишээ нь зээлийн хүүгийн бодит өртөг нөлөөлж байсан хураамжийг авахаа больсон. Энэ шүүхийн шийдвэрүүд гарсан. Энэ яг хэрэгжиж байгаа юу? Бас иргэдээс одоо чадан ядан ч юм уу одоо хомс маш хүрэлцээгүй байгаа ипотекийн зээлээс бас олгож байгаа зээлийн нэг хувийг ингээд банкны хураамж гээд бас авчаж байна уу? Цалингийн зээл дээр бас тэгээд л авчаж байгаа юм. Ер нь энэ одоо хураамжуудын асуудал ч байдаг юм уу, энэ зээлийн одоо бодит өртөг дээр нөлөөлж байгаа энэ асуудал дээр ер нь ямар ямар одоо бодлогууд байна вэ? Ер нь шүүхийн шийдвэрүүд хэрэгжиж байгаа юу энэ дээр нэг хариулаадхаач.

Тэгээд эцэст нь ингэе. Төр бас хэмнэх гээд үзэж байдаг энэний дундуур нэг сугарч байгаа юм нь Монголбанк өөрөө. Одоо яг бас Энхтайван ерөнхийлөгчийг хариулж чадах байх гэж бодож байна. Монголбанк ямар хэмнэлт хийх гэж байгаа вэ? Наад 700 орон тоотой албан тушаалд хэдийг цомхотгох гэж байгаа юм?

Өнөөдөр Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүрэг нэмэгдсэнийг би ойлгож байгаа. Мөнгө угаах терроризмтой санхүүжих чиглэлээр. Монголбанкн дээр бас яг одоо бас харьцангуй гайгүй байгаа шүү дээ. Яагаад өнгөрсөн хугацаанд энэ одоо Монголбанк ингэтлээ данхайчлав аа? Энэ 700 албан тушаалтан тийм хэрэгцээтэй байгаа юу? 700 албан тушаалтны чинь хамт чинь бараг 6, 7 оффис байгаа гэж сонссон. Энэ өндөр барилгаас чинь гадна. Энийг хэзээ хэмнэх юм бэ?

Ч.Лодойсамбуу: За Энхтайван Ерөнхийлөгч хариулъя. 6 номерын микрофон.

Г.Энхтайван: Зээлийн хүүгийн эх үүсвэрийг үгүй ээ зээлийн хүүг хэрхэн одоо батлах бодох аргачлалыг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар баталдаг. 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хамтарсан тушаалаар зээлийн хүүг хэрхэн тооцох вэ гэдэг аргачлалыг бол баталсан байгаад байгаа. За бүтцийг нь харахаар зээлийн хүүгийн 48 хувийг эх үүсвэрийн зардал эзэлж байгаа. 48 хувийг буюу энэ тоо урьд нь бол 60 орчим хувьтай байсан. Одоо бол бас харьцангуй буурч байна. За 48 хувьтай байна. Эрсдэлийн зардал 21 хувьтай байна. Ингээд нийлээд бол хамгийн голлох үндсэндээ бараг 70 орчим хувь нь зөвхөн эрсдэл зээлийн хүүн дээрээ явж байгаа. Үйл ажиллагааны зардал 17 хувьтай байгаад байгаа.

Зээлийн хүү ерөнхийдөө бол нэг иймэрхүү бүрдэлтэй байгаад байгаа. Тэгэхээр зээлийн хүүг бууруулахад бид бүхэн бол арилжааны банкны эрсдэлийн хүүг эрсдэлийг багасгах зах зээлийн одоо суурь дэд бүтцийг сайжруулах замаар одоо үйл ажиллагааны зардлыг бууруулах чиглэлд нь бол төв банк бол ажиллаад явж байгаа. Эх үүсвэрийн зардал дээр бол би бас түрүүн хэлсэн. Тодорхой механик байдлаар хэрвээ хандах юм бол энэ эргээд төгрөгийн худалдан авах чадвар дээр нөлөөтэй учраас энэ бол маш эмзэг сэдэв байгаад байгаа юм.

За Мачуритигийн хувьд зээлийн одоо арилжааны банкн дээр эх үүсвэрийн хадгаламжийн хувьд бол 1.4 жилтэй байгаад байгаа юм. Манай дунд чинь дийлэнх одоо хадгаламж эзэмшигч нар маань бас урт хугацааны хадгаламж байршуулж тийм сураагүй тийм зан төлөвтэй байна. Одоо манай улс чинь 1992 оноос л хойш иргэд банкн дээр хадгаламж байршуулж сурлаа шүү дээ. Тэгээд бас энэ бол хугацааны явцад бол илүү уртсах болов уу гэж бодож байна. Тэгэхдээ арилжааны банкны хувьд бол эдийн засгийн макро эдийн засгийн суурь нөхцөл байдал, эдийн засгийн одоо бусад үзүүлэлтүүдээсээ хамаараад бас урт хугацааны эх үүсвэр олоход бол хүндрэлтэй байгаад байгаа. Жилийн одоо дундаж инфляцыг төв банкны хувьд бол 6 дээр нэмэх, хасах 2 буюу 8 хувь орчимтой тогтворжуулна гэж тооцож байхад бол түүнийг урт хугацаанд хадгаламж татаж, түүгээрээ урт хугацааны зээл олгох нь арилжааны банкнуудын хувьд бол бас болзошгүй эрсдэлийг тооцоход бас хүндрэлтэй байгаа.

Тэгэхээр бол инфляцыг дунд хугацаанд тогтворжуулах ханшийн тогтвортой байдал нь өөрөө эргээд урт хугацаатай эх үүсвэрийг татаж, урт хугацаатай эх үүсвэрийг бүрдүүлэх бол үндсэн суурь болоод байгаа юм. Тэгэхээр бид бүхний бодлогын арга хэмжээ бол инфляцыг дунд хугацаандаа тогтворжуулахад бол чиглэгдээд явна аа.

Гишүүний дараагийн асуулт дээр бол бид бүхэн энэ арилжааны банктай холбоотой ББСБ-аар болон ломбардаар дамжаад байгаа зээл дээр бол Төв банк,

Санхүүгийн зохицуулах хороо 2 бол хамтраад шалгалт хийсэн. Шалгалтын үр дүнгээр бол арилжааны банкнаас бусад одоо зээл олгож байгаа байгууллагууд бол ломбард ББСБ-д ямар нэгэн хэлбэрээр эх үүсвэр олгохыг бол Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар бол зогсоосон байгаа. Дахиж бол одоо яг энэ дээр бол банкнууд ББСБ-д эх үүсвэр өгдөг асуудал бол байхгүй болно.

Гишүүний дараагийн асуудал асуулт чинь энэ шүүхийн шатанд хэрэг хянан шийдвэрлэх, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх процесс бол бас удаан явж байгаа. Зарим зээлийн одоо маргааны асуудал 7 хүртэлх жилээр явж байгаа. Ингээд их хэмжээний зээлийн эргэн төлөлттэй холбоотой хугацаа ингээд олон жилээр шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд явахаар эргээд энэ зээлийн хүүгийн зардлыг нэмэгдүүлээд байдаг буюу муу зээлдэгчийнхээ зээлийг сайн зээлдэгч нь төлөөд байдаг. Ийм одоо тэгш бус гэх юм уу, шударга бус гэх юм уу ийм асуудал бол байгаа. Энэ дээр бол бид бүхэн бас хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох энэ шүүхийн бус зарчмаар энэ зээлийн одоо маргаантай холбоотой асуудлыг шийдвэрлэдэг ийм практиктай байхгүй бол болохгүй байгаад байгаа.

За гишүүн тэр Төв банкны ажилтнуудтай холбоотой, зардалтай холбоотой асуудлыг хөндлөө. Монголбанкны хяналтын зөвлөл саяхан 2025 оны 1 дүгээр сард томилогдсон байгаад байгаа. Хяналтын зөвлөлөөс төв банкны бүтэц орон тоо, төсөв, зардалтай холбоотой бол шалгалтыг бол хийж явж байгаа. Одоогоор бол арай дуусаагүй байна. Ерөнхийдөө энэ шалгалтын дүнгээр төв банкны ажилтан, албан хаагчдын давхцал, үүрэг функцийн одоо илүүдэл нэг албан тушаал дээр ажиллах одоо боломжтой позишн дээр хэдэн хүн ажиллаж байгаа гэх мэтчилэн нарийвчилсан дүгнэлтүүд гарна. Нарийвчилсан дүгнэлтүүд гарахаар Төв банк мэдээж бусад одоо төрийн байгууллагуудтайгаа ижил нийцтэй байдлаар өөрсдийнхөө төсөв орон тоон дээр хэмнэлтийг хийнэ ээ.

Ч.Лодойсамбуу: Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Би уг асуудлаар Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн дагуу асуулга тавьсан байж байгаа юм. Асуулт асуусан байж байгаа. Бичгээр хариулна биз. Би энэ арилжааны банкнаас ББСБ ломбард руу олгосон зээлийн хэмжээ давтамжийг нэг хариулаач ээ гэсэн шалгалт яваад зогсоосон л гэж хариулаад байх юм. Тийм нууцалдаг мэдээллүүд юм уу.

2 дугаарт энэ шүүхийн шийдвэр гараад энэ зарим зээлүүдийн бодит өртөгт багтаж байсан гэж үзээд байсан боловч шүүх буруу байна аа гэж шийдсэн энэ хураамжуудыг авахыг зогсоосон. Ипотекийн зээл дээр энэ хураамж ер нь зогссон уу? энэ цалингийн зээл дээрээс энэ зогссон уу, эсвэл авдаг юм уу гэдгийг нэг хариулаадхаач ээ гэж байгаа юм.

2 дугаарт энэ өнөөдрийн энэ зах зээл дээр энэ зээлийн хүү чинь өсөөд байдаг энийгээ дагаад Монголбанкны орон тоо ч өсөөд байгаа нь буруу шүү. Тэгээд ер нь заавал та нар хяналт шалгалтыг хүлээж яадаг юм ер нь. Шаардлагатай бол бас энэ арга хэмжээг авах ёстой шүү дээ. Хяналт шалгалт нэг явчихвал бид хэд нэг арга хэмжээ авна даа гэж юу яриад байна аа?

Ч.Лодойсамбуу: Энхтайван Ерөнхийлөгч хариулъя 6 номерын микрофон.

Г.Энхтайван: Яг аль банкнаас банк бусуудад хэдэн төгрөгийн дамжуулан зээл олгосон байна, аль банк бус аль банкнаас хэдэн төгрөгийн зээл авсан байна гэдэг нарийн деталь тоог бол би бол одоо яг цээжээр мэдэхгүй байна. Ер нь бол би танд 650 орчим тэрбум төгрөг бол нийт багцын дүнгээр бол харагдаж байсан. Танд яг дэлгэрэнгүй мэдээллийг аль банкнаас аль банк бус хэдэн төгрөг авсан байна гэдгийг албан бичгээр танд хүргүүлье.

Ипотекийн зээлийн тэр нэг хувийн шимтгэлтэй холбоотой тэр төв банк энэ дээр арилжааны банкнууд дээр бол хяналт шалгалт хийсэн, хэд хэдэн удаа хийсэн, шүүхийн шийдвэр гарсан. Төв банкны ерөнхийлөгчийн тушаал болон одоо холбогдох хууль тогтоомжид байгаа арилжааны банк өөрийн үзүүлсэн одоо зээлийн үйлчилгээндээ шимтгэл авахыг бол хуулиар зохицуулж өгсөн байгаад байгаа. Нэг хувь гэдэг хэмжээг үүнээс хэтрүүлэхгүй байх ёстой гэдэг тийм зохицуулалттай байгаад байгаа юм. Тэгэхээр арилжааны банкнууд өөрийн олгож байгаа аливаа төрлийн зээлээс нэг хувийн шимтгэл авч байгаа.

Ч.Лодойсамбуу: Санхүүгийн зохицуулах хорооны дарга Жамбаажамц. 9 номерын микрофон.

Т.Жамбаажамц: Сайнзориг гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье. Санхүүгийн зохицуулах хороо 2025 оны 3 сарын 20-ны өдөр энэ банк санхүүгийн байгууллагуудын зохистой харьцаа, эх үүсвэр татах харьцаан дээр бол тодорхой бодлогын нэлээдгүй томоохон өөрчлөлтүүд орсон. Итгэлцэл татах хувь хэмжээ, бонд гаргах, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, гадаадын болон дотоодын банк санхүүгийн байгууллагуудаас эх үүсвэр татах ийм зохицуулалт дээр бол нэлээдгүй томоохон бодлогын шийдвэрүүд гаргасан. Түүнээс гадна энэ өр орлогын харьцаа, барьцаа хөрөнгө үнэлгээний харьцаан дээр ч мөн өөрчлөлтүүд оруулаад ингээд хэрэгжүүлээд явж байгаа. Үүний нэг томоохон одоо бодлогын өөрчлөлт бол энэ дотоодын арилжааны банкнуудаас болон мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс банк санхүүгийн байгууллагууд ямар нэгэн хэлбэрээр эх үүсвэр татах, зээл авахыг хориглочихсон байж байгаа. Тухайн үед Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр гаргахад нийтдээ нэр бүхий арилжааны 10...

Ч.Лодойсамбуу: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Гадаа нэг хэдэн хөгшчүүд хөөрхий тэгээд нэг зээл авах гэсэн хүүг нь өсгөөд, хэмжээг нь багасгаад ингээд л одоо нэлээн л урт үргэлжилж байна даа нэг.

Тэгэхээр энэ хүмүүсийн асуудлыг чуулган дээр Энхтайван Ерөнхийлөгч бас эргээд хэвэнд нь оруулах гэж байгаа гээд байсан. Тэгээд дорвитой бас нэг шийдэл гарсангүй гэж би харж байгаа юм. Ахмадуудын зээлийг аваад үзэхээр нэг үр хүүхдэдээ өгсөн, ингэсэн тэгсэн яам, Засгийн газраас нэг ийм санал ирүүлээд энийг хязгаарласан гэж яриад байсан чинь сүүлдээ Засгийн газар нь буцаагаад татчихсан чинь Монголбанк яг л нөгөө гаргаж байгаа шийдвэртэйгээ дорвитой хуучин хэвэнд нь оруулсан юм бол байхгүй л байгаад байна л даа. Тэгэхээр та хэдийн бас энэ хэлж ярьж байгаа чинь бас зөрөөд байна аа гэдгийг бас 1 дүгээрт хэлмээр байна.

2 дугаарт энэ ахмадуудын чинь зээл авч байгаа, цалингийн зээл авч байгаагийн цаана юу вэ гэхээр хүмүүс жижиг, дунд бизнес эрхэлж байна аа. Өрхийнхөө амьжиргааг залгуулж байна аа. Тийм учраас энийг бүгдийг нь аваад

идээд уучихдаг гэдэг байдлаар ерөөсөө асуудалд хэт одоо нэг талын субъект талаас бол харж болохгүй. Монголбанк болон энэ мөнгөний бодлогын хорооныхон дандаа нэг мөнгө санхүү чиглэлийн л хүмүүс байдаг байх. Тэгэхдээ энэ зээлдэгчдийн одоо эрх ашгийг хамгаалж төлөөлж байх энэ институцийг ер нь яаж байгуулмаар юм бэ нэг.

За дараа нь энэ нийт хадгаламж эзэмшиж байгаа хүмүүсийн нийт хадгаламжийн хэдэн хувь нь нийт хадгаламж эзэмшиж байгаа хүмүүсийн хэд нь байдаг юм бэ? Миний одоо олж сонссоноор нийт хадгаламж эзэмшигчийн маш цөөхөн хувь нь нийт одоо хадгаламжийн мөнгөний дийлэнхийг эзэмшдэг үндсэндээ тусгай хэлэлцээр хийдэг тэгээд энэ өөрөө эргээд зээлийн эх үүсвэр буурах боломжгүй байна буюу цөөхөн хүний гарт төвлөрсөн их мөнгийг өндөр хүүгээр одоо банкнууд хадгалж бусдад одоо дамжуулан хүү олгох гэдэг байдлаар эх үүсвэрийн одоо өртөг буурахгүй байна аа гэдэг зүйлийг хэлж байгаа. Банкнууд бол үйл ажиллагааны хувьд бол одоо цахимжаад эргээд бол одоо зардал бол нэлээдгүй буурч байгаа гэж бодож байгаа. Тэгэхээр буцаад л бараг 10, 20 жилийнхээ өмнөх зээлийн хүүгийнхээ хэмжээнээс нэг их олигтой буураагүй л байгаад байна шүү дээ.

Тэгэхээр энэ банкнуудын чинь хэдэн хувь нь гадаадын хувь эзэмшигчтэй юм. Одоо манай зарим банкнууд бол дийлэнх нь гадаад хувь эзэмшигчтэй тэд нар нь мөнгө оруулж ирдэг. Хэрвээ тийм бол бид нар заавал банкаар тэгж байсны оронд гадаадаас хямд эх үүсвэр оруулж ирээд иргэддээ боломжийн төслийн зээлүүдийг нь олговол болдоггүй юм уу.

Дээрээс нь энэ байгууллагууд дээр маш их хэмжээний одоо хадгаламж байж байдаг. Хугацаагүй, хугацаатай. Харилцах данснууд одоо 3 хүртэл л хүү тооцдог гэж байгаа. Зарим харилцах данс бол яг үнэнийг хэлэхэд байгууллагуудын дундаж харилцах дансны үлдэгдлүүд тогтвортой бөгөөд нэлээдгүй бас эх үүсвэрийн хувьд ашиглаж боломжийн байгаад байдаг. Харилцах дансанд тооцож байгаа хүү бага байгаад байхад түүнийг нь ашиглаж олгож байгаа зээлүүд нь өндөр байгаад байна аа. Тийм учраас энэ тал дээр одоо бас тодорхой хариулт мэдээлэл өгөөч.

Ч.Лодойсамбуу: Энхтайван Ерөнхийлөгч хариулъя. 6 номер.

Г.Энхтайван: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Сүүлээс нь эхлээд хариулчихъя. Харилцах дансны хүүгийн 3 хувийн хязгаарыг Төв банкны Ерөнхийлөгч Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар тогтоодог. Сангийн сайдын хамтарсан тушаалаар тогтоодог. 3 хувийн хүү гэдэг маань олон улсын жишиг практикаараа ч тэр, манай өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлаараа ч тэр маш өндөр байна. Дэлхийн дийлэнх оронд харилцах дансанд хүү тооцдоггүй, харилцах дансанд хүүнээс өндөр хүү тооцоод явах юм болбол харилцах данс нээж иргэд, ААН-д санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг арилжааны банк байхгүй болно. Харилцах дансны үлдэгдэл маань тухайн хүний урсгал зардал, урсгал гүйлгээг санхүүжүүлэх зорилготой учраас хэзээ ч бэлэн байдаг. Тийм учраас түүнийг ашиглаж арилжааны банкнуудад зээл олгох нь бол харьцангуй өрөөсгөл ойлголт оо.

ББСБ-аар дамжуулан гарч байгаа зээл дээр бол би түрүүн хэлсэн. Хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж байгаа. Энийг бол зогсоосон байгаад байгаа. Тэтгэврийн зээлтэй холбоотой бол Төв банк 2025 оны 3 сард бол Гэр бүл, нийгмийн хамгаалал хөгжлийн яамнаас ирүүлсэн саналынх нь дагуу шийдсэн. 6 сард хурлаар ч гэсэн мөн яг ирүүлсэн саналынх нь дагуу шийдсэн. Төв банканд дээр Засгийн газар

ямар байр суурьтай байгаа тэрийг Мөнгөний бодлогын хорооноос хурлаараа хэлэлцээд шийдвэрлэсэн байгаад байгаа. Тэтгэврийн зээл гэдэг маань нэг талаараа хэрэглээний зээл, бусад хэрэглээний зээлтэй яг ижил зохицуулалттай байгаад байгаа. Урьд нь 3 сард олгогдсон байсан зохицуулалтаар бүрэн тэтгэврийн доод хэмжээний авч байгаа буюу 689 мянган төгрөгийн тэтгэвэр авч байсан иргэн дунджаар 2.3 сая төгрөгийн зээл авах боломжтой байсан бол 6 сарын зохицуулалтаар 4.5 сая төгрөг болж нэмэгдсэн байгаа.

Бүрэн тэтгэврийн дээд хэмжээнээс давж байгаа иргэн бол энэ дээр 5 аравны, дундаж нь бол 5.2 сая төгрөгийн тэтгэврийн зээл авах боломжтой байгаад байгаа юм. Тэгэхээр одоо арилжааны банкны баланс дээр байгаа нэг тэтгэврийн зээлийн дундаж хэмжээ 6.5 сая төгрөг байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр бол бас харьцангуй бараг өөрчлөлт ороогүй гэсэн үг. Өр орлогын харьцаа 50, 50 гэдэг маань бусад бүх төрлийн цалингийн зээл, хэрэглээний зээлтэй адилхан байгаад байгаа гэсэн үг. Төв банкны зүгээс бол мэдээж бодлогын хүү гэдэг маань өөрөө зээлийн хүүгийн үндсэн суурь. Урьдач нөхцөл байгаад байгаа. Бодлогын хүү маш олон одоо параметрууд дээр үндэслэж тогтдог. Төв банкны мөнгөний бодлогын хороо хараат бусаар хуралдаад бодлогын хүүг бол улирал тутамд тогтоодог. Улирал тутам тогтоохдоо үндсэн нэг л одоо үүрэг функцийг баримталдаг. Үнэ нь энэ бол монгол төгрөгийн тогтвортой байдал буюу иргэдийн төгрөгөөр худалдан авах чадварыг хамгаалах үүднээс.

Тодорхой хэмжээний хүмүүсийн эрх ашгийг хамгаалах гээд бид бүхэн 3 сая иргэний бүгдээрэнгийнх нь эрх ашигт бас халдаж болдоггүй. Хэн нэг нь бага хүүтэй зээл авахаар бусад нь энэ зээлийн өртгийг хувааж төлж байдаг. Тэгэхдээ бид хэд арилжааны...

Ч.Лодойсамбуу: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Би тодорхой бас асуултууд асуусан шүү дээ. Тэр олон улсын жишиг гэж ярих юм бол манай олон улсын банкнуудын зээлийн дундаж хүү хэд байдгийг бол би бас гадарлана аа. Тэгээд 1-д зарим зүйл ярихаараа олон улсын жишиг яриад байдаг зээлийн хүү ярихаар, зарим одоо нөгөө талаас нь ярингуут арай өөрөөр ингээд яриад байдаг эд нараас гайхаад байна.

2 дугаарт тэр хадгаламжийн чинь хэдэн хувийг хэд нь эзэмшээд байгаа юм бэ? Би өөрөөр хэлбэл их хэмжээний одоо хадгаламжтай хүмүүс өндөр хүүг одоо буулгахгүй байх сонирхол байдаг юм биш байгаа юм. Энэ өөрөө нөгөө талдаа зээлдэгчдийн эх үүсвэр болоод байгаа гэдэг дээр би хэлэх гээд байгаа юм. Тэр ахмадын тэр зээлийн хувьд бол яах вэ би хэлээд байгаа нь тэр яг яамны саналаар шийдсэн гэж яг үнэн үү. Энэ хариуцлагатай асуудал шүү дээ. Засгийн газар бол өөрөө юу гэсэн бэ гэхээр за энэ бол бас буруу юм байна аа энийг бол Монголбанк нь өөрөө шийдэг ээ, Засгийн газар бол саналаа буцаагаад авлаа гэдэг үүднээс шийдсэн. Тийм бол наад ахмадуудтайгаа гараад нэг уулзаач ээ Монголбанкных.

Ч.Лодойсамбуу: Энхтайван Ерөнхийлөгч хариулъя.

Г.Энхтайван: Зээлийн хүү харин яаж тогтож байгаа тухай хэлсэн. Олон улсын жишиг жишгийн дагуу ч гэсэн манай зээлийн хүү одоо зээлийн жигнэсэн дундаж хүү 16.1 хувьтай, одоо ипотекийн зээлийн хүү 6 хувьтай байна. Хэрэглээний зээлийн хүү 18.5 хувьтай байна. Дэлхийн зээлийн дундажтай харьцуулбал манайх тэг голоор нь

л явж байгаа. Бас харьцангуй өндөр гэж хэлж ерөөсөө болохгүй. Ипотекийн зээлийн хувьд шүү дээ. Одоо бид бүгдийн жишээ аваад байдаг Америкийн ипотекийн зээлийн хүү манайхаас өндөр байгаа 7.9 хувьтай байгаа. Энэ чинь төгрөг төгрөгөөр биш валютаар илэрхийлэгдэж байгаа шүү дээ. Тэгэхээр зээлийн хүү гэдэг маань нэг талдаа хүртээмж болон одоо эх үүсвэрийн олдоцтой л хамааралтай байгаад байгаа. Зах зээлийнхээ зарчмын дагуу хүү нь нэмэгдээд, буураад явдаг.

Хэрвээ бид бүхэн бизнес эрхлэгчдээ дэмжээд, баялаг бүтээгчдийг дэмжээд экспортоо сайн гаргаад хэрвээ арилжааны банкн дээр эх үүсвэрийн хэмжээ явбал энэ өрсөлдөөний зарчмаар зээлийн хүү буурна. Зээлийн хүүг бол бууруулах тал дээр Төв банк бол тантай санал нэг байгаа. Бүх талд нь бол...

Ч.Лодойсамбуу: Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн асуултаа асууя.

Н.Батсүмбэрэл: Энхтайван дэд ерөнхийлөгчид талархал илэрхийлье, асуултуудад хариулж байна. Сая нөгөө хурал даргалагчийн хэлдгээр бас Ерөнхийлөгч болоорой гэж ерөөе. Энэ Монгол банкны ерөнхийлөгч нь хэн ч билээ, нэг нөхөр байдаг үзэгдэхээ л больсон байна. Амьд юм уу, байгаа юм болов уу бодвол энэ төсвөөс цалин авдаг билүү дээ тэр хүн Монголын татвар төлөгчдийн мөнгөөр цалин авч байж яагаад энэ хуралд ирж асуултад хариулдаггүй юм. Төсөв тодотгол юм эд нар яриад явж байгаа. Хөөрхий муу ажил хийж байгаа 14 мянган төрийн албан хаагчийг хэмнэх гээд яриад байдаг. Дарга нарын дарга болчихсон Монголбанк 270 хүнтэй байсан юм гэнэ лээ. Одоо 700 гаруй хүнтэй болчихсон юм гэнэ лээ. Тэгээд 700 хүнтэй болсон явдал нь бодвол тушаал юм гардаг байлгүй дээ. Монголбанкны ерөнхийлөгч гэж хүний. Тэр үзэгдэж харагддаггүй хүний тэр тушаалыг үзэж харж болох уу? Эдийн засгийн байнгын хороо Монголбанкны орон тоо 270-аас яаж 700 болсныг мэдэж авмаар байна. Үүнийг энд хэдэн онд хэн Ерөнхийлөгч зарлиг захирамж тушаал гаргаж одоо зарлиг гардаг болоод л энд ирдэг байлгүй дээ. Тааллаараа Их Хуралд суудаг, тааллаараа Эдийн засгийн байнгын хороонд суудаг Монголбанкны ерөнхийлөгч хэн гуай, хэзээ ямар зарлиг тушаал гаргаж хүнээ тоогоо нэмсэн юм бэ? Энийг нэг хэлж өгөөч?

700 хүнтэй болсон гэж би сонссон тэгээд бүгдээрээ л тэр ББСБ-тай холбоотой юм шиг байгаа юм. Ингээд одоо энэ мэдээллээр явж байгаа мэдээллээр бол ББСБ-ын хувь эзэмшигч дарга нартай Монголбанк тэгээд бүгдээрээ цаашаа тэрүүгээрээ дамжуулж мөнгө хүүлдэг байж болзошгүй дарга нар. Тэгээд хуралд ирдэггүй ийм юм байна аа. Тэгэхлээр тэр орон тоог яаж яаж нэмснийг мэдэж болох уу? Тэгээд энэ чинь бас дотоод хяналт шалгалтаа та нар явуулдаг юм уу, үгүй юм уу? Ер нь тэгээд эхлээд энэ тоогоо нэг аваадахъя саяны тэр. Тэгээд энэ Лхагвасүрэн гуайн бие хаа зүгээр юм уу? Тэр хурал муралд ирж яагаад болохгүй байгаа юм? Цалин мөнгө авдаг юм бол. Тэгээд цалин авдаг биз дээ энэ чинь одоо. Монголын татвар төлөгчдийн мөнгөнөөс.

Ч.Лодойсамбуу: Энхтайван дэд ерөнхийлөгч хариулъя, 6 номерын микрофон.

Г.Энхтайван: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя аа. Монголбанкны ерөнхийлөгч гадаад улсад ажлын албан томилолттой ажиллаж байгаа. Энэ хугацаанд. Төв банкны хувьд бол өнөөдрийн байдлаар бас 700 орчим ажилтан албан хаагчидтай ажиллаж байна. Яг танд 2012 оноос хойш жил болгон хэд хэдээр нэмэгдсэн, ямар албан тушаал, ямар үүрэг функц нэмэгдсэн тухайн жилд хэдээр нэмэгдсэн гэдэг талаар дэлгэрэнгүй мэдээллийг танд албан бичгээр хүргүүлъя ээ.

Түрүүн Сайнзориг гишүүний асуултад бас дутуу хариулчихлаа. 576.5 тэрбум төгрөг арилжааны банкуудаас банк бусуудад шилжиж очсон юм байна шүү. Тэгээд энийг би бас танд яг аль банкнаас аль банк буст хэдээр очсоныг нь танд дэлгэрэнгүй мэдээллээр хүргүүлье. Хугацааг нь бас би танд 1.4 жилээр бол дундаж нь.

Түрүүний Эрдэнэбат гишүүний асуултад хариулчихъя. Банкан дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль хэрэгжээд нэг хадгаламжийн 20 хүртэлх сая төгрөгийг төрөөс хадгаламжийн даатгалд хамруулан даадаг болсонтой холбогдуулан эх үүсвэрийн төвлөрөл бол маш их саарсан байгаад байгаа. Дийлэнх одоо урьд нь бол хүмүүс ярьдаг байсан шүү дээ. Нэг хадгаламж нийт хадгаламжийн 99 хувийг нийт хадгаламж эзэмшигчдийн нэг хувь энэ тэр эзэлдэг байсан гэсэн. Тийм юм бол байхгүй. Төрөөс мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль батлагдсанаар эх үүсвэрийн төвлөрөл маш их саарсан байгаад байгаа. Нийт хадгаламжийн 40 гаруй хувийг тэр 20 хүртэлх сая төгрөгийн хадгаламж эзэмшигч нар эзэлж байгаа. Танд яг интервалаар нь хэдэн сая төгрөг хүртэл хадгаламж дээрээ тэдэн хувь эзэлж байгаа талаар танд албан бичгээр хүргүүлье ээ.

Ч.Лодойсамбуу: Батсүмбэрэл гишүүн тодруулъя.

Н.Батсүмбэрэл: Энхтайван ерөнхийлөгч өө, тэр саяынхаа тэр юуг мэдээллийг энэ 7 хоногт багтаагаад өгчихвөл сайн байна шүү. Одоо тэгээд энэ Монголбанкны ерөнхийлөгч ирээд тоогоо өөрчлөөд байдаг байдлыг бол цааш нь таслан зогсоох хэрэгтэй. Тэгээд өөрөө ирж 6 хүн байсныг 12 болгочхоод гадаад яваад өгдөг, тэгээд тааллаараа Их Хурлын чуулганд ороод байдаг. Тэгээд Лхагвасүрэн гуай бол одоо ажлаа өгөх хэрэгтэй шүү дээ. Тэгээд энэ Энхтайван гээд ажлаа сайн хийдэг залууд ажлаа өгөөд явчих хэрэгтэй байгаад байгаа юм.

Ч.Лодойсамбуу: Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. Одоо тогтоолын төслийг уншиж танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас Тогтоох нь:

Нэг.Зээлийн хүүг бууруулах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монголбанканд даалгасугай.

Дэд заалт 1.Эх үүсвэрийн өртгийг бууруулах зорилгоор банкны системийн тухайн хугацааны дундаж хүүгээс өндөр хүүтэй хугацаатай хадгаламжийн заавал байлгах нөөцийн хэмжээг өсгөх, зохистой харьцааг тогтоох асуудлыг судлан шаардлагатай зохицуулалт хийх.

Дэд заалт 2.Банк болон ББСБ-ын гадаад зах зээлээс татсан валютын эх үүсвэрийг үндэсний мөнгөн тэмдэгтэд хөрвүүлэх зардлыг бууруулах.

Дэд заалт 3.Бизнесийн зээлийн эх үүсвэрт ноогдох заавал байлгах нөөцийг бууруулах.

Дэд заалт 4.Арилжааны банкнууд эрсдэл багатай зээлдэгчид олгох зээлийн хүүгийн түвшин тогтоож, тогтмол хугацаанд нийтэд мэдээлэх.

Дэд заалт 5.Зээлийн шимтгэл хураамж тооцсон бодит хүүг тухай бүр зээлдэгчид мэдэгдэж, нийтэд мэдээлэх.

Дэд заалт 6.Монгол Улсад гадаадын банк үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд гадаадын банкны салбар байгуулах, үйл ажиллагаа эрхлэх нөхцөл, шалгуурыг шинэчлэх, боловсронгуй болгох.

Хоёр.Зээлийн хүүг бууруулж банкнаас бусад санхүүгийн салбарыг хөгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Санхүүгийн зохицуулах хороонд даалгасугай.

Дэд заалт 1.Банк болон банк бус санхүүгийн байгууллагад банк болон банк бус санхүүгийн байгууллагууд хөрөнгийн зах зээлээр дамжуулан эх үүсвэр татахад дэд бүтцийн байгууллагатай холбогдох зардал хугацааг бууруулах.

Дэд заалт 2.ББСБ-ын дүрмийн сангийн доод хэмжээг тогтоохтой холбоотой шаардлага шалгуур нь эх үүсвэрийн зардлыг нэмэгдүүлж байгаа асуудлыг судалж, төв болон орон нутагт ялгамжтай тогтоох.

Гурав.Зээлийн хүүгийн дээд хязгаарыг бизнесийн хэрэглээний болон бусад зээлийн бүтээгдэхүүн тус бүрээр төрөлжүүлэн судалж, санал боловсруулан танилцуулахыг Монголбанканд, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус даалгасугай.

Дөрөв.Зээлийн үнэлгээг үл хөдлөх эд хөрөнгийн барьцаанд тулгуурлан тооцох өнөөгийн аргачлалыг судалж, сайжруулах санал боловсруулан танилцуулахыг Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус даалгасугай.

Тав.Тогтоолын хэрэгжилтийн явцыг 2025 оны 11 дүгээр сард багтаан Улсын Их Хуралд танилцуулахыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд даалгасугай.

Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай гэжээ.

Энэ тогтоолын төсөлтэй холбоотойгоор Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооноос санал тодорхой саналууд ирсэн. Товчхондоо Монголбанкны санал бол нэг дэх заалтын 1-5 дахь дэд заалтыг хасах гэдэг санал ирүүлсэн. Санхүүгийн зохицуулах хорооноос 2 дахь заалтын 2 дахь дэд заалтыг хасъя гэдэг саналаа буцаан татаж байгаа гэж ойлгосон тийм. Буцаан татаж байгаа юм байна.

Тэгэхээр 1.Монголбанкнаас гаргасан саналтай холбоотойгоор ажлын хэсгийн ахлагч Соронзонболд гишүүн тайлбар хэлэх үү? Энэ Монголбанк юу гаргасан саналдаа тайлбар хэлэх үү эхлээд. Хэлэхгүй юү? Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Тогтоолын төсөлтэй холбогдуулаад Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооноос саналууд ирсэн. Санхүүгийн зохицуулах хорооны удирдлагатай ярилцаад, бас тогтоолын төсөл дээр өөрчлөлт оруулахгүйгээр явъя

гэж бол ярилцсан байгаа. Монголбанкнаас ирүүлсэн саналуудтай бол танилцсан. Тэгээд ажлын хэсгийн хүрээнд бол одоо тогтоолын төсөл дээр заавал өөрчлөлт оруулах шаардлагагүйгээр төсөл тогтоолын төслийнхөө төслөөрөө явах саналтай байна. Энэ дээр бол дэлгэрэнгүй тайлбар хийх шаардлагагүй байх гэж бодож байна тийм ээ.

Ч.Лодойсамбуу: Монголбанк гаргасан саналаа тайлбарлая. 6 номерын микрофон.

Г.Энхтайван: Банк болон ББСБ-ын гадаад зах зээлээс татсан валютын эх үүсвэрийг одоо своп форвард хэлцлээр дамжуулан одоо төгрөгт хөрвүүлэх нь дараах хэд хэдэн эрсдэлтэй. Энэ дээр бол гадаад валютын татсан эх үүсвэрийн ханшийн эрсдэлийг бол Монголбанк бол дийлэнхийг нь бол үүрдэг асуудал үүснэ. Хэрвээ энэ дээр энэ нь эргээд Төв банкны алдагдлыг огцом өсгөөд, төв банкны алдагдал огцом өссөнөөр мөнгөний бодлогын одоо хараат бус байдалд бол сөргөөр нөлөөлдөг. Төв банкны алдагдлыг хуулиараа Засгийн газрын үнэт цаас гаргаж санхүүжүүлэх үүрэгтэй. Энэ нь эргээд эдийн засгийн үйл ажиллагааг хумьдаг, хувийн секторын хөрөнгө оруулалтыг бууруулдаг ийм ийм сөрөг үр дагавартай. Санхүүгийн байгууллагууд хэрвээ энэ заалт орох юм бол гадаад эх үүсвэр дутахдаа ханшийн эрсдэлээ ерөөсөө тооцохгүй. Аль нэг байгууллагад одоо Төв банкандаа 100 хувь найдаад л шууд мөнгө оруулаад ирдэг. Эрсдэлээ одоо бусдад шилжүүлээд ажилладаг ийм схем рүү явах нь байна шүү дээ.

Тэгэхээр энэ нь эргээд бол арилжааны банкнуудын эх үүсвэрийн зардал дээр бол тодорхой хэмжээний дарамт үзүүлнэ. Зах зээлийн хэвийн журмаар явж байгаа голдирлыг бол сааруулна аа гэж үзэж байгаа. Төв банкнаас. Төсвийн ачаалал бас нөгөө талдаа нэмэгдэнэ.

Ч.Лодойсамбуу: Монголбанкны гаргасан саналтай хийсэн тайлбарыг сонслоо. Энэ тогтоолын төсөлтэй холбоотой тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах саналтай гишүүн байна уу? Гараа өргөчих зүгээр. Алга байна.

Тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэгт заасныг үндэслэн Зээлийн хүүг бууруулах талаар авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 77.8 хувиар дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 2 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн боловсруулсан Зээлийн хүүг бууруулах талаар авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд танилцуулна аа.

Ч.Лодойсамбуу: Дараагийн асуудалдаа орёе.

Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал танилцуулна аа. Гишүүний микрофоныг нээе ээ.

О.Батнайрамдал: Эрхэм гишүүддээ оройн мэнд хүргэе. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Монгол Улсад газарт түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэлд төрийн хамгаалалтад байна гэж 28 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний 4-ний 1-ээс доошгүй нь Хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурлын цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна гэж тус тус заасан.

Оюутолгой төслийн асуудал нь нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудал бөгөөд дээрх хуульд заасны дагуу Улсын Их Хурлын нийт гишүүдийн 4-ний 1-ээс доошгүй нь буюу 89 гишүүн энэхүү асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулах санал гаргаад байна аа. Жавхлант, Шивээ толгой стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд Монгол Улсын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, нэмэлт өөрчлөлт оруулж, дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээний 11.3-ын ё-д 7 жил тутам санхүүжилтийн хүүгийн зохистой хэмжээг авч үзэх заалтыг хэрэгжүүлж, 2025 онд багтаан хүүг бууруулах арга хэмжээ авахад Улсын Их Хурлын зүгээс дэмжлэг үзүүлж ажиллах нэн чухал байна аа.

Үүний тулд Монгол Улсын Их Хурлаас Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтлалыг шинжлэн судлан, нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд олон нийтийг тэнцвэрт мэдээллээр хангах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх асуудлаар дагнасан хяналт шалгалт эрчимтэй явуулах, цуглуулсан нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг үр дүнтэй зохион байгуулж, иргэдийг мэдээллээр хангах тайланг Улсын Их Хурлын 2025 оны намрын чуулганы ээлжит хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулах тогтоолын төслийг боловсрууллаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэн хэлэлцэн авч баталж өгнө үү. Баярлалаа.

Ч.Лодойсамбуу: Танилцуулгатай холбоотойгоор үг хэлж, асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Хянан шалгах түр хороо байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолоор Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулсан Оюутолгой бүлэг ордын талбайн хил заагт орших Жавхлант, Шивээ толгой ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг ашиглахад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэх, тэдгээрийн шаардлагыг хангуулах. Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагч талтай 2011 онд байгуулсан нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээний 11.3-ын ё-д зааснаар хөрвүүлэх өдрөөс хойш 7 жил тутамд санхүүжилтийн хүүгийн зохистой хувийг хянан үзэх хугацаа 2025 онд тохиож байгаатай холбогдуулан Оюутолгой төслөөс хүртэх Монголын талын өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас Тогтоох нь:

1.Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг Оюутолгой бүлэг ордод ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр тогтоосугай.

2.Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийн хүрээ хязгаарыг доор дурдсанаар тогтоосугай.

Дэд заалт 1.Жавхлант, Шивээ толгой ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг тогтоож, үнэлгээг тодорхойлсон болон холбогдох бусад баримтуудад үндэслэн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоохтой холбогдуулан хяналт шалгалт хийх.

Дэд заалт 2.Оюутолгой компанийн нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон хувь нийлүүлэгчийн гэрээний санхүүжилтийн хүүгийн хувь, түүнийг олон улсын зах зээлийн жишигт нийцүүлэн бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, холбогдох үр дагаврыг судлан хяналт шалгалт хийх, санал дүгнэлт гаргах .

3.Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Олонхыг төлөөлөн Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал, Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар, Улсын Их Хурлын гишүүн Болормаа, Улсын Их Хурлын гишүүн Зулпхар, цөөнхийг төлөөлөн Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэн, Улсын Их Хурлын гишүүн Ганзориг, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдаваа, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан, Улсын Их Хурлын гишүүн Шижир.

4.Тусгай шалгалтыг иж бүрэн хэрэгжүүлж, тайлан санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэгт заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулахыг Хянан шалгах түр хороонд даалгасугай.

5.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Санал хураалт явуулна гишүүд. Ингээд энэ хар аа. Монгол Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгээс ийм албан бичгээр нэрсээ ирүүлсэн байна аа. 6 дугаар сарын 30-ны өдөр. За бүлгээс ирүүлсэн нэрсийг энэ тохиолдолд уншиж өгөхөөс өөр шаардлагагүй, одоо аргагүй юм байна.

Монгол Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг, Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж ч танаа. 2025 оны 6 дугаар сарын 30, 98 тоотын бичиг ирүүлсэн.

Санал хүргүүлэх тухай. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, 33.5 дахь хэсэгт заасны дагуу Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянах шалгах түр хорооны бүрэлдэхүүнд МАН-ын бүлгээс дараах гишүүдийг орох саналыг хүргүүлж байна аа.

Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд санал болгож байгаа гишүүд нь тус асуудалд ашиг сонирхлын зөрчилгүй болно оо. Гишүүд Батнайрамдал, Баярбаатар, Бат-Эрдэнэ, Бадамсүрэн, Зулпхар, Болормаа. Хүндэтгэсэн бүлгийн дарга Бат-Эрдэнэ гэжээ.

Манай Монгол Улсын Их Хурал дахь АН-ын бүлэг саналаа ирүүлсэн. Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд оруулах тухай. Мөн 6 дугаар сарын 30-нд ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, 33.5 дахь хэсэгт заасны дагуу Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Жаргалан, Бямбасүрэн, Шижир нарыг оруулах саналыг хүргүүлж байна аа.

Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд санал болгож байгаа гишүүд нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5 дахь хэсэгт заасны дагуу тус асуудалд ашиг сонирхлын зөрчилгүй болно. Бүлгийн дарга Цогтгэрэл.

Мөн Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдалаагаас Байнгын хороонд ирүүлсэн бичиг байна. Энэ бол 6 дугаар сарын 27-нд ирсэн бичиг байна. Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд оруулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх Түр хороо байгуулах тогтоолын төслийг боловсруулан өргөн барьсан байна аа.

Уг Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, 33.5 дахь, 33.2-оос 33.5 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал дахь Хүн намын зөвлөлийн зүгээс Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийг дэвшүүлж байна аа. Улсын Их Хурал дахь Хүн намын зөвлөлийн зүгээс Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5 дахь хэсэгт заасны дагуу дээр дурдсан Түр хорооны тусгай шалгалттай холбоотой асуудлаар ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзсэн болно оо. Иймд бидний хүсэлтийг хүлээн авч Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийг дээр дурдсан Түр хорооны бүрэлдэхүүнд оруулах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж өгнө үү. Улсын Их Хурлын гишүүн Найдалаа гэсэн бичиг байна.

Мөн Үндэсний эвслээс ирсэн бичгийг уншиж танилцуулах ёстой юм байна. Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж танаа. Үндэсний Эвсэл 6 дугаар сарын 30-нд ирүүлсэн санал хүргүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, 33.5 дахь хэсэгт заасны дагуу Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд Үндэсний эвслээс Монгол Улсын Их Хурлын гишүүн Үндэсний эвслийн удирдах зөвлөлийн гишүүн Пүрэвдавааг оруулах саналыг үүгээр хүргүүлж байна. Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүний санал болгож байгаа гишүүн нь тус асуудалд ашиг сонирхлын зөрчилгүй болно оо. Хүндэтгэсэн Үндэсний эвслийн удирдах зөвлөлийн гишүүн нарийн бичгийн дарга Төмөр гэсэн байна.

За ингээд бүлгүүд албан ёсоор ирүүлсэн учраас энэ ажлын хэсэг хорооны бүрэлдэхүүн ингэж гарч байгаа юм байна аа. За санал хураана. Батболд гишүүний микрофоныг өгье.

Р.Батболд: Уул нь энэ их том ажлын хэсэг гэж ойлгоод байгаа юм. Тэгээд энэ Их Хурал дээр 5 нам байдаг уул нь, 5 нам байдаг юм. Заримдаа болохоор хамтраад засаг барихаараа цөөнх болоод, цөөнхийнхөө үүргийг бас давхар гүйцэтгээд явдаг. Та нарт бүлэг байхгүй ээ гээд байдаг юм. Одоо ингээд өөрсдөө засгаас гарчихаараа бид нар цөөнх шүү дээ гээд ингээд ороод байдаг. Нөгөөх нэг яам авсан нь болохоор та нар хамтарчихсан шүү дээ гээд ингээд нөгөө ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтахгүй юм байна лээ гэдэг чинь одоо юу гэсэн үг юм бэ Батнайрамдал гишүүн ээ. Энийг нэг тайлбарлаад өгөөч.

Энэ чинь одоо Улсын Их Хуралд суудалтай 5 намын нэг нь шүү дээ. Нэг намын төлөөлөл шүү дээ. Энийг одоо багтахгүй юм байна лээ гэдэг тайлбар чинь яг юу гэсэн үг юм. Энийг нэг тайлбарлаад өгөөч. Энэ чинь одоо хэдэн гишүүнтэй юм. Үгүй ээ одоо тэгээд энэн дотор сууж байгаа гишүүд нь хүртэл мэдэхгүй гайхчихсан. Гэнэт оруулж ирээд л уншаад л ингээд болдог ийм бүтэц бүрэлдэхүүнтэй эдийн засгийн тэгээд байнгын хорооноос ийм юм гарах гэж байгаа бол наадах чинь манайх бүлэг байхгүй шүү дээ. Та нар дандаа нэг ийм юм ярьж байдаг. Тэгээд юм ярихаар танай бүлэг гээд л ярьдаг. Үгүй ээ бүлэг байгуулах эрхийг нь өгчих л дөө. Манайх 4-ийн 4 гишүүн байгаа тийм. Үгүй ээ нээрээ. Тэгээд ядаж санал тавьсан юм уу, манай тэгвэл намын даргад ядаж хэн орох юм бэ гэж санал тавьсан юм уу? Арай жоохон тийм.

Ч.Лодойсамбуу: За ингээ. Ер нь болбол Батболд гишүүний хэлж байгаа зөв зөвлөл эвслүүд бас ингээд мэдээллээ саналаа ирүүлсэн байна. Тэгэхээр одоо төслөө энэ төслөө тогтоолоо батлаад, баталсны дараа бүрэлдэхүүнд танайхаас саналаа өгөөд нэмээд орчхож болох юм байна. Тэгээд тогтоолдоо өөрчлөлт оруулаад, ингээд л болно тийм үү? Болно.

За ямар ч байсан эхлээд. Одоо саналаа хураая. Тэгээд саналаа хураагаад ямар ч байсан баталсны дараа Түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл гаргаад, өөрчлөлт оруулаад нэмээд явчих юм байна аа. Энэ боломжтой юм байна. Одоо хаагдаад бүх юм байхгүй болох гэж байгаа хэрэг биш байна. Тэгэхээр одоо санал хураалт явъя.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлуулахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураая аа. Санал хураалт. Санал хураалтад бэлдье.

Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалт явуулж дууслаа. Хуралдаанд оролцсон гишүүдийн 72.2 хувиар тогтоолын төсөл дэмжлээ.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гарах санал дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал танилцуулна аа.

Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэг дууслаа.

18:43

Ч.Лодойсамбуу: Дараагийн асуудалдаа оръё.

Нэг асуудал хэлэлцэхээр үлдсэн байгаа гишүүд ээ. Ганцхан асуудал хэлэлцээд дууслаа.

Монгол Улсын дунд богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц, тайлагналтын талаар Эдийн засаг хөгжлийн яамны мэдээллийг хэлэлцэж эхэлье. Танилцуулгыг Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү танилцуулна аа. 2 номерын микрофоныг өгье.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү танилцуулга хийе ээ. Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдсанаас хойш Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулж, Засгийн газар, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаж байгаа.

Энэ хүрээнд саяхан батлагдсан Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай хууль, хуулийн дагуу Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрыг Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын харьяанд шилжүүлсэн байгаа. Энэ шилжүүлэхтэй холбоотой Эдийн засаг, хөгжлийн яамнаас байгаа хууль тогтоомжийн хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилтийн үнэлгээ, явцыг нь хянах ажлыг сайжруулах талаар тодорхой санаачилгууд гарган ажиллаж байгаа. Тухайлбал дизайн, мониторинг, эволюшн гэж ярьдаг. Хөгжлийн бодлого төлөвлөлтийг төлөвлөлтийн шатнаас нь өгсүүлээд гүйцэтгэл, санхүүжилт, хэрэгжилтийнх нь одоо гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлттэй нийцүүлж үнэлэх, эцсийн одоо явцынх нь үр дүнтэй холбогдуулаад засаж, сайжруулах арга хэмжээг эргэх холбоотойгоор авч хэрэгжүүлэх энэ тогтолцоог бүрдүүлэхээр хичээж ажиллаж байна аа.

За яг одоо байгаа хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүрээнд бол одоо энэ асуулгад ирүүлсэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийн асуудлыг Эдийн засаг, хөгжлийн яамнаас явцын одоо үнэлгээг нь хийгээд, тэрийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлдэг байгаа. Одоогийн хуулиар бол 7 сарын 1 гэхэд энэ асуудлыг хуулийн дагуу танилцуулахаар зохицуулагдсан байдаг. Биднүүс бол цаашдаа одоо шинэчлэх гэж байгаа шинэ тогтолцооныхоо хүрээнд энэ хөгжлийн бодлого төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналтын тогтолцоог нэгдсэн байдлаар, цогц байдлаар цахим системээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, боловсруулж, ажиллаж байгаа.

Энэ тогтолцоог нэвтрүүлснээр төрийн албаны шат шатын байгууллагууд дээр энэ төлөвлөлтийн баримт бичгүүдийг давхардсан байдлаар цаасаар боловсруулах шаардлагагүй болно. Бүгдийг нь цахимжуулаад гүйцэтгэл хэрэгжилтийн явцад ямар нэгэн тоо, датаны алдаа гарахгүй, гүйцэтгэлийн тоо баримтууд өөрчлөгдөхгүй байдлаар хяналтыг шат шатанд нь сайжруулах. За тэгээд хэрэгжилтийн явцыг шийдвэр гаргагчид бусад хяналтын эрх бүхий байгууллагууд, эрх бүхий этгээдүүд тухай бүр рийл таймаар танилцаж шалгах боломжтой тийм тогтолцоог бүрдүүлэхээр ажиллаж байгаа.

Ч.Лодойсамбуу: Ажлын хэсэг танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Монгол Улсын тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Ням-Осорын Учрал, буруу ажлын хэсэг мөн үү. Ажлын хэсэг байхгүй юу, биш үү тиймээ.

Ажлын хэсгийн мэдээлэлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье өө. За нэрээ өгөөрэй манайхан. Бадамсүрэн гишүүнээр тасаллаа. Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Эдийн засгийн байнгын хорооны мэдээллийг сонссонтой холбогдуулаад тогтоолын төсөл гаргаж, Засгийн газарт чиглэл өгөх ийм одоо саналтай байна. Энэ саналыг бол 2026 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэлэлцүүлэгт бэлдэх үүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооноос байгуулсан 11 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгээс бол санал нэгдэж ингэж оруулж ирж байгаа. Энэ тогтоолын төсөл маань бол 6 заалттай. Ер нь энэ хөгжлийн төлөвлөгөөг одоо хэлэлцүүлэгт бэлдэх үүрэг бүхий ажлын хэсгийг одоо энэ дээр ажиллах явцад бол хэд хэдэн гол зүйл дээр анхаарах шаардлагатай гэж үзэж энэ тогтоолын төслийг бэлдсэн юмаа.

Тэгэхээр энд бол 5 жилийн үндсэн чиглэл Хөрөнгө оруулалтын 5 жилийн хөтөлбөртэй хамт 6 сарын 28-ны дотор өргөн мэдүүлэх ёстой байгаа. Яагаад гэвэл 2021 оны 8 дугаар сарын 28-ны өдөр энэ хугацаа одоо батлагдсан. Тэгэхээр энэ 5 жилийн хугацаа болсон. Энийг бол та бүхэн хуулийн хугацаанд өргөн мэдүүлэх ёстой. Энийг одоо чиглэл өгөх. Хоёрт нь болбол энэ боловсруулалтыг Эдийн засгийн хөгжлийн яам өөрөө одоо манлайлж, зохион байгуулж дараа нь одоо холбогдох яам, орон нутгаас санал авч нэгтгэн одоо зохион байгуулаад ингээд Засгийн газарт танилцуулж, энийг бол өргөн мэдүүлэх энэ одоо зарчмыг одоо хэлбэрэлтгүй мөрдөх ёстой гэдэг энэ одоо чиглэл, мөн энэ одоо жилийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах.

Ер нь одоо дунд, богино, урт хугацааны хөгжлийн бодлогыг боловсруулахад ийм олон талын оролцоог хангаж байх ёстой. Энэ одоо хуулийн шаардлагыг хангуулах ёстой гэдэг зарчим, мөн техник, эдийн засгийн үндэслэл одоо зураг төсөв хийгдсэн нийгэм, эдийн засгийн ач холбогдлоор эрэмбэлэгдсэн ийм одоо төсөл, арга хэмжээ ийм заалтуудыг бол одоо баримталж тусгаж ажиллах.

Мөн одоо төсвийн хүрээний мэдэгдэл зардлын дээд хязгаарыг энэ хөгжлийн одоо жилийн төлөвлөгөөн дээр тусгах эсэх асуудлаар хууль тогтоомжид одоо өөрчлөлт оруулах талаарх саналыг боловсруулах. Мөн одоо санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яамнаас жил бүрийн төсвийн төслийг боловсруулахдаа Эдийн засгийн хөгжлийн яаманд одоо хянуулах буюу тухайн жилийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байсан эсэх талаар дүгнэлт гаргуулж байх. За ийм одоо зохицуулалтуудыг яаралтай энэ цаг мөчөөс эхлэн хэрэгжүүлэх ёстой гэж үзэж байгаа учраас энэ тогтоолын төслийг манай ажлын хэсгээс одоо санаачилсан байгаа юмаа.

Ингээд 6 зүйл заалттай тогтоолын төслийг ажлын одоо Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд бол урьдчилан тараагдсан байгаа. Тэгэхээр та бүхнийг энэ тогтоолын төслийг дэмжиж, баталж өгөхийг хүсье. Тэгээд энэ одоо тогтоолыг Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолыг дэмжиж, санал хураалгаж гаргуулж өгөхийг хуралдаан даргалагчаас хүсье ээ. Баярлалаа.

Ч.Лодойсамбуу: Уг нь ингээд нөгөө асуулт асуух юун дээр шууд горимын саналаа гаргачих шиг боллоо. Ер нь болбол Эдийн засгийн хөгжлийн сайдаас энэ болбол өнгөрсөн 3 дугаар сард хуулийнхаа хугацааны хүрээнд энэ танилцуулгыг хийчихсэн учраас өнөөдөр хийх шаардлагагүй юмаа уг нь гэдэг ийм бичиг уг нь ирүүлсэн юм. Тэгээд өглөө хэлэлцэх асуудлыг батлахын өмнө санал хураасан боловч гишүүдийн олонх нь энийг өнөөдөр сонсъё гэж үзсэний үүдэн дээрээс сонссон.

За ингээд Бадамсүрэн гишүүний гаргасан горимын саналыг шууд санал хураачихъя. Тэгэхээр одоо юу яана. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо Бадамсүрэн гишүүний гаргасан горимын саналаар энэ тогтоолыг Байнгын хорооноос тогтоол гаргах уу, үгүй юу гэдгийг шийднэ. Тэгэхээр Байнгын хорооны тогтоол гаргая гэдэг дээр гаргая гэдэг саналын томьёоллоор гаргахыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалтад гишүүд бэлдье.

Байнгын хорооны тогтоол гаргахыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 72.2 хувийн саналаар тогтоолын төсөл гаргая аа гэж ямар ч байсан шийдлээ.

За одоо тогтоолын төслийг уншиж өгнө. Тэгээд ар дээр нь тогтоолын төсөл дээр саналаа хэлж болно. Горимын саналыг дараа нь хэлж болно. Энэ эхлээд тогтоолын төслөө сонсох юм байна.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын төсөл. Засгийн газарт чиглэл өгөх тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 3.13 дахь заалт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.3 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос Тогтоох нь:

Монгол Улсын дунд богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Эдийн засаг, хөгжлийн яамны танилцуулгатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

1. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл энэ 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдөр дуусгавар болж байгаатай холбогдуулан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 14.4 дэх хэсэгт заасан хугацаанд Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хамт Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасны дагуу улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг үе шаттайгаар шаардлага хангуулан, олон талын оролцоог ханган боловсруулж, эцэслэгдсэн төслийг олон нийтээр хэлэлцүүлж байх.

3. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.1, 6.10.2 дахь заалтын дагуу Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон. Шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон. Хариуцах эзэнтэй техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл арга хэмжээг эрэмбэлсэн байх шаардлагыг бүрэн хангуулах, тухайн жилийн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл, төлөвлөгөө, хяналт шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүдийн уялдааг ханган боловсруулж байх.

4. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд төсөл арга хэмжээг нарийвчилсан байршил, төсөв зардлын дүнтэйгээр тусгах эсэх эсхүл бүсүүдэд болон нийслэлд хэрэгжүүлэх гэсэн байдлаар тусгах эсэх, тухайн салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нийт дүнгээр нь ангилж тусгах эсэх талаар тус тус судлан аль оновчтой хувилбарыг сонгох.

5.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгах төсөвт шаардагдах ажлуудын нийт зардлын дээд хязгаарыг хуулиар тогтоох эсэх, тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэлтэй хэрхэн нийцүүлэх талаар судалж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах эсэх саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

6.Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тухайн жилийн төсвийн саналыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтын дагуу хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглүүлж тус төлөвлөгөөнд нийцүүлэн нэгтгэн боловсруулж, эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулан, төсвийн төслийг өргөн мэдүүлж, нийтэд ил тод мэдээлэхдээ Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээний нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг үндэслэн, эрэмбэ тогтоосон баримт бичгийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх. Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж гэжээ.

Энэ тогтоолын төсөлтэй холбоотой. За гишүүд ээ ингэх юм байна. Сая хэдүүлээ ямар ч байсан Байнгын хорооноос тогтоол гаргая гэдгээрээ санал хураагаад дэмжчихсэн. Ямар нэгэн байдлаар эндээс тогтоол гарна. Яг энэ саяын уншсан төслийг энэ хэвээр нь гаргах уу, үгүй юу гэдгээ одоо санал хураалтаар шийдэх юм байна.

Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолыг баталъя гэдгээр санал хураалт явуулъя.

Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү тайлбар хийнэ. 2 номерын микрофоныг өгье.

И.Батхүү: За тогтоолын төслийн бусад заалт дээр та бүгдийн бүрэн эрх учраас нөгөө дэмжиж байна. Зарчмын хувьд сайжруулах юунууд байгаа шүү. Гол нь 1 дүгээр заалтын цаг хугацаатай холбоотой нэг асуудал байгаад байгаа. Тайлбар хэлэхийг хүсэж байна аа. Энэ 2021 оны 8 сарын 28-нд батлагдсан өдөр нь тэгж яваад байгаа. Түүнээс биш яг энэ 5 жилийн хөтөлбөр байна 2021 оноос эхлээд 2025 оны 12 сарын 31-нд дуусах агуулгатай хөтөлбөр байгаа. Тэгэхээр хуулиараа бол 12 сарын 31-нээс өмнө 2 сарын өмнө буюу 10 сарын 31 гэхэд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр цаг хугацааны зохицуулалттай байгаа юмаа. Тэгээд 8 сарын 28-наар гэхихээр цаг хугацааны хувьд арай зөрүүтэй асуудал үүсээд байгаа учраас энийг бас та бүгд харгалзаж үзнэ үү гэж.

Ч.Лодойсамбуу: Одоо тайлбар байхгүй. Одоо болбол Бадамсүрэн гишүүний 2 горимын санал байгаа. Эхнийх нь бид нар ямар нэгэн байдлаар тогтоол гаргая гэдгээ баталчихсан. 2 дахь нь энэ тогтоолыг батлах уу гэдгээр одоо батлах уу гэдгээр санал хураалт явуулна. Тэгээд энэ санал хураалтын дараа Жаргалан гишүүний горимын саналыг авъя. Одоо болохоор энэ тогтоолыг батлах уу, үгүй юу гэдгээрээ санал хураалт явуулах юм байна. Тэгээд батлахгүй гэх юм бол ирэх 7 хоногт гишүүд саналаа оруулж ирэх 7 хоногт оруулж ирнэ. За Жаргалан гишүүн горимын санал гаргая.

Б.Жаргалан: Хөгжлийн бодлого төлөвлөлтийг сайжруулах Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яамны уялдаа холбоог сайжруулах гэдэгтэй зарчмын хувьд

бол санал нэг байгаа. Гэхдээ Эдийн засгийн байнгын хороо дөнгөж сая тогтоол батлах нь зүйтэй гэсэн санал гаргаад, араас нь шууд нөгөө нэг ийм гишүүд санал өгөх боломжгүйгээр ийм яаруу сандруу байдлаар тогтоол батлах нь бол зохимжгүй гэж үзэж байна аа. Тэгэхээр гишүүдийнхээ саналыг авах тийм хугацаа бүрдүүлээд ажлын хэсгээс тэгээд ирэх 7 хоногийн Байнгын хорооны хурлаар энэ асуудлыг хэлэлцье ээ гэсэн хойшлуулах горимын санал гаргаж байна аа.

Ч.Лодойсамбуу: Ирэх 7 хоногт чуулган хуралдах эсэхийг тэгэхдээ яг энэ нөгөө даргын дэргэдэх зөвлөл шийдэх байх. За одоогийн байгаа гаргасан хуваариар бол ирэх 7 хоногт байхгүй байгаа. Тэгэхээр одоо Байнгын хороо бол хуралдаж болно л доо. Нэгдсэн чуулганы хуралдаан байхгүй л болохоос биш.

Тэгэхээр одоо Жаргалан гишүүний гаргасан горимын саналыг хойшлуулъя гэдэг горимын саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Жаргалан гишүүний гаргасан горимын саналаар тогтоолын төслийг дараагийн Байнгын хорооны хуралдаан хүртэл хойшлуулъя гэдгийг дэмжье гэдгээр санал хураая. Санал хураалт. За тэгье. Саналын томьёоллоо Жаргалан гишүүн тодорхой хэлье протоколд.

Б.Жаргалан: Байнгын хорооноос гаргах тогтоолын төслийг дараагийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх горимын санал гаргаж байна аа.

Ч.Лодойсамбуу: Гишүүд санал хураалтдаа бэлдсэн байгаа. Байнгын хорооноос гаргах тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хорооны дараагийн хуралдаанаар оруулах Жаргалан гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын дунд богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц тайлагналтын талаар Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээлэлтэй танилцаж дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж байна. Хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд, ажлын хэсгийнхэнд баярлалаа.

19:04

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

